



Ханс - Зайдалийн сангийн
Монгол дахь тоологчийн
газар

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ
ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

ЭМХТГЭЛ

АНХНЫ ХЭВЛЭЛ

- ❖ ЗӨВЛӨМЖ
- ❖ ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
- ❖ БУСАД

Улаанбаатар хот
2012 он



Захиргааны хэргийн давж
заалдах шатны шүүх



Ханнс - Зайделийн сангийн
Монгол дахь төлөөлөгчийн
газар

ЭМХТГЭЛ

АНХНЫ ХЭВЛЭЛ

- ❖ *Улсын тэмдэгтийн хураамжийн тухай*
- ❖ *Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчдын эрх зүйн байдлын тухай*
- ❖ *Нэхэмжлэл хүлээн авах, нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгчийн ажиллагааны тухай*
- ❖ *Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримт цуглуулах, үнэлэх шүүгчийн ажиллагааны тухай*

Улаанбаатар хот
2012 он

DDC

....

N- ...

Эрхлэн гаргасан:

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ
ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ**

Шуудангийн хаяг: Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж-211238.

Харилцах утас: 98896414, 98896416

E-mail: appellatecourt@admincourt.gov.mn

Web site: www.admincourt2.gov.mn

Facebook page: [http://www.facebook.com/pages/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх](http://www.facebook.com/pages/Захиргааны_хэргийн_давж_заалдах_шатны_шүүх)

Twitter account: <http://twitter.com/appellatecourt>

Зөвлөмж боловсруулсан:

Ц.Цогт

Д.Батбаатар

А.Отгонцэцэг

Т.Энхмаа

Эмхтгэлийг бэлтгэсэн:

Ц.Цогт

А.Насандэлгэр

М.Цэцэгмаа

Ё.Биндэрьяа

Б.Анхбаяр

© Энэхүү эмхтгэл нь ХБНГУ-ын Ханнс-Зайделын сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын санхүүжилтээр хэвлэгдсэн, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн зөвшөөрөлгүйгээр хэвлэх, олшруулах, худалдан борлуулах болон бусад хэлбэрээр зохиогчийн эрхийг зөрчихийг хориглоно.

Цаасны хэмжээ: B5

Хэвлэлийн хуудас: 10

Хэвлэсэн тоо: 250

"Хөх судар принтинг"ХХК-ийн хэвлэх үйлдвэрт эхийг бэлтгэж хэвлэв.

Анхны хэвлэл

2012 он

ISBN

ГАРЧИГ

Танилцуулга үг

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

- ❖ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай
- ❖ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчдын эрх зүйн байдлын тухай
- ❖ Нэхэмжлэл хүлээн авах, нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгчийн ажиллагааны тухай
- ❖ Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримт цуглуулах, үнэлэх шүүгчийн ажиллагааны тухай

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- ❖ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг байгуулсан тухай Монгол Улсын хууль,
- ❖ Ерөнхийлөгчийн зарлиг, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн тогтоолууд

ГУРАВДУГААР ХЭСЭГ

- ❖ Шүүн таслах ажиллагааны 2011 оны тоон мэдээ /үзүүлэлт/.
- ❖ Шүүн таслах ажиллагааны талаар болон шүүхийн удирдлага, зохион байгуулалтын ажлын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд.
- ❖ 2011 онд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, шүүгчийн туслах нарт зориулсан бүсчилсэн сургалтын тойм

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

- ❖ Гадаадад сургалт, айлчлалаар явсан тухай мэдээ
- ❖ Хэрэг автоматаар хуваарилах програм ашиглах заавар
- ❖ “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим” мэдээлэл
- ❖ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- ❖ Төсөл хэрэгжүүлэх гэрээ
- ❖ Хэргийг илтгэн танилцуулах дараалал
- ❖ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шалгах ажилбар /check list/

ТАНИЛЦУУЛГА ҮГ

1992 оны шинэ Үндсэн Хуулийн хэрэгжилтээс хойш 2004 онд анх Захиргааны хэргийн шүүх байгуулагдаж, 2011 оны 4 дүгээр сарын 01 –ны өдрөөс давж заалдах болон хяналтын шатны шүүх нь бүтцийн хувьд жигдрэн ажиллаж эхэлснээр хүний эрхийн хэрэгжилтийн баталгаа болсон “шүүх байгууллага” нь төрийн бусад эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд эрх зүйн бодит хяналт тавьж ажиллах боломж бүрдсэн, бидний хувьд ч хуулиар хүлээсэн үүргээ чин шударгаар гүйцэтгэхийн төлөө хичээнгүйлэн ажиллаж ирсэн.

Эрхэм танд толилуулж буй энэхүү эмхтгэл нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэмээн “отгон шүүх” –ийн хамт олны 2011 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан болно.

Эмхтгэл хэдийгээр анхан шатны захиргааны хэргийн шүүхийн шүүгч, ажилтнуудад зориулагдсан ч, эрх зүйн энэ салбарт мэргэшин ажиллаж буй бусад хуульчдад хэрэг болохуйц мэдээллийг агуулсан, тухайлбал: тус шүүхийн шүүн таслах ажиллагааны тоон мэдээ, чанарын харьцуулсан судалгаа болон удирдлага зохион байгуулалттай холбоотой мэдээллүүд гэх мэт.

Онцлох зүйл нь, давж заалдах шатны дагнасан шүүх байгуулагдаж ажилласан нэг жилийн хугацаанд хянагдсан хэрэг маргааны төлөв, байдалд тулгуурлан боловсруулсан “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчийн эрх зүйн байдлын тухай”, “Нэхэмжлэл хүлээн авах, нэхэмжлэлийг хүлээж авсан шүүгчийн ажиллагааны тухай”, “Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримт цуглуулах, үнэлэх шүүгчийн ажиллагаа” гэсэн зөвлөмжүүдийг энд багтаасан явдал юм.

Тус шүүх байгуулагдсан цагаас ХБНГУ –ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар шүүгч, ажилтнуудын сургалт, боловсролын асуудалд тусалж ирсэн бөгөөд энэ удаа ч эмхтгэлийг маань хэвлүүлж олон нийтэд хүргэх ажлыг санхүүжүүлж байгаад гүнээ талархаж байна.

Та бүхэн эмхтгэлийн талаар болон манай шүүхийн үйл ажиллагааны талаар саналаа www.admincourt2.gov.mn цахим хуудсаар дамжуулан ирүүлээрэй.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ ЦЭНДИЙН ЦОГТ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2012 оны 3 сарын 15 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад 2011 оны 06 дугаар сарын 09-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орж, эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд төлөх улсын тэмдэгтийн хураамж 70200 төгрөг төлөх болсноор Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан улсын тэмдэгтийн хураамжтай /цаашид “тэмдэгтийн хураамж” гэх/ холбоотой зүйл, заалтуудыг нэг мөр хэрэглэх, нэгдсэн ойлголтод хүргэх зорилгоор Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд **ЗӨВЛӨХ нь:**

Нэг. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч төлөх тэмдэгтийн хураамжийн хэмжээг, харин 7.1.2 дахь заалтад эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд төлөх тэмдэгтийн хураамжийн талаар тусгажээ.

Захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны акттай холбогдуулан гаргах нэхэмжлэлийн шаардлага нь захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой байдгаас захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг мөнгөн дүнгээр үнэлэх боломжгүй.

Хөдөлмөрийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасан буруу халсан буюу шилжүүлсэн үеийн олговор, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.6 дахь заалтад заасан захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, мөн улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагчийн акт /тухайлбал татварын/-тай холбоотой шаардлагуудын тухайд ч тэдгээрийг хууль бус захиргааны акттай холбогдуулан гаргадаг тул тэдгээрийг үнэлэх боломжгүй гэж үзнэ.

1.1. Захиргааны хэргийг хянан шийдвэрлээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасны дагуу тэмдэгтийн хураамжийг хуваарилахдаа нэхэмжлэл бүрэн хангагдсан тохиолдолд хариуцагчаар нөхөн төлүүлж, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд нэхэмжлэгчид буцаан олгохгүй.

Харин нэхэмжлэл эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй учраас захиргааны хэргийг хянан шийдвэрлээд тэмдэгтийн хураамжийг хуваарилахад мөн зүйлийн 56.2 дахь хэсгийг хэрэглэх боломжгүй.

1.2. Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан тохиолдолд тэмдэгтийн хураамжийг хариуцагчаар нөхөн төлүүлнэ. Харин нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болсон тохиолдолд нэхэмжлэгчид хариуцуулбал зохино.

1.3. Нэг хэрэгт хэд хэдэн шаардлагыг нэг болон хэд хэдэн этгээдэд холбогдуулан гаргасан тохиолдолд нэхэмжлэгчээр нэг удаа 70200 төгрөгийг төлүүлнэ.

1.4. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу хамтран нэхэмжлэл гаргасан этгээд тус бүрээр тэмдэгтийн хураамж төлүүлэх шаардлагагүй.

1.5. Хоёр буюу түүнээс дээш этгээдэд холбогдуулан нэгэн адил шаардлага бүхий нэхэмжлэл гаргасныг шүүх хангасан тохиолдолд тэмдэгтийн хураамжийн 70200 төгрөгийг тэдгээр хариуцагч нарт хуваан хариуцуулна.

1.6. Хоёр буюу түүнээс дээш хариуцагчид холбогдуулан тус тусад нь шаардлага гаргасан нэхэмжлэлээс заримыг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд тухайн нэхэмжлэлийн шаардлага хангагдсан хариуцагчаар тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлнэ.

1.7. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлбэл улсын тэмдэгтийн хураамжийг дахин нэмж төлөхийг шаардахгүй. Хэрвээ нэмэгдүүлэхдээ төлсөн байвал Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтад заасны дагуу илүү төлсөн хэсгийг буцаан олгоно.

1.8. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэгт заасны дагуу нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж хэргийг хэрэгсэхгүй болговол тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэгчид буцаан олгохгүй.

1.9. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг болон нэхэмжлэгч,

хариуцагч эвлэрснийг баталгаажуулахдаа тэмдэгтийн хураамжийг хариуцагчид хариуцуулна.

1.10. Шүүхээс Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7-д заасны дагуу захиргааны байгууллага, албан тушаалтнаас дахин шинэ акт гартал уг актыг түдгэлзүүлж шийдвэрлэж байгаа нь хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулж, шинэ акт гаргахыг хариуцагчид даалгаж байгаа тул нэхэмжлэл хангагдсантай адилтган тэмдэгтийн хураамжийг хариуцагчаар нөхөн төлүүлнэ.

1.11. Хариуцагч нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу сөрөг нэхэмжлэл гаргавал тэмдэгтийн хураамжийг ердийн нэхэмжлэлийн адил тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ.

Хариуцагч нь Төсвийн байгууллага, албан тушаалтан бол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтад заасны дагуу сөрөг нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө.

Харин Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-4.1.16-д заасан байгууллага, албан тушаалтан гаргасан бол тэмдэгтийн хураамжийг төлүүлнэ.

1.12. Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасанчлан хэргийн оролцогчийн эрх эдэлж, үүрэг хүлээх тул гаргасан шаардлагынхаа хувьд нэхэмжлэгчтэй нэгэн адил тэмдэгтийн хураамж төлнө.

1.13. Шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу хэргийг нэгтгэсэн тохиолдолд нэг ажиллагаагаар хэргийг нэгтгэн хэлэлцэж байгаатай холбогдуулан хэргийн оролцогчдын болон нэхэмжлэлийн шаардлагын тооноос хамаарахгүйгээр 70200 төгрөгийг нэхэмжлэлийн шаардлага хангагдсан эсэхээс хамаарч нэхэмжлэгч эсхүл хариуцагчид хариуцуулж, илүү төлөгдсөн тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэгч нарт буцаан олгоно.

1.14. Шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгт зааснаар хэргийг тусгаарлаж шийдвэрлэсэн тохиолдолд тусгаарлагдсан хэрэг бүрт нэхэмжлэл хангагдсан эсэхээс хамааруулж хэргийн оролцогчдод тэмдэгтийн хураамжийг хариуцуулж шийдвэрлэнэ.

Хоёр. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-д төсвийн байгууллагын нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхөөр заажээ.

2.1. "Төсвийн байгууллага" гэдгийг Төсвийн тухай хуулийн /2011.12.23/ 4 дүгээр зүйлийн 4.1.34 дахь заалтад зааснаар "батлагдсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.3-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээд" гэж ойлгох бөгөөд үүнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээд болох төрийн байгууллага, албан газрыг хамааруулна. Харин мөн зүйлд заасан төрийн өмчит үйлдвэрийн газрыг төсвийн байгууллагад хамааруулахгүй.

2.2. Шүүх хэргийг хянан шийдвэрлээд нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг болон бүрэн хангасан тохиолдолд хариуцагч болох Төсвийн байгууллага, түүний албан тушаалтнаар тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлнэ.

2.3. Харин төсвийн байгууллага давж заалдах, буюу хяналтын журмаар гомдол гаргахад улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлэхгүй. Учир нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Төрийн эрх бүхий байгууллагаас энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж... гэнэ", Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт "Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохигчоос төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж гэнэ" гэж тус тус заажээ. Тиймээс Улсын тэмдэгтийн хураамжийн тухай 41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтад төсвийн байгууллага анхан шатны шүүхийн үйлчилгээг авах буюу хэрэг хянан шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргахдаа тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөхөөр заасантай нэгэн адил давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үйлчилгээг авах буюу хэргийг хянуулахаар гомдол гаргахдаа тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө гэж ойлгоно.

2.4. Хуульд нэгэнт төсвийн байгууллагын нэхэмжлэл тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөхөөр заасан тул шүүх хэрэг үүсгэх захирамждаа эсхүл тусад нь захирамж гарган тэмдэгтийн хураамжаас чөлөөлж шийдвэрлэх шаардлагагүй, харин шийдвэртээ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3 дэх заалтын дагуу чөлөөлөгдсөнийг дурьдаж байвал зохино.

Гурав. Бусад

3.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлд зааснаар талуудын хэн нэгнийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлсөн, төлөх хэмжээг багасгасан, хугацааг хойшлуулсан, хэсэгчлэн төлүүлсэн нь нөгөө талыг түүнтэй адилтган тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, багасгах, хойшлуулах, хэсэгчлэн төлүүлэх үндэслэл болохгүй.

3.2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52-60 дугаар зүйлд зөвхөн “шийдвэрт” давж заалдах журмаар гомдол гаргах талаар зохицуулсан. Түүнчлэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт “давж заалдах гомдол” гэдэгт зөвхөн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт гаргаж буй гомдлыг хамааруулан хуульчилжээ. Иймд мөн хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д заасан “гомдол” нь үүнд хамаарахгүй тул Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д зааснаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нараас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргахад тэмдэгтийн хураамж төлөхийг шаардахгүй.

3.3. Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хураамжийг нөхөн төлүүлэх, хэсэгчлэн төлүүлэх, төлөх хэмжээг багасгах, төлөх хугацааг хойшлуулах зэрэгт Улсын тэмдэгтийн хураамжийн талаарх хуулийн зохицуулалтыг шүүхийн практикт зөв хэрэглэх талаар өмнө нь Монгол Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас 2003 оны 11 сар, 2006 оны 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд гаргасан зөвлөмж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2011 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн албан бичгүүдийг сайтар судлан ашиглавал зохино.

---oo0oo---

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2012 оны 3 сарын 22 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчдын эрх зүйн байдлын тухай

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг зөв тодорхойлох нь хэргийг үндэслэлтэй зөв шийдвэрлэхэд болон хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдөхөөс сэргийлэх чухал ач холбогдолтой, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон зүйл, заалтыг захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд нэг мөр, зөв ойлгож хэрэглэх зорилгоор **ЗӨВЛӨХ нь:**

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар хэргийн оролцогч нь нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд тэдгээрийн эрх зүйн байдлыг зөв тодорхойлох нь хэргийг үндэслэлтэй зөв шийдвэрлэхэд болон хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдөхөөс сэргийлэх ач холбогдолтой.

Нэг. Нэхэмжлэгч - Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь хэсэгт зааснаар захиргааны хууль бус актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн иргэн, хуулийн этгээд.

Өөрөөр хэлбэл, хууль бус гэж үзсэн захиргааны актыг зааж, уг актын улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэнийг тодорхойлсны үндсэн дээр “зөрчигдсэн эрхээ сэргээлгэх арга замыг нэхэмжлэлийн шаардлага болгон” тодорхойлсноор нэхэмжлэгчийн зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээх эсэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлнэ.

Нэхэмжлэлд дурдсан маргаан бүхий захиргааны актын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн нь тогтоогдохгүй бол нэхэмжлэгчийн эрхийг сэргээх асуудал гарч ирэхгүй, өөрөөр хэлбэл,

нэхэмжлэлийн шаардлагыг хангах, улмаар маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгох¹ нөхцөл бүрдэхгүй гэсэн үг.

Харин нэхэмжлэлийг өөрийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, сэргээх зорилгоор бус, захиргааны байгууллага хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж байна гэж үзэж, эсвэл бусад этгээдийн өмнөөс иргэн, хуулийн этгээд шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь “нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй болон нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд” -ийн нэхэмжлэл гэж хүлээн авахаас татгалзах үндэслэлтэй.

Иймд нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг үүсгэхдээ ч, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж шүүх хуралдаанаар эцэслэн шийдвэрлэхдээ ч маргаан бүхий захиргааны актын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэхийг шалгаж, тогтоох нь шүүхийн хэрэг шалгаж, шийдвэрлэх ажлын гол үндсэн зорилго гэдгийг тэмдэглэж байна.

Хэдийгээр маргаан бүхий захиргааны акт ямар нэг байдлаар хууль зөрчсөн нь тогтоогдсон ч, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй бол шүүх уг захиргааны актыг хууль бус гэж тогтоох, улмаар нэхэмжлэлийн шаардлагыг хангах бодит үндэслэл бүрдэхгүй, учир нь захиргааны хэргийн шүүх гагцхүү нэхэмжлэгч, хариуцагчийн хооронд үүссэн бодитой маргааныг шийдвэрлэх явцад хууль бус захиргааны актыг хүчингүй болгохгүйгээр нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй тохиолдолд маргаан бүхий актыг хүчингүй болгоно.

Тухайлбал, газар эзэмших, ашиглахтай холбоотой маргаанд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэх асуудлыг анхаарах шаардлагатай байдаг.

Жишээ: “А” ХХК өөрийн хууль ёсоор эзэмшдэг газрын зэргэлдээ 12 метрийн зайд орших газрыг бусдад эзэмшүүлсэн Засаг даргын захирамжийг өөрийн орц гарцыг хаасан, мөн нийтийн эзэмшлийн зам талбайг ашиглах эрхийг зөрчлөө гэж шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Энэ жишээний хувьд нэхэмжлэгч, гуравдагч этгээдүүдийн газрын хил зааг тусдаа, газар давхцаагүй, орц, гарцыг хаагаагүй, нэхэмжлэгчийн хувьд гуравдагч этгээдэд эзэмшүүлсэн газрыг ашиглахаас өөр бусад байдлаар нийтийн эзэмшил газар руу зорчих, орж гарах боломжтой бол нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх боломжгүй.

Шүүх маргаан бүхий захиргааны актын хууль зүйн үндэслэлийг шалгах явцад хариуцагч уг актыг гаргахдаа хууль зөрчсөн (жишээ нь: Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд уг газарт эзэмшүүлж болохоор

¹ Шүүхийн гаргах шийдвэрийн төрөл нь нэхэмжлэлийн шаардлагын төрлөөс хамаарна, энд хүчингүй болгуулах нэхэмжлэлийн төрөл дээр жишээ авсан болно.

тусгагдсанаас илүү хэмжээтэй газрыг гуравдагч этгээдэд эзэмшүүлэхээр шийдсэн) нь тогтоогдсон ч нэхэмжлэгчийн хууль ёсны эрхийг ямар нэгэн байдлаар зөрчөөгүй, эрхээ хэрэгжүүлэхэд нь саад тотгор болоогүй бол нэхэмжлэлийг хангах үндэслэлгүй.

Хуулийн этгээд нэхэмжлэл гаргаж буй тохиолдолд шүүхээс хэрэг үүсгэсэн захирамжид нэхэмжлэгчээр тухайн хуулийн этгээдийг тодорхойлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийн эрх зөрчигдсөн эсэх талаар нотлох баримт цуглуулан шалгаж, эцэст нь хэргийг шийдвэрлэхдээ уг хуулийн этгээдийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт хийх ёстой.

Гэтэл шүүхүүд хэрэг үүсгэхдээ “ББ” ХХК –ийн *захирлын* нэхэмжлэлтэй хэрэг, шийдвэрлэхдээ захирлын нэхэмжлэлийг хангах эсхүл хэрэгсэхгүй болгосугай хэмээн шийдвэрлэж (бичиж) байгаа нь шүүх анхнаасаа тухайн хуулийн этгээдийг төлөөлж нэхэмжлэлийн өргөдөлд гарын үсэг зурах эрх бүхий этгээдийг нэхэмжлэгч хуулийн этгээдээс ялгахгүй байгааг харуулж байна.

Тухайлбал: хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох захирал өөрчлөгдөж болно, захирал нэхэмжлэлийн өргөдөлд гарын үсэг зурсан нь захирал нэхэмжлэл гаргаж байгаа бус гагцхүү хуулийн этгээдийг шууд төлөөлөх эрх бүхий этгээд болохынхоо хувьд нэхэмжлэлд хуулиар тавигддаг шаардлагыг хангахын тулд хийж байгаа үйлдэл юм.

Хоёр. Хариуцагч - Захиргааны хууль бус акт гаргаж нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж нэхэмжлэлд дурдсан захиргааны байгууллага, албан тушаалтан нь хариуцагч болно.

Нэхэмжлэгч нь маргаан бүхий захиргааны актыг гаргасан захиргааны байгууллагыг буруу тодорхойлох явдал түгээмэл байдаг бөгөөд хариуцагчаа зөв тодорхойлоогүй тохиолдолд шүүгч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т зааснаар нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар буцаах нь зүйтэй бөгөөд бүрдүүлбэр хангуулах тухай захирамждаа буцааж буй үндэслэлийг тодорхой бичиж, хууль зүйн үндэстэй тайлбарлан, зөвтгөх боломжийг нэхэмжлэгчид олгох нь зүйтэй юм.

Жишээ нь: нэхэмжлэлийн өргөдөлд, хариуцагчийг “Нийслэлийн өмч хувьчлах комиссын дарга Нийслэлийн засаг дарга Ч.М” гэж нэрлэн заасан бөгөөд нэхэмжлэлийн шаардлагыг “Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2011 оны 42 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах” хэмээн тодорхойлсон байна.

Энэ тохиолдолд анхан шатны шүүх дээрх нэхэмжлэлд үндэслэн хэрэг үүсгэсэн захирамждаа “Нийслэлийн өмч хувьчлах комиссын дарга” гэдэг албан тушаалтныг хариуцагчаар татаж, түүнд холбогдуулж хэрэг үүсгэж, улмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчаар оролцуулж байгаа

нь буруу. Учир нь энгийн логик утгаараа нэхэмжлэлийн шаардлага дахь захиргааны актыг гаргасан этгээд нь хариуцагч байх ёстой бөгөөд дээрх жишээний хувьд “Нийслэлийн өмч хувьчлах комиссын тогтоол”- ыг тус комиссын дарга дангаар гаргадаггүй, “комисс” хэмээх хамтын удирдлага бүхий байгууллага бүрэлдэхүүнээр хэлэлцэн гаргадаг.

Харин хуулиар Нийслэлийн засаг дарга уг комиссын даргын албыг хавсран эрхэлдэг бөгөөд уг комиссын шийдвэрийг албажуулж гарын үсэг зурснаараа хариуцагч болохгүй юм.

Тэмдэглэвэл, нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн өргөдөлдөө аль нэг захиргааны байгууллага эсхүл албан тушаалтныг хариуцагчаар нэрлэн зааснаар тэр этгээд хариуцагч болж, хариуцагчийн эрх, үүрэг үүсдэг биш бөгөөд шүүх заавал тэр этгээдийг хариуцагчаар татан оролцуулна ч гэсэн утгаар ойлгохгүй. Гагцхүү хэрэг үүсгэсэн шүүгчийн захирамжид нэрлэн заагдсан этгээд л уг захирамж гарснаар тухайн хэргийн оролцогч болж эрх эдэлж, үүрэг хүлээх үндэслэл бүрдэх юм.

Өөрөөр хэлбэл “хэргийн оролцогч” болох эрх зүйн үндэслэл нь, нэхэмжлэгч, хариуцагчийн хувьд хэрэг үүсгэсэн захирамж, харин гуравдагч этгээд болон хамтран хариуцагчийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулсан захирамж болох юм.

Нэхэмжлэл хүлээн авсан шүүгч хариуцагчийг зөв тодорхойлоогүй нэхэмжлэлийг хүлээн авч нэгэнтээ хэрэг үүсгэсэн бол, мөн хариуцагчаар татагдсан этгээд уг хэргийн жинхэнэ хариуцагч биш болох нь нотлох баримтаар сүүлд тогтоогдвол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар жинхэнэ хариуцагчаар солих ажиллагааг явуулна.

Анхан шатны шүүхүүд дээр дурьдсан жишээтэй адил хариуцагчийг зөв тодорхойлоогүй байхад зөвтгүүлэх, жинхэнэ хариуцагчаар солих ажиллагааг хийхгүй байх, бие даасан хариуцагч, хамтран хариуцагчийн эрх зүйн байдлыг зөв тогтоож, ялгаатай авч үзэлгүйгээр хэргийг шийдвэрлэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн алдаа гаргаж байна.

Жишээлбэл, “СС” ХХК ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Гэтэл Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын гарын үсэг бүхий тусгай зөвшөөрлийг цуцалсан тухай мэдэгдэл түүнд иржээ. Уг мэдэгдлийг хүлээн авсан “СС” ХХК-ийн захирал ГУУКХ-ын тусгай зөвшөөрөл цуцалсан шийдвэрийг эс зөвшөөрч АМГ-ын даргад гомдол гаргасан бөгөөд АТГ-ын дарга гомдлыг хүлээн авах үндэслэлгүй талаар түүнд мэдэгдэж хариуг албан бичгээр өгсөн. “СС” ХХК АМГ-ын даргыг хариуцагчаар тодорхойлон, албан бичгийг хүчингүй болгох нэхэмжлэл гаргажээ.

Тусгай зөвшөөрлийг цуцлах эрх нь Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15-д зааснаар АМГ-ын даргад биш, харин тус газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргад олгогдсон байх тул нэхэмжлэгч тусгай зөвшөөрлийг цуцалсан тухай шийдвэрийг гаргасан эрх бүхий захиргааны албан тушаалтанд холбогдуулан “тусгай зөвшөөрлийг цуцалсан шийдвэрийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлага гаргах нь зүйтэй. Гэвч тэрээр өөрт ирсэн мэдээллийнхээ хүрээнд нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлон хариуцагчийг буруу тодорхойлсон байна.

Шүүх дээрх тохиолдлуудад тусгай зөвшөөрлийг цуцлах эрх бүхий этгээд буюу тохиолдол бүрээс хамаарч тухайн нэхэмжлэл дэх захиргааны актыг гаргасан этгээд нь ямар захиргааны албан тушаалтан болох, эрх бүхий этгээдийн шийдвэрийн талаарх мэдээлэл нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтад байгаа эсэхийг судлан үзэж, нэхэмжлэлийн шаардлагыг болон хариуцагчийг зөв тодорхойлуулах ажиллагааг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасны дагуу хийх шаардлагатай.

Хэрэв нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагаа зөв тодорхойлсон боловч хариуцагчийг тухайлбал, ГУУКХ-ийг биш АМГ-ыг хариуцагчаар тодорхойлсныг шүүх хэрэг үүсгэх үед шалгалгүйгээр, АМГ -т холбогдуулан хэрэг үүсгэсэн бол жинхэнэ хариуцагчийг тогтоож, солих ажиллагааг зайлшгүй хийх шаардлагатай.

Хариуцагчийг солих ажиллагааг нэхэмжлэгчийн зөвшөөрснөөр, нотлох баримт цуглуулахаас өмнө хийнэ. Хэрэв нэхэмжлэгч зөвшөөрөхгүй бол хамтран хариуцагчаар оролцуулна.

Мөн нэхэмжлэгч нь маргаан бүхий актыг гаргасан захиргааны байгууллагыг болон уг актыг эс зөвшөөрсөн гомдлыг захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтныг хамтад нь хариуцагчаар тодорхойлох тохиолдол байдаг. Жишээ нь: Татварын улсын байцаагчийн төлбөр ногдуулсан акт, уг актыг татвар төлөгчийн гомдлоор хянаад “хууль зүйн үндэстэй байна” хэмээн дүгнэсэн Татварын маргаан таслах зөвлөлийн тогтоолыг тус бүр хүчингүй болгуулахаар нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлж, түүнтэйгээ уялдуулан (1) Татварын улсын байцаагч, (2) Татварын маргаан таслах зөвлөл гэсэн 2 этгээдийг хариуцагчаар тодорхойлж ирүүлдэг.

Иймэрхүү тохиолдолд маргаан бүхий актыг эс зөвшөөрсөн гомдлыг захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан нь шинээр үр дагавар үүсгэсэн бөгөөд маргаан үүсгэсэн үндсэн актаас тусдаа шаардлага болж шийдвэрлэгдэх

ёстой өөр захиргааны актыг гаргасан явдал биш, тухайн актыг хянаж гомдолд хариу өгсөн тул энэ хэрэгт хариуцагч болохгүй.

Нэг нэхэмжлэлд хэд хэдэн хариуцагч байж болно. Мөн нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлж байгаа тохиолдолд харилцан хамааралтай асуудлаар эрх бүхий захиргааны албан тушаалтан бие даан шийдвэр гаргасан бол нэхэмжлэгч шинэ хариуцагчийг тодорхойлдог. Энэ тохиолдолд нэхэмжлэгчийн шинээр тодорхойлсон хариуцагчийг шүүгч захирамж гарган хариуцагчаар татаж (хариуцагчаар татаж буй захирамж нь энэ тохиолдолд уг шаардлагад холбогдуулан хэрэг үүсгэж байгаатай ижил агуулгыг илэрхийлнэ), хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.

Тухайлбал, иргэнд газар эзэмшүүлсэн шийдвэр гаргасан дүүргийн Засаг дарга, уг газрыг иргэнд өмчлүүлсэн Нийслэлийн Засаг дарга, өмчлүүлсэн шийдвэрийг үндэслэн газар өмчлөх эрхийг бүртгэсэн бүртгэлийн байгууллага нэг газрын тухайд өөрт олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд бие даасан захиргааны актыг гаргасны хувьд бие даасан хариуцагчид болно. Энэ тохиолдолд дурдсан захиргааны албан тушаалтнууд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөр өөрийн гаргасан захиргааны акт бүрийнхээ тухайд бие даасан хариуцагчаар оролцоно.

Харин захиргааны байгууллага, албан тушаалтнууд эрх хэмжээнийхээ хүрээнд тодорхой нэг асуудлаар хамтран шийдвэр гаргасан бол тухайн захиргааны актыг хууль бус гэж шүүхэд маргаан үүсгэсэн тохиолдолд маргаан бүхий захиргааны актыг гаргасан хамтран хариуцагчид болно. Өөрөөр хэлбэл тухайн нэг шаардлагыг хамтран хариуцах этгээдүүд болно. Жишээ нь, “Шингэрүүлсэн шатдаг хий тээвэрлэх зөвшөөрөл олгох журам” – ыг Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тээврийн газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан тушаалаар баталсан бол уг журмын тодорхой заалтын талаар гарсан маргааны хувьд уг захиргааны актыг гаргасан дээрх захиргааны байгууллагууд нь хамтарсан хариуцагчид болно.

Эдгээрээс үзвэл нэг нэхэмжлэл буюу хэрэгт хэд хэдэн хариуцагч байж болох бөгөөд тэдгээр нь тухайн нэхэмжлэлийн (хэргийн) хувьд хамтран хариуцагч болно, харин нэхэмжлэлийн нэг шаардлагын хувьд зөвхөн тухайн шаардлага дахь маргаан бүхий захиргааны актыг хамтран үйлдсэн этгээдүүд л хамтран хариуцагчаар татагдах боломжтой.

Түүнчлэн шүүхүүд нэхэмжлэгч нь хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлагыг гаргасан атлаа нэг хариуцагчийг тодорхойлсон байхад шаардлага тус бүр нь уг хариуцагчид холбогдох уу гэдгийг тодруулалгүйгээр зөвхөн тухайн хариуцагчид холбогдуулан хэрэг үүсгэх алдааг олонтой гаргаж байна. Энэ нь эцэстээ хэргийг шийдвэрлэхэд хүндрэл учруулж, хариуцагчид

холбогдохгүй шаардлагыг хэрхэх нь тодорхойгүй болох, эсвэл хариуцагчид холбогдохгүй шаардлагыг шүүхийн шийдвэрээр шийдвэрлэх үр дагаварт хүргэж, шүүхийн шийдвэр өөрчлөгдөх, хүчингүй болох үндэслэл болж байгааг анхаарвал зохино.

Тиймээс нэхэмжлэлийн шаардлага тус бүрт хамаарах хариуцагч нь мөн байна уу, шаардлага тус бүрт холбогдох хариуцагчийг нэхэмжлэгч тодорхойлж чадаж уу гэдгийг шалгасны үндсэн дээр хэрэг үүсгэж, хэрэв дутуу бол нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хэрэг үүсгэхээс өмнө хангуулж зохих ажиллагааг цааш явуулах нь зүйтэй.

Гурав. Гуравдагч этгээд – Тухайн захиргааны хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж болзошгүй этгээд бөгөөд захиргааны хэргийн бие даасан оролцогч.

Гуравдагч этгээдийг шүүхийн санаачилгаар, мөн өөрийнх нь болон нэхэмжлэгч, хариуцагчийн хүсэлтээр шүүгчийн захирамж гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авсан даруйд нэхэмжлэлийн шаардлага, агуулга, үндэслэл, түүнд хавсаргасан баримтаас тухайн нэхэмжлэлд үндэслэн хариуцагчийн гаргасан захиргааны актыг шүүх шийдвэрлэхэд өөр аль нэг “гуравдагч” этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй, эсхүл уг маргааныг бүрэн цогцоор нь эцэслэн шийдвэрлэхэд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөр хэн нэгэн этгээдийн оролцоог зайлшгүй хангах шаардлагатай нь тодорхой байвал хэргийн оролцогчдын болон өөрийг нь хүсэлт гарахыг хүлээлгүйгээр шүүх санаачилгаараа уг этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр татан оролцуулж байх нь зүйтэй. Энэ нь хэргийг нэг мөр, бүрэн дүүрэн шийдвэрлэх ажиллагааг шүүгч удирдан явуулах зарчимд нийцнэ.

Гэтэл шүүхүүд дээрх байдал илт байхад гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулах ажиллагааг хийлгүй удаашруулж, улмаар хэргийг хуульд заасан хугацаанд багтаан шийдвэрлэхгүйд хүргэж, шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болж байгааг анхаарвал зохино.

Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд татан оролцуулсан гуравдагч этгээд нь хэрэгт цугларсан нотлох баримтаас хамаарч бие даасан шаардлага гаргах эсэхээ өөрөө шийдэх бөгөөд хэрэв хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “бие даасан шаардлага” гаргавал эрх зүйн байдлыг өөрчлөн бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдээр татан оролцуулахаар шүүгч захирамж гаргах нь гуравдагч этгээд шүүхэд гаргасан шаардлагаа шийдвэрлүүлэхийн тулд хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны явцад эдлэх эрхээ бүрэн хэрэгжүүлэх, шүүхийн шийдвэрээр маргаантай асуудлыг нэг мөр, бүрэн шийдвэрлэхэд ач холбогдолтой.

Зарим тохиолдолд гуравдагч этгээд нэхэмжлэлийн шаардлагаар үүсгэсэн захиргааны хэргийн хариуцагчаас өөр хариуцагчид холбогдуулан шаардлага гаргадаг. Энэ тохиолдолд маргааны үйл баримт нь нэг, зайлшгүй уг хэрэгтэй хамтруулан шийдвэрлэх шаардлагатай гэж шүүгч дүгнэвэл гуравдагч этгээдийн шаардлагаар тухайн хариуцагчид холбогдуулж хэрэг үүсгэн, хамтад нь шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдээр татан оролцуулах шүүгчийн захирамж нь уг шаардлага хариуцагдах этгээдийг тухайн хэрэгт хариуцагчаар татан оролцуулсан, улмаар бие даасан шаардлага дахь захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагааг эхлүүлж байгаа гэдэг утгаараа “захиргааны хэрэг үүсгэх” захирамжтай ижил зохицуулалт агуулж байгаа юм.

Харин бие даасан шаардлага гаргах үндэслэл болсон гэх (эсхүл бие даасан шаардлага дахь) захиргааны акт нь:

- (1) үндсэн нэхэмжлэлийн шаардлага дахь маргаанаас өөр, уг маргааны үйл баримтад шууд хамааралгүй асуудлыг зохицуулсан агуулгатай,
- (2) эсхүл заавал нэг ажиллагаагаар хамтатган шийдвэрлэж байж тухайн “маргаан” шийдвэрлэгдэх боломжтой болохоос бусад асуудлыг шийдвэрлэсэн
- (3) түүнчлэн бие даасан шаардлагын хариуцагч нь үндсэн нэхэмжлэлийн хариуцагчтай адил буюу нэг захиргааны байгууллага, албан тушаалтан байсан ч дээрх 1, 2 –т заасан нөхцлийг хангаагүй тохиолдолд

тухайн хэрэгт шийдвэрлэгдвэл зохиох “бие даасан шаардлага” гэж үзэхгүй, тусдаа маргааны үйл баримт болох тул хамтатган шийдвэрлэх боломжгүй, тусдаа нэхэмжлэл гарган шийдвэрлүүлвэл зохих хэрэг болно.

Жишээ нь: (1) нэхэмжлэлийн шаардлага нь ““АА” ХХК –д газар давхцуулан эзэмшүүлсэн Аймгийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгуулах” байтал энэ хэрэгт гуравдагч этгээдээр татагдсан “АА” ХХК нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “нэхэмжлэгчид уг газарт (нэг ижил байршил дахь тодорхой талбайн хувьд) эзэмших эрх олгосон Сумын Засаг даргын захирамж”-ийг илт хууль бус болохыг тогтоолгох гэсэн шаардлага гаргасан. Энэ тохиолдолд гуравдагч этгээдийн уг шаардлага нь тухайн хэрэгт зайлшгүй хамт шийдвэрлэгдэх нөхцлийг хангасан байх тул энэ хэргийн хувьд “бие даасан” шаардлага болно.

Жишээ (2): нэхэмжлэлийн шаардлага нь ““АА” ХХК–д газар давхцуулан эзэмшүүлсэн Аймгийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгуулах” байтал энэ хэрэгт гуравдагч этгээдээр татагдсан “АА” ХХК нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “нэхэмжлэгчийн гуравдагч этгээдээс авсан зээлийн барьцаан дахь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл”-ийг хүчингүй болгуулах гэсэн шаардлага гаргасан. Энэ тохиолдолд уг шаардлага дахь маргаан нь үндсэн нэхэмжлэлийн шаардлага дахь “маргаан бүхий газрын эзэмших эрх” –тэй холбоотой үйл баримтад шууд хамааралгүй учир тусдаа нэхэмжлэл гарган шийдвэрлүүлвэл зохих хэрэг болно.

Гуравдагч этгээдийн бие даасан шаардлагад нэхэмжлэлийн нэгэн адил бүрдүүлбэр, шаардлага (хэлбэрийн шаардлага, улсын тэмдэгтийн хураамж гэх мэт) тавигдахыг анхаарах нь зүйтэй.

Дөрөв. – Хэргийн бусад оролцогч. Нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж буюу өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж буй этгээд мөн.

Нэхэмжлэгч нь шүүхэд төлөөлөгчөөр төлөөлүүлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бол Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т заасан шаардлага хангасан итгэмжлэлийг шүүхэд гаргаж өгснөөр төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар эрхтэй оролцох нь тодорхой, итгэмжлэлд заасан эрхийн хүрээнд төлөөлж байгааг шалгах боломжтой болно.

Иймд нэхэмжлэгч нь төлөөлүүлэгчдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль үе шатнаас, ямар хугацаагаар, ямар эрхийг олгосон нь бичгээр олгосон итгэмжлэлээс харагдаж, төлөөлөгч нь төлөөлүүлж байгаа этгээдийн олгосон эрхийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа эсэхийг шалгаж байхыг зөвлөж байна.

Итгэмжлэлд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан тодорхой бүрэн эрхүүдийг төлөөлөгчид эдлүүлэхээр тусгайлан заагаагүй бол дурдсан тодорхой эрхүүдийг төлөөлөгч хэрэгжүүлэх хууль зүйн боломжгүй юм.

Гэтэл шүүхүүд хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхгүй болон нэхэмжлэлд гарын үсэг зурах эрхгүй этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэх, эсвэл төлөөлөгчид олгосон итгэмжлэлд ямар эрх эдлэхийг заасныг шалгалгүй, итгэмжлэлд заагаагүй эрх тухайлбал, нэхэмжлэлд гарын үсэг зурах, эвлэрэх, давж заалдах гомдол гаргах зэрэг эрхийг төлөөлөгч хэрэгжүүлсэн байхад түүнийг анхаарч шалгалгүйгээр хэргийг шийдвэрлэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн

алдаа гарч, шүүхийн шийдвэр хүчингүй болох үндэслэл болж байгааг анхаарвал зохино.

Хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдлөө хэмээн нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойлогдсон бол уг нэхэмжлэл нь тухайн хуулийн этгээдийнх байх тул нэхэмжлэлд тухайн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсгээ зурж, тамга тэмдгээр баталгаажсанаар тухайн хуулийн этгээдийн нэхэмжлэл гэж үзнэ.

Иймд нэхэмжлэлд гарын үсэг зурсан этгээд нь мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т зааснаар хуулийн этгээдийн төлөөлөгчөөр оролцох байгууллагын эрх баригчаас өөрийн албан тушаал, эрх хэмжээгээ гэрчилсэн баримт бичгийг шүүхэд гаргаж өгөхийг, мөн бусад ажилтнаас Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т заасан болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан шаардлагыг хангасан итгэмжлэлийг шүүхэд гаргаж өгөхийг шаардан, төлөөлөгчийн бүрэн эрхийг шалгаж байхыг зөвлөж байна.

Гуравдагч этгээд нь нэхэмжлэгчийн нэгэн адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр төлөөлүүлж болох бөгөөд төлөөлөгчийн бүрэн эрх нь нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн дээр дурдсантай нэгэн адилаар хэрэгжинэ.

Харин хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлээр тодорхойлсон захиргааны байгууллага, албан тушаалтныг төлөөлөх учраас төлөөлөгч нь захиргааны албан байгууллага, албан тушаалтны албан ёсны шийдвэрээр томилогдсон байхыг шаардана.

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тодорхой бүрэн эрх нь мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, эвлэрэх, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийг бусдад шилжүүлэх, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг эдлүүлэхээр итгэмжлэлд тусгайлан заасан бол эдгээр бүрэн эрхийг төлөөлөгч хэрэгжүүлж болно.

Хариуцагч захиргааны байгууллага, захиргааны албан тушаалтан өөрийн гаргасан шийдвэрийн улмаас бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн асуудлаар шүүхэд маргаан үүссэнийг мэдэгдэх хуудсаар мэдэж, нэхэмжлэлийн хувийг хүлээн авч танилцаж, хэрхэн үзэж байгаа талаар бичгээр тайлбар гаргах, захиргааны хэргийн шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаж үүргийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай

хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтаар түүнд ногдуулсныг анхан шатны шүүх анхаарвал зохино.

Түүнчлэн төлөөлөгчөөс төлөөлүүлэгчид олгож болох тодорхой бүрэн эрхийг заасан хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт “хариуцагчийн тайлбарт гарын үсэг зурах эрх”-ийг төлөөлөгчид олгох тухай зохицуулалт байхгүй болно.

Гэтэл шүүхүүд хариуцагчийн бичгээр гаргасан хариу тайлбарт төлөөлөгч гарын үсэг зурсан байхад хүлээн авч хуулийн эдгээр заалтыг буруу хэрэглэж, алдаа гаргаж байгааг анхаарвал зохино. Зүй нь нэхэмжлэлд өгөх хариу тайлбарыг тухайн хэргийн хариуцагч албан тушаалтан бол өөрөө, захиргааны байгууллага бол шууд төлөөлөх эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж ирүүлэхийг шаардах нь зүйтэй байна. Энэ талаар давж заалдах шатны шүүхийн 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 1/372 дугаар албан бичигт заасныг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

Өмгөөлөгч нь хууль зүйн туслалцаа авахыг хүссэн талуудын хүсэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйл заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Хуулийн дээрх зохицуулалтаар эрх зүйн туслалцаа авч байгаа тал өмгөөлөгчийн туслалцаа авах хүсэлтээ илэрхийлсэн, хүсэлтэд нэрлэсэн өмгөөлөгчийг хэргийн бусад оролцогч гэж үзэх үндэслэл болох тул илүү зүйлийг шаардах шаардлагагүй, эрх зүйн туслалцаа авч байгаа этгээд өмгөөлөгчийн хамт өөрсдийн биеэр шүүх хуралдаанд хүрэлцэн ирсэн үед хүсэлтийг хуралдааны тэмдэглэлд тусган өмгөөлөгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд албан үүргийн дагуу хөндлөнгийн байр сууринаас оролцож байгаа бусад оролцогчид иргэдийн төлөөлөгч, гэрч, шинжээч, хэлмэрч, орчуулагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хамаарна.

Шүүхүүд шинжээч, хэлмэрч, орчуулагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахдаа эрх үүргийг тайлбарлаж, баримтжуулах, шүүгчийн захирамжаар томилох ажиллагааг хийгээгүй алдаа гаргаж байгааг анхаарч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59, 60 дугаар зүйлд заасан ажиллагааг хуулийн заалт тус бүрийн дагуу хийж байх шаардлагатай.

Жишээлбэл, орчуулагч, хэлмэрчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгчийн захирамжаар томилолгүйгээр оролцуулсан алдаа олонтаа гарсан байна. Шүүн таслах ажиллагаанд орчуулагчаар оролцох этгээд “тусгай зөвшөөрөл” –тэй байх шаардлага байхгүй болсон

ч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасан “орчуулагч, хэлмэрчийг шүүгч захирамж гарган” томилох шаардлага хэвээр байгаа бөгөөд тухайн орчуулагчийн шүүн таслах ажиллагаанд орчуулга хийх эрх нь энэхүү захирамж гарснаар хэрэгжиж эхлэх төдийгүй захирамжаар томилоогүй бол түүний хийсэн орчуулга (хэргийн оролцогчдын мэдүүлэг) нь нотлох баримтын шаардлага хангахгүйд хүрэх сөрөг үр дагавартай.

---oo0oo---

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2012 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Нэхэмжлэл хүлээн авах, нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгчийн ажиллагааны тухай

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Тавдугаар бүлэг дэх нэхэмжлэлийг хүлээн авах, нэхэмжлэлийг хүлээн авсны дараах ажиллагаатай холбоотой зүйл, заалтуудыг захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд нэг мөр, зөв ойлгож хэрэглэх, нэгдсэн практик тогтоох зорилгоор **ЗӨВЛӨХ нь:**

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан хэлбэр, бүрдүүлбэр, агуулгын шаардлага хангасан нэхэмжлэлийг хаягласан шүүхийн нэхэмжлэл хүлээн авах чиг үүрэг бүхий албан тушаалтан буюу шүүхийн нарийн бичгийн дарга хүлээн авч, бүртгэснээр нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргасанд тооцогдоно.

Шүүхийн нарийн бичгийн дарга нь нэхэмжлэлийг хүлээн авахдаа хэлбэр, бүрдүүлбэрийнх нь хувьд шалгаж, нэхэмжлэлд хавсаргасан материалын нэр, хуудасны тоог тулган, хуудасны тоо, огноо, цаг минутыг нэхэмжлэлд тэмдэглэхээс гадна шүүхийн нэхэмжлэлийн бүртгэлд бүртгэн, тогтоосон хуваарийн дагуу шүүгчид шилжүүлэх ажиллагааг хийнэ.

Шүүхэд нэхэмжлэл хүлээн авсан хугацааг баримтжуулж, албан ёсны бүртгэлд бүртгэх хуулийн энэ шаардлага нь нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа, тухайн нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэх, эсхүл хүлээн авахаас татгалзах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг тоолох эхлэл болох учраас зайлшгүй хийгдэх ёстой бөгөөд хууль зүйн үр дагавар, ач холбогдолтой.

Нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэр, агуулгын шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, хуулийн уг заалт дахь шаардлагыг хангаагүй бол гүйцээж, бүрдүүлбэл зохих шаардлагуудыг тодорхой зааж, 7-14 хоногийн хугацаа өгч шүүгчийн захирамжаар буцаана.

Хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгч анх нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэлийн бүрдүүлбэр, агуулгад тавигдах шаардлагыг хангасан байх ёстой ч, хэрэв уг нэхэмжлэлийн агуулгыг

тодруулах, хуульд нийцүүлэх шаардлагатай байвал нэхэмжлэгчийн шүүхэд хандах эрхийг хангах үүднээс шүүхэд нэхэмжлэлийг хүлээн авсны дараа бүрдүүлбэр хангах арга замыг тодорхойлон хугацаа заан буцааж, зөвтгөх боломжийг олгох нь зүйтэй.

Тогтоосон хугацаанд нэхэмжлэгч нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлээгүй бол шүүгч хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт зааснаар захирамж гаргаж, нэхэмжлэлийг нэхэмжлэгчид буцаана.

Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хүлээн аваад Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-34.1.8 дахь хэсгүүдэд заасан “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл” байгаа эсэхийг үндэслэл тус бүрээр шалгалгүй хэрэг үүсгэх, эсвэл татгалзах үндэслэлийг хууль зүйн тодорхой үндэслэл, болон нотлох баримтад тулгуурлан дүгнэж, эргэлзээгүй болголгүйгээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсанаас хуульд заасан журам зөрчсөн алдаа гаргаж байна.

Иймд нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч дээр дурдсан алдааг гаргахгүй байхын тулд хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д тодорхойлсон нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийг эхнээс нь нэгбүрчлэн шалгасны эцэст хэрэг үүсгэх эсэхээ шийдвэрлэх ёстой.

Хэрвээ хэрэг үүсгэсний дараа хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан татгалзах аль нэг үндэслэл илэрвэл хэрэг хянан шийдвэрлэх эцсийн хугацааг хүлээлгүйгээр шүүх хуралдааныг зарлан хэргийг хэлэлцэж, дээрх үндэслэл тогтоогдсон тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж гаргаж болно.

Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах тухай ЗХХШТХ-ийн 34 дүгээр зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудлууд

Нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч нь хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх үндэслэлээр буюу захиргааны хэргийн шүүхийн харьяаллынх мөн эсэхийг тогтоох шаардлагатай. Гэтэл шүүгч нар нэхэмжлэл нь захиргааны хэргийн шүүхийн харьяаллынх биш байхад уг үндэслэлд дүгнэлт өгөлгүйгээр хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасан бусад үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, ноцтой алдаа гаргаж байгааг онцгойлон анхаарах шаардлагатай.

Иймд хэрэг үүсгэж байгаа байгаа бол татгалзах үндэслэл байхгүй болохыг захирамждаа үндэслэл тус бүрээр заавал дүгнэж өгөх нь дээрх алдаа гарахаас сэргийлэх ач холбогдолтой. Ийм байтал хэрэг үүсгэх захирамжид “хүлээн авахаас татгалзах үндэслэл тогтоогдохгүй” гэсэн ерөнхий дүгнэлт хийснээр хэргийн оролцогчдийн хувьд ялангуяа хариуцагч, гуравдагч этгээдүүдийн зүгээс “хүлээн авахаас татгалзах үндэслэл байхад

түүнийг шалгаагүй хэрэг үүсгэсэн талаар” гомдох, зарим тохиолдолд хэрэг үүсгэж, ажиллагаа хийж, хугацаа алдсаны дараа хэргийг хэрэгсэхгүй болгож буцааснаас нэхэмжлэгчээс “татгалзах байсан бол өмнө нь татгалзахгүй, олон өдөр сараар дэмий явуулж чирэгдүүллээ” гэсэн гомдол гаргах үндэслэл болдгийг анхаарч ажиллавал зохино.

Хэрэв татгалзах үндэслэл тогтоогдвол захирамжийн үндэслэлд татгалзах болсон үндэслэлээ ойлгомжтой, тодорхой, эргэлзээгүйгээр тайлбарлан, татгалзсан үндэслэл арилсан нөхцөлд шүүхэд хандах эрх нь нээлттэйг тайлбарлан бичих шаардлагатай. Ийнхүү татгалзсан нь хуулийн энэ заалтын аль нэг үндэслэлд заавал хамаарна, хуульд заагаагүй үндэслэлээр татгалзахгүй.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа эсэхийг шалгах:

Захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр, захиргааны акттай холбоотой бүх нэхэмжлэл болгон захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан гэж үзэж болохгүй юм. Хуульд заасан тодорхой үндэслэлүүдээр захиргааны байгууллага албан тушаалтны гаргасан шийдвэр нь захиргааны хэргийн шүүхэд харьяалагдахгүй байж болно.

Тухайлбал, Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “хуульд заасан бол иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн захиргааны шийдвэр” нь иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл болохоор, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1, 4.2-т зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол” иргэний хэрэг үүсгэх үндэслэл болохоор тус тус заасан байна.

Иймд дээр дурдсан захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэртэй холбогдуулан гаргасан гомдол, нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэхгүй бөгөөд захиргааны байгууллагын шийдвэр нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан “захиргааны акт” мөн үү, эсвэл иргэний эрх зүйн харилцаа үүсгэсэн акт байна уу гэдгийг шүүх ялгаж хэргийн харьяаллаа зөв тогтоох шаардлагатай. Хэрэв захиргааны байгууллагын шийдвэр захиргааны актын шинжийг бүрэн агуулаагүй, нийтийн эрх зүйн харилцааных биш бол хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах маргааны хувьд хариуцагч нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

4.1-д заасан захиргааны байгууллага, албан тушаалтан байхаас гадна нэхэмжлэлийн шаардлагад дурдсан захиргааны акт нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан хэрэг бүртгэх, мөрдөх байцаах, шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаатай холбоогүй, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.2-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд захиргааны хэргийн шүүхийн хэргийн харьяалалд хамаарна.

Жишээ: Иргэн Б-ийн дунд сургуулийн захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцож, хамгийн өндөр оноо авч, төрийн албаны салбар зөвлөлөөс уг албан тушаалд томилуулахаар Сумын Засаг даргад Б-ийн нэрийг Төрийн албаны тухай хуулийн дагуу санал болгосон байхад сумын Засаг дарга сонгон шалгаруулалтын оноогоор Б-ийн дараа орсон, төрийн албаны салбар зөвлөлөөс санал болгоогүй Д-г дунд сургуулийн захирлаар томилсон нь Төрийн албаны хуулийг зөрчиж, нэхэмжлэгч Б-ийн эрхийг зөрчлөө гэж шүүхэд гаргасан нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь “захиргааны журмаар урьчдлан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлээгүй ба энэ журмыг хэрэглэх боломжтой” гэж үзэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

Дээрх жишээнд дурдсан сумын сургуулийн захирлын албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс санал болгоогүй, сонгон шалгаруулалтад эхний байрт ороогүй этгээдийг томилсон маргаан бүхий сумын Засаг даргын захирамж нь Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.1.2 дахь хэсэгт заасан төрийн үйлчилгээний албан тушаал болох Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллуулахтай холбоотой, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь хэсэгт зааснаар Хөдөлмөрийн хуулиар зохицуулагдах хөдөлмөрийн эрх зүйн харилцааг үүсгэсэн акт байна.

Засаг даргын дээрх захирамжийг Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан “иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн захиргааны шийдвэр” гэж үзэх үндэслэлтэй бөгөөд “нийтийн эрх зүйн харилцааны бус” маргаан тул Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх үндэслэлээр хүлээн авахаас татгалзана.

Гэтэл нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх “татгалзах” үндэслэлүүдийг нэг бүрчлэн шалгалгүй, өөрөөр хэлбэл, хамгийн түрүүнд захиргааны хэргийн шүүхийн харьяаллынх мөн үү гэдгээ тогтоосны дараа бусад үндэслэлийг шалгах ёстой байхад уг үндэслэлийг шалгаж тогтоолгүй, 34.1.3 дахь үндэслэлээр татгалзаж алдаа гаргасан байна.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь үндэслэл байгаа эсэхийг шалгах:

Маргаан бүхий захиргааны актыг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтан нь тухайн захиргааны хэргийн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрт оршин байрладаггүй байвал хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Жишээ нь: “Төв аймгийн Заамар сумын хэсэг иргэд уул уурхайн “ДХ” компани малчдын өвөлжөө хаваржааны газарт олборлолт хийх зорилгоор машин тоног төхөөрөмжөө байрлуулан, газрыг ухаж, тэслэх ажил хийсэнтэй холбоотойгоор Төв аймгийн захиргааны хэргийн шүүхэд дээрх уул уурхайн “ДХ” компанийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгож өгнө үү” гэсэн нэхэмжлэл гаргажээ.

Нэхэмжлэлд тусгай зөвшөөрлийн дугаарыг дурдаад, тусгай зөвшөөрлийн дагуу хийж байгаа “ДХ” компанийн үйл ажиллагаа нь Төв аймгийн нутаг дэвсгэрт болж байгаа, уг тусгай зөвшөөрөл нь орон нутгийн иргэдийн өвөлжөө хаваржааны газраа ашиглах эрхийг зөрчсөн тул хүчингүй болгох үндэслэлтэй гэж дурджээ.

Шүүх энэ тохиолдолд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд нь Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс тул нэхэмжлэгчийн хүчингүй болгохоор шаардсан захиргааны актыг гаргасан захиргааны байгууллага нь Нийслэлийн нутаг дэвсгэрт орших тул нутаг дэвсгэрийн харьяаллын хувьд Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд харьяалагдана гэдгийг захирамжийн үндэслэлдээ тодорхой зааж, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Харин нэхэмжлэгчийн хувьд аль шүүхэд нэхэмжлэл гаргахаа сонгох боломжтой тохиолдол байж болно, ийм тохиолдолд нэхэмжлэгчийн сонгож нэхэмжлэлээ гаргасан захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж болохгүй. Тухайлбал, “БГ” ХХК –ийн “байгалын ургамал түүх” үйл ажиллагааг зогсоож, 10 сая төгрөгийн төлбөр ногдуулсан улсын байцаагчийн актыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагч, Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нар хамтран (нэг акт үйлдэж, 2 байцаагч гарын үсэг зурж баталгаажуулсан) гаргажээ.

Хэрэв нэхэмжлэгч хуулийн этгээд уг актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг Дорноговь аймгийн захиргааны хэргийн шүүх эсхүл Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн аль нэгийг сонгон гаргавал тухайн шүүх хүлээн авч хэрэг үүсгэн шийдвэрлэх нь зүйтэй. Харин хамтран

хариуцагчаар нөгөө улсын байцаагчийг татан оролцуулах замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулах боломжтой.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь үндэслэл байгаа эсэхийг шалгах:

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь хэсэгт заасан захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлээгүй гэдэгт хуульд тусгайлан заасан бол тухайн хуульд заасан захиргааны байгууллага, албан тушаалтанд, тусгайлан заагаагүй бол маргаан бүхий захиргааны актыг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны шууд харьяалах дээд шатны байгууллага албан тушаалтанд гомдол гаргаж шийдвэрлүүлээгүй байхыг ойлгох бөгөөд энэ журмыг хэрэглэх боломжтой эсэхийг нэхэмжлэлд дурдсан нөхцөл байдал, нотлох баримтыг үндэслэн шүүх дүгнэлт өгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах эсэхээ шийдвэрлэнэ.

Маргаан бүхий захиргааны актын талаарх гомдлоо хуульд заасан журмын дагуу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлээгүй боловч гомдол гаргах хугацаа нь хэтрээгүй бол шүүх урьдчилан шийдвэрлэх журмыг хэрэглэх боломжтой гэж үзэн нэхэмжлэлийг 34.1.3 дахь үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж болно.

Харин нэхэмжлэгч нь хуульд заасан хугацаанд захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэхээр зохих этгээдэд гомдол гаргасан боловч захиргааны дээд шатны байгууллага, албан тушаалтан 30 хоногийн хугацаанд хянан шийдвэрлээгүй бол нэхэмжлэгч шүүхэд хандах эрхтэй болох бөгөөд шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлгүй.

Түүнчлэн, нэхэмжлэгчийн маргаж буй тухайн захиргааны актыг гаргасан албан тушаалтанд өөрт (урьдчилан) нь хандах хуулийн зохицуулалт, шаардлага огт байхгүй байхад хуулийн 34.1.3 дахь заалтыг илтэд буруугаар тайлбарлан хэрэглэж, өөрт нь хандах замаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагатай хэмээн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж буйг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх журмыг биелүүлээгүй боловч энэ журмыг хэрэглэх боломжтой эсэхийг шүүх дүгнэж, захиргааны хэрэг үүсгэх эсэхээ шийдвэрлэх зохицуулалт энэ заалтад байгаа гэдгийг анхан шатны шүүхийн шүүгч нар анхаарах нь зүйтэй бөгөөд тухайлбал, дүүргийн Засаг даргын захирамжаар иргэнд газар эзэмшүүлсний дараа түүнд үндэслэж, Нийслэлийн Засаг дарга уг эзэмшүүлсэн газрыг өмчлүүлдэг.

Нэхэмжлэгч дүүргийн Засаг даргын захирамжийн талаарх гомдлыг дээд шатны Засаг дарга буюу Нийслэлийн Засаг даргад гаргах ёстой. Энэ тохиолдолд Нийслэлийн Засаг дарга нь нэгэнт өөрийн шийдвэрээр

дүүргийн Засаг даргын газар эзэмшүүлсэн захирамжийг хууль зүйн үндэстэй гэж үзэн, уг газрыг өмчлүүлэхээр шийдвэрлэсэн тул тухайн гомдлыг хүлээн авч дүүргийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгох магадлал багатай бөгөөд шүүх энэ тохиолдолд “захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх журмыг хэрэглэх боломжгүй” гэж дүгнэх боломжтой.

Жишээ: Нийслэлийн Засаг даргын иргэн “Г”-д газар өмчлүүлсэн захирамжийг хүчингүй болгох нэхэмжлэлээр хэрэг үүсгэн шалгаж байх явцад нэхэмжлэгч нь уг газрыг “Г”-д эзэмших эрх олгосон дүүргийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгохыг шаардаж нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлсэн бол уг нэмэгдүүлсэн нэхэмжлэлийн шаардлагыг “урьдчилан шийдвэрлүүлэх ёстой” гэдэг үнэслэлээр хүлээн авахаас татгалзалгүйгээр нэг мөр шийдвэрлэх нь хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалтад нийцнэ.

Мөн хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлагатай хэрэгт нэгэнт уг маргаантай хэргийг шүүхээр хянан хэлэлцэх шатанд байгаа нөхцөлд зарим шаардлагыг нь захиргааны журмаар “урьдчилан шийдвэрлүүлэхийг шаардаж” буцаах нь оновчтой биш бөгөөд, шүүхээр нэг мөр хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй.

Хуульд захиргааны байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлыг дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүхэд гаргаж болох сонгох эрх олгосон тусгайлсан зохицуулалттай бол, мөн дээд шатны захиргааны байгууллага байхгүй бол гомдол гаргагч шүүхэд шууд хандах эрхтэй бөгөөд заавал захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэхийг шаардахгүй, ийнхүү сонгох эрхийн дагуу шууд гаргасан нэхэмжлэлийг шүүх хүлээн авч захиргааны хэрэг үүсгэн шийдвэрлэнэ.

Жишээ: “МТ” ХХК ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалсан Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын шийдвэрийг эс зөвшөөрч, шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Шүүх уг нэхэмжлэлийг татгалзах үндэслэлгүй. Учир нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Ашигт малтмалын тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтаар “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулиар олгосон эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно” гэж гомдлоо хэнд гаргахыг гомдол гаргагчид сонгох боломжтойгоор хуульчилсан байна.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх үндэслэл байгаа эсэхийг шалгах:

Нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээд эрх зүйн чадвар, чадамжтай байхыг мөн хуулийн 17, 18 дугаар зүйлд тодорхойлж заасан бөгөөд хуулийн энэ

шаардлагад нийцээгүй буюу нэхэмжлэл гаргасан этгээд эрх зүйн бүрэн чадамжгүй болох нь захиргааны хэрэг үүсгэхээс өмнө мэдэгдвэл шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй гэдгийг Иргэний хуульд зааснаар 7 хүртэлх насны хүүхдийг болон сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүхээс иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцсоныг ойлгох бөгөөд түүнийг төлөөлсөн этгээд байхгүй бол нэхэмжлэлийг хүлээн авах боломжгүй.

Харин эрх зүйн чадамжгүй этгээдийг төлөөлөх бүрэн эрхтэй этгээд тухайн асуудлаар нэхэмжлэл гаргасан бол шүүх түүний нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэнэ. Энд төлөөлөх бүрэн эрхтэйг нотлох баримт бичиг /эцэг эх, асран хамгаалагч гэдгийг нотлох/ нэхэмжлэлд заавал хавсаргагдсан байх ёстой.

Хуулийн этгээдийн эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болдог тул хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч эрх зүйн чадвартай хуулийн этгээдээс гаргасан эсэхийг нь улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн шалгаж тогтооно. Хэрэв улсын бүртгэлийн гэрчилгээний хугацаа дууссан, татан буугдсан тухай тэмдэглэл, шүүхийн шийдвэртэй бол тухайн хуулийн этгээдийг эрх зүйн чадамжгүй гэж үзэж түүний гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь үндэслэл байгаа эсэхийг шалгах:

Нэхэмжлэгч нь эрх зүйн чадамжтай боловч түүнийг өөр этгээд төлөөлж нэхэмжлэл гаргасан, төлөөлөх бүрэн эрх олгосон тухай баримтгүй бол нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан гэж үзэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана. Түүнчлэн төлөөлөх эрх олгосон итгэмжлэл нь хуульд заасан шаардлагыг хангаагүй, нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийн өргөдөлд гарын үсэг зурах эрхийг тусгайлан олгоогүй бол тухайн этгээдийг нэхэмжлэл гаргах эрх олгогдсон этгээд гэж үзэх боломжгүй юм. Учир нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1-д “нэхэмжлэлийн өргөдөлд гарын үсэг зурах” эрхийг итгэмжлэлд тусгайлан заасан нөхцөлд эдэлж болохоор хуульчилсан байдаг.

Хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлд гарын үсэг зурсан этгээд тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох нь нэхэмжлэлд хавсаргасан баримтаас тодорхой биш, шүүхэд

төлөөлөх эрх итгэмжлэлээр олгогдоогүй бол төлөөлөх бүрэн эрхтэй этгээд гэж үзэх боломжгүй болно.

Хуулийн этгээдийн эрхгүй холбоо, сан зэрэг нэгтгэлийн хувьд тухайн холбоо санг үүсгэн байгуулах баримт бичиг, дүрэмд шүүхэд төлөөлөх асуудлыг хэрхэн зохицуулж тогтоосныг нь үндэслэн гагцхүү хуульд заасан тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авах, гуравдагч этгээдээр татан оролцуулах боломжийг энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-оор шүүгчид олгосон байна.

Гэхдээ хуулийн этгээдийн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргах тохиолдолд гагцхүү эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж буй этгээдийг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой байгааг анхаарах хэрэгтэй юм. Тухайлбал: Сууц өмчлөгчдийн холбоо нь Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.3-т зааснаар “хуулийн этгээдийн эрхгүй байх” боловч мөн хуулийн 149 дүгээр зүйлийн 149.2-т зааснаар өөрийн гишүүн сууц эзэмшигч, өмчлөгчдийн эрхийг хамгаалах зорилгоор өөрийн төлөөлөгчөөр дамжуулан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Харин энэ төрлийн байгууллагын хувьд нэгэнт уг этгээд нь өөрөө хуулийн этгээдийн эрхгүй тул өөрийн үйл ажиллагаагаар эрх бий болгохгүй, улмаар уг эрх нь хуулиар хамгаалагдсан байх боломжгүй тул өөрийн субьектив эрх зөрчигдсөн хэмээн шүүхэд маргах боломж тун хязгаарлагдмал юм.

Хуулийн этгээдийн эрхгүй этгээд “өөрийн эрхийг зөрчигдсэн” гэж үзэж нэхэмжлэл гаргах боломжит нэг тохиолдол бол: Төрийн бус байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар “үүсгэн байгуулагчдаас төрийн бус байгууллага (ТББ) байгуулах тухай шийдвэр гаргаж байгууллагын дүрмийг баталснаар төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсанд тооцох бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрхэдлэх” зохицуулалттай. Гэтэл тухайн ТББ –ыг байгуулах шийдвэр гарч байгуулагдсаны дараа улсын бүртгэлд бүртгэхээс татгалзжээ. Энэ үед тухайн ТББ нь эрх зүйн байдлын хувьд “хуулийн этгээдийн эрхгүй” болохоос биш нэгэнт бие даасан “байгууллага” үүсч болсон байна.

Өнөөгийн байдлаар гагцхүү энэ үед л уг ТББ нь өөрийн нэрээр өөрийн эрхийг зөрчигдсэн гэж үзэж Улсын бүртгэлийн байгууллагын бүртгэхээс татгалзсан шийдвэрийг хянуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандах боломжтой.

Нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан бол тухайн нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

Нэхэмжлэлд захиргааны байгууллагын шийдвэр /захиргааны акт/ нь хуульд заасан журам процедурыг зөрчсөн, хууль бус гэдгийг тодорхой

үндэслэлүүдээр заан дурдсан ч, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөнталаар тодорхой заагаагүй, түүний үйлдэл нэхэмжлэгчийн тодорхой эрхэд чиглээгүй, шууд хамааралгүй бол нэхэмжлэгчийг нэхэмжлэл гаргах эрхгүй гэж үзэж болно.

Иймд тухайн захиргааны актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөнөө нэхэмжлэгч нэхэмжлэлдээ тодорхой зааж үндэслэх ёстой бөгөөд, нэхэмжлэлд дурдсан нөхцөл байдлуудаас захиргааны акт нь нэхэмжлэл гаргасан этгээдийн субъектив (хуульд заасан журмын дагуу өөрт үүсч, бий болж, баталгаажсан) эрхтэй холбоогүй, өөрөөр хэлбэл нэхэмжлэгч захиргааны байгууллагатай тухайлсан эрх зүйн харилцаа үүсгээгүй, түүний шийдвэр үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй болох нь илт байхын зэрэгцээ нэхэмжлэгч өөрөө захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа /захиргааны акт/ нь эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэдгийг зааж тодорхойлоогүй байвал нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

Жишээ нь: Гадаад улсын харьяат иргэнээс Монгол улсын иргэнд газар өмчлүүлсэн шийдвэр нь өөрийнх нь газар өмчилж авах эрхийг зөрчлөө гэсэн утга бүхий нэхэмжлэлийг гаргасан бол түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхгүй нь ойлгомжтой. Учир нь гадаадын иргэнд монгол улсад газар өмчлөх эрхийг хуулиар олгоогүй, тухайн этгээдэд энэ асуудлаар маргах эрх үүсэхгүй нь тодорхой байгаа.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6 дахь үндэслэл байгаа эсэхийг шалгах:

Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагын талаар урьд өмнө гарсан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа гэсэн үндэслэлээр захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа нэхэмжлэлийн шаардлага буюу маргаан бүхий захиргааны актын талаар, мөн нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн талаар гарсан шүүхийн шийдвэр байгаа эсэхийг шалгахаас гадна маргаан бүхий актыг гаргасан хариуцагч захиргааны байгууллага, албан тушаалтны хууль зөрчсөн үйл ажиллагаа буюу тухайн маргаан бүхий захиргааны актын хууль зүйн үндэслэлийн талаар дүгнэсэн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байгаа эсэхийг шалгаж тогтоох шаардлагатай.

Жишээ нь: шүүх, иргэн “Б”-гийн “Нийслэлийн Засаг даргын 2007 оны 777 дугаар захирамжийн өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгох” тухай нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, маргаан бүхий захиргааны акт нь хууль бус, иргэн “Б”-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж дүгнэн нэхэмжлэлийг

хангаж шийдвэрлэжээ. Гэтэл энэ шийдвэрийг хүчин төгөлдөр болсны дараа иргэн “О” нь мөн “Нийслэлийн Засаг даргын 2007 оны 777 дугаар захирамжийн өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгох” тухай шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргасан бол шүүх уг нэхэмжлэлийг хуулийн 34.1.6-д заасан үндэслэлээр буюу тухайн захиргааны актын хууль зүйн үндэслэлийг буюу хариуцагчийн гэм бурууг дүгнэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байна гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзахгүй. Учир нь дээрх нэхэмжлэлийн хариуцагч, мөн маргаан бүхий захиргааны акт адил боловч уг актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж нэхэмжлэл гаргасан нэхэмжлэгч өөр байна.

Өөрөөр хэлбэл хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6 нь тухайлсан нэг маргааны хувьд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байхыг шаардах бөгөөд дээрх тохиолдолд эхний нэхэмжлэгч иргэн “Б” болон Нийслэлийн Засаг даргын дунд үүсэж, шийдвэрлэгдсэн (1) маргаан нь сүүлийн нэхэмжлэгч болох иргэн “О” болон Нийслэлийн Засаг даргын хооронд үүссэн (2) маргааны үйл баримтаас тусдаа. Тиймээс эхний маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь сүүлийн маргааны хувьд хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр болохгүй. Энэ тохиолдолд нэхэмжлэгч “О”-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхол дээрх захиргааны актын улмаас зөрчигдсөн эсэхийг захиргааны хэрэг үүсгэн шалгаж тогтоосны үндсэн дээр нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэхийг дүгнэж шийдвэрлэх шаардлагатай.

Хэрэв иргэн “О” нь өмнөх нэхэмжлэгч “Б” –гын эрх залгамжлагчаар тогтоогдсон эсхүл тухайн “маргаан бүхий эрх” –ийг түүнээс шилжүүлж авсан гэх тохиолдлуудад шүүх нэхэмжлэлд дурдсан маргааны үйл баримт буюу иргэн “Б” –гын эрх зөрчигдсөн эсэх талаар, хариуцагчийн гэм буруугийн талаар хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байгаа гэж үзнэ. Учир нь хэдийгээр “О” нэхэмжлэл гаргаж байгаа боловч түүний маргаж буй асуудал буюу иргэн “Б” –гээс шилжүүлэн авсан (эсхүл залгамжилсан) бөгөөд өмнө нь шийдвэрлэгдсэн эрхийн талаар дахин маргахгүй.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн агуулга, зохицуулалтаас үзвэл шүүх тухайлсан нэг маргааныг нэг удаа шийдэх бөгөөд тухайлсан “маргаан” гэдэг ойлголт нь (1) нэр бүхий тодорхой этгээдүүд /талууд/ -ийн хооронд үүссэн, (2) тухайлсан асуудлын хууль зүйн үндэслэлээр маргасан байх гэсэн бүрдэлтэй байна. Тиймээс хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6 дахь үндэслэлээр татгалзах тохиолдолд дээрх 2 нөхцөл бүрдсэн үү гэдгийг харьцуулан дүгнэлт хийх шаардлагатай.

Түүнчлэн, нэхэмжлэлд дурдсан “үйл баримтын” талаар дүгнэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг

хүлээн авахаас татгалзахдаа нэхэмжлэлд дурдсан маргаж буй үйл баримт буюу маргаан бүхий захиргааны актыг хууль бус гэж үзсэн үндэслэл адил боловч, уг асуудлаар шинээр гарсан захиргааны актын талаар маргаж байвал нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахгүй.

Жишээ нь: Төрийн албан хаагчийг хууль бусаар халсан гэж тогтоогдон, маргаан шийдвэрлэгдсэний дараа шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон үед, өөр ямар нэгэн үндэслэл гараагүй байхад, урьдхи үндэслэлээр дахин шинэ акт гаргаж төрийн албанаас дахин халсан тохиолдолд шинээр гарсан захиргааны актыг хууль бус гэж шүүхэд хандсан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй, учир нь уг захиргааны актын хууль зүйн үндэслэлтэй эсэхийг дүгнэсэн шүүхийн шийдвэр байхгүй юм.

Харин энэ тохиолдолд төрийн албан хаагчийг халах үндэслэл байхгүй талаар дүгнэсэн шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоосон тул уг үйл баримтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг баримтлан дахин үнэлэхгүй байх хууль зүйн үндэслэлтэй.

“Хэргийг хэрэгсэхгүй болгосон” хуулийн хүчин төгөлдөр шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж байгаа гэдэгт энэ хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон, 42 дугаар зүйлд зааснаар хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон, 43 дугаар зүйлд зааснаар эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хамаарна. Мөн нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж дуусан, шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэх үед хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан татгалзах үндэслэл тогтоогдох үед хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3-т зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол хамаарна.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан хуулийн хүчин төгөлдөр шүүгчийн захирамж байгаа гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа энэ асуудлаар урьд нь гарсан захирамжид заасан “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл” арилсан эсэхийг шалгаж, татгалзсан үндэслэл арилсан бол нэхэмжлэлийг тухайн үндэслэлээр хүлээн авахаас татгалзахгүй. Харин урьд нь хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 –д заасан үндэслэлээр татгалзсан бол “хүлээн авахаас татгалзах үндэслэл арилах” тухай ойлголт байхгүйг анхаарах хэрэгтэй.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7 дахь үндэслэл байгаа эсэхийг шалгах:

Нэхэмжлэгч болох иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан боловч эрх үүрэг нь эрх залгамжлагчид шилжсэн нь нэхэмжлэлд хавсаргасан

баримтаар нотлогдохгүй бол шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана. Энэ тохиолдолд нэхэмжлэгч нь татгалзсан шалтгааныг арилгаж, эрх залгамжлагч мөн гэдгээ нотлосон бол дахин нэхэмжлэл гаргах эрхтэй.

Жишээ нь: Шүүгчийн захирамжаар иргэн Ш.Х –ны Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдуулан гаргасан “Монгол шуудан банк” ХХК-ийн 2000 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох, “УС” ХХК-ийн эд хөрөнгийн бүртгэлийн 22222 тоот Ү-220220220 дугаарт бүртгэгдсэн гэрчилгээг сэргээхийг Улсын бүртгэлийн газарт даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.1.7 дахь үндэслэлээр өмнө нь “уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж байгаа” гэсэн үндэслэлээр дахин хүлээн авахаас татгалзжээ.

Гэтэл нэхэмжлэлд хавсаргасан баримтаар: 1/ Шүүгчийн захирамжийн үндэслэх хэсэгт дурдсан захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн 2009 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 431 дүгээр захирамжаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7 дахь “нэхэмжлэгч болох хуулийн этгээд “УС” ХХК татан буугдсан боловч эрх, үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан боловч нэхэмжлэгч Ш.Х нь 2011 оны 10 дугаар сарын 17-нд захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ “УС” ХХК-ийн “эрх залгамжлагч” нь өөрөө болох тухай холбогдох нотлох баримтуудыг хавсарган өгснөөр татгалзсан үндэслэл арилсан болох нь харагдаж байна.

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.8 дахь үндэслэл байгаа эсэхийг шалгах:

Нэхэмжлэгч нь өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш буюу энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан 30 хоногийн хугацаанд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2-т зааснаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Иймд хүлээн авсан шүүгч уг нэхэмжлэл нь хуульд заасан нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаанд гарсан эсэхийг шалган, хуульд заасан 30 хоногийн хугацааг хэтрүүлсэн бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Нэхэмжлэгч энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх тухай хүсэлтээ тухайн захиргааны хэргийн шүүхэд гаргах бөгөөд уг хүсэлтийг шүүхээс сэргээсний дараа шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болно.

Шүүгч нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахад захиргааны

акт гарснаас хойш хэдий хугацаа өнгөрсний дараа шүүхэд хандсаныг шууд тоолж тогтоох хялбар мэт боловч маргаан бүхий захиргааны актыг нэхэмжлэгч хэзээ хүлээн авсан, хэзээ мэдсэн гэдгийг нэхэмжлэлийг хүлээн авмагцаа шалгалгүйгээр шууд тогтоох боломж муутай байдаг. Иймд шүүхийн практикт 7 хоногийн хугацаанд холбогдох баримтуудыг шаардах, цуглуулах ажиллагааг хийж энэ талаар дүгнэлт хийх, эсхүл бүр боломжгүйд хүрвэл уг нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэн, нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдэд хандсан, хаягласан захиргааны актыг уг актыг гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтан хүргүүлэх, мэдэгдэх үүргээ биелүүлсэн эсэхийг шалгаж тогтоосныг үндэслэн уг асуудалд дүгнэлт өгөх шаардлагатай болно.

Нэгэнт холбогдох этгээдэд нь захиргааны байгууллага гаргасан шийдвэрээ журмын дагуу хүргүүлсэн, мэдэгдсэн нь нотлогдож байвал хугацааг тоолоход хялбар бөгөөд харин энэ талаар баримтгүй эргэлзээтэй бол хугацаа тоолоход бэрхшээлтэй болно. Иймд захиргааны байгууллагын шийдвэрийг мэдэгдэж, хүлээлгэн өгсөн баримтгүй бол энэ үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахаар яарч, урьдчилан дүгнэлт өгөх нь иргэн, хуулийн этгээдийн шүүхэд хандах эрхийг үндэслэл муутайгаар хязгаарлах үр дагавартай тул анхааралтай авч үзэх нь зүйтэй юм. Түүнчлэн нэхэмжлэлийн шаардлага нь захиргааны “эс үйлдэхүй” –тэй холбоотой байгаа тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн гэсэн дүгнэлт хийхдээ хянамгай хандаж, Иргэний хуулийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг тохиолдол бүрт тааруулан хэрэглэх шаардлага байна.

Энд өөр нэг анхаарах зүйл нь захиргааны акт гарсныг мэдсэн ч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүхэд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааг хэтрүүлсэн бол нэхэмжлэлийг хүлээн авах хуулийн зохицуулалтыг зөв хэрэглэх асуудал гарна.

Захиргааны байгууллагын үйл ажиллагааны улмаас эрхээ зөрчигдсөн гэж үзсэн этгээд уг захиргааны актыг мэдмэгцээ хуульд заасан дээд шатны байгууллага, албан тушаалтанд биш, бусад хяналт шалгалтын эрх бүхий байгууллагад хандаж дүгнэлт гаргуулж, ингэх явцад нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа алдагдсан тохиолдол гардаг. Энэ тохиолдолд хяналт шалгалтын байгууллагад хандах эрх нь иргэн, хуулийн этгээдэд тухайн хуулиар олгогдсон байдаг учраас түүнийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа алдсан гэж үзэх боломжгүй юм.

Хүндэтгэн үзэх шалтгаан гэдгийг урьдчилан таамаглаж ерөнхийд нь тодорхойлох боломжгүй бөгөөд тухайн тохиолдол бүрт нэхэмжлэгчээс гаргаж ирж буй үндэслэлд дүгнэлт хийж, хугацаа алдахад хүргэхүйц

зайлшгүй нөхцөл байж уу гэдгийг баримтаар тогтоох замаар шүүгч шийдвэрлэх нь зохимжтой.

Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл захиргааны хэрэг үүсгэх үед мэдэгдэхгүй байх боломжтой бөгөөд хэрэг үүсгэсний дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгт цугларсан нотлох баримтуудаар энэ үндэслэл тогтоогдвол энэ хуулийн 74 дүгээр зүйлийн 74.3-т зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

Захиргааны хэрэг үүсгэх тухай 36 дугаар зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудлууд

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй гэж үзвэл шүүгч нэхэмжлэлийн шаардлагаар захиргааны хэрэг үүсгэнэ. Нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шүүгч тухайн нэхэмжлэлийг татгалзах үндэслэл байгаа эсэхийг хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан үндэслэл тус бүрээр нягтлан шалгаад, татгалзах үндэслэлгүйг тогтоосны үндсэн дээр захиргааны хэрэг үүсгэнэ.

Мөн нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангуулахаар шүүгчийн захирамжаар буцаасан нэхэмжлэлийг бүрдүүлбэр хангаж ирүүлсэн бол, энэ өдрөөс хойш 7 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэнэ. Захиргааны хэрэг үүсгэж буй шүүгч энэ тухай захирамж гаргаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж, хугацаа тоологдож эхэлнэ.

Нэхэмжлэгч нь нэг, түүнчлэн хэд хэдэн шаардлагыг мөн нэг болон хэд хэдэн хариуцагчид холбогдуулан гаргаж болох бөгөөд шүүгч захиргааны хэрэг үүсгэснээр нэхэмжлэгчийн тодорхойлсон хариуцагч, мөн нэхэмжлэгч нь албан ёсоор хэргийн оролцогч болж, хуульд заасан эрх үүргийг эдлэх үр дагавар үүсэх учраас шүүгч захирамждаа хэний ямар шаардлагатай нэхэмжлэлээр ямар захиргааны байгууллага, албан тушаалтанд холбогдуулан захиргааны хэрэг үүсгэж байгаагаа шаардлага тус бүрээр тохирох хариуцагчид нь холбогдуулан тодорхой зааж өгөх нь зүйтэй.

Түүнчлэн захирамжийн үндэслэх хэсэгт нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлгүй, хуулийн 34.1.1-34.1.8-д заасан тохиолдолууд тогтоогдохгүй байгаа талаар тодорхойлон бичиж, уг нэхэмжлэл нь шүүхийн болон хэргийн харьяаллын хувьд тухайн захиргааны хэргийн шүүхийнх мөн болох тухай дүгнэж тусгана.

Шүүгч захиргааны хэрэг үүсгэхдээ анхаарвал зохих дээрх асуудлууд нь хэрэг үүсгэсний дараа татгалзах үндэслэл илрэх, мөн хэргийн хариуцагчийг жинхэнэ хариуцагчаар солих зэргээр хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны хугацааг сунжруулах, хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг зөв тодорхойлж чадахгүй байх, улмаар нэхэмжлэлийн шаардлагыг зөв тодорхойлуулаагүйгээс шийдвэрлэвэл зохих асуудлыг шүүхийн шийдвэрээр шийдвэрлэхгүй орхигдуулах зэрэг сөрөг үр дагавар гарах магадлалыг багасгаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөв эхлүүлэх ач холбогдолтой.

Захиргааны хэрэг үүсгэсний дараа шүүгчийн хийх ажиллагааг тодорхойлсон хуулийн 37 дугаар зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудлууд

Нэхэмжлэлийг хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ямар ажиллагааг хийвэл зохихыг хуулийн энэ заалтад төрөлжүүлж тоймлон заасан байна.

Шүүхэд хүлээн авсан нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэснээр хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагаа шүүгчийн эрх хэмжээнд шилжих учраас хэрэг үүсгэсэн шүүгч нь хуульд заасан ажиллагаа бүрийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцүүлэн, үр дүнтэй, шуурхай, зөв хэрэгжүүлснээс хэргийн нөхцөл байдлыг хуульд заасан хугацаанд багтаан бүрэн дүүрэн тогтоох, улмаар шүүхийн шийдвэр үндэслэлтэй гарах нөхцөл бүрдэнэ. Иймд хуульд заасан дараах ажиллагааг алхам бүрээр нь хугацаанд нь үр дүнтэй удирдан явуулах ёстой.

Шүүхнэгэнт нэхэмжлэгчийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэж, нэхэмжлэгчийн тодорхойлж заасан хариуцагчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар шийдвэрлэсэн учраас юуны түрүүнд хариуцагчийг дуудан ирүүлж, нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримт бичгийн хувийг гардуулах ажиллагааг явуулна. Нэхэмжлэлийн хувийг гардан авсан хариуцагч нь нэхэмжлэлд хариу тайлбарыг хуульд заасан хугацаанд бичгээр гаргах үүрэгтэй учраас хугацаа тоолох шаардлагын үүднээс нэхэмжлэлийг гардуулсан хугацааг баримтжуулж, хариу тайлбар гаргах хугацааг тогтоон, гарын үсэг зуруулан баталгаажуулж авна. Энэ шаардлагыг хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтаар тодорхойлсон байна.

Хуулийн энэ заалтын дагуу “хариуцагчийг дуудан ирүүлэх”-дээ шүүхэд ямар учир дуудаж байгааг, мөн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирээгүйгээс гарах үр дагавар, шүүхэд ирвэл зохих өдөр, цаг хугацааг тодорхой бичсэн шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудна. Шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авсан хариуцагч мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1, 20 дугаар зүйлийн 20.2-т заасан “захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх” үүргийнхээ дагуу шүүхэд заасан хугацаанд ирж нэхэмжлэлийг өөрийн биеэр, мөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан гардан авна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах мөрдөн шалгах зарчмын дагуу захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг гүйцэтгэдэгтэй холбоотой ажиллагаануудыг хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалтаар нэгбүрчлэн тодорхойлж өгсөн байна. Энэ заалтаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчоос эрх үүргээ хэрэгжүүлэх явцад цугларч болох нотлох баримтаас өөр, шүүх санаачилгаараа эсхүл хэргийн оролцогчийн хүсэлтийн дагуу нотлох баримт бүрдүүлэх, тухайлбал гэрчийн мэдүүлэг авах, шинжээч, хэлмэрч томилох болон шаардлагатай бусад ажиллагааг тодорхойлж заасан байгааг анзаарвал зохино.

Хуулийн энэ зохицуулалтаас харвал хэрэгт ач холбогдолтой нотлох баримтыг цуглуулах захиргааны хэргийн шүүхийн үүрэг нь хэргийн оролцогчийн нотлох баримтыг гаргаж өгөх, энэ талаар хүсэлт гаргах эрхийг хязгаарлахгүй байна. Иймээс хэргийн оролцогч нар нь шүүхээс шаардсан эсэхээс үл хамааран өөрийн шаардлага, тайлбар, татгалзал, няцаалтын үндэслэл болсон нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх бөгөөд өөрөө гаргаж өгөх боломжгүй бол энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т зааснаар нотлох баримт бүрдүүлэх талаар шүүхэд хүсэлт гаргана.

Хуулийн энэ заалт дахь “хэрэгт ач холбогдолтой” гэдгийг маргаж буй зүйлд хамааралтай, өөрөөр хэлбэл, талуудын шаардлага, тайлбар, татгалзлын үндэслэлийг нотлоход чиглэгдсэн, эсхүл шүүхийн үзсэнээр тухайн маргааны үйл баримтыг бүрэн тогтооход хэрэглэгдэхүйц, хуульд заасан арга журмын дагуу авагдсан, эргэлзээгүй баримтыг цуглуулах ажил гэж ойлгоно.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хэргийн оролцогч бүр хуульд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлснээр шүүх хэргийг бүх талаас бүрэн дүүрэн хэлэлцэж шийдвэрлэх гол нөхцөл болох бөгөөд ингэхийн тулд хэргийн оролцогч бүрт эрх үүргийг нь тайлбарлан ойлгуулж, эрхээ хэрэгжүүлэх урьчилсан нөхцлийг шүүх бүрдүүлнэ.

Иймд хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалтад “хэргийн оролцогчид эрх үүргийг тайлбарлаж өгөх” –ийг шүүхэд үүрэг болгосон байна. Улмаар хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, үүргээ мэдээгүйгээс эрх, ашиг сонирхлоо шүүхийн өмнө хамгаалж чадаагүй гэх нөхцөл байдал гаргуулахгүйн үүднээс тэдгээрт эрх үүргийг тайлбарлаж, энэ тухай тэмдэглэл үйлдэж гарын үсэг зуруулж, баримтжуулсан байх шаардлагыг хуульд зааж өгсөн байна.

Шүүх шийдвэрлэж байгаа хэргийн нотлох баримт нь өөр аймаг, орон нутагт байгаа, түүнийг зайлшгүй цуглуулах, хэрэгт авах шаардлагатай

гэж үзвэл энэ хуулийн 30, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримт байгаа газрын захиргааны хэргийн шүүхээр даалгавар гүйцэтгүүлэн нотлох баримтыг цуглуулах эрхтэй. Хэдийгээр даалгавар гүйцэтгүүлэх тухайн орон нутагт захиргааны хэргийн биш ерөнхий харьяалалын шүүх илүү ойр байж болох боловч, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх эрх хэмжээ нь зөвхөн захиргааны хэргийн шүүхүүдэд байгаа, хэрэг хянан шийдвэрлэх ялангуяа, нотлох баримт цуглуулах ажиллагаан дахь зарчмын ялгаа зэргээс үндэслэн даалгаварыг зөвхөн захиргааны хэргийн шүүхээр гүйцэтгүүлэхээр явуулж байх нь зүйтэй.

Ингэхдээ шүүгч даалгавар гүйцэтгүүлэх тухай захирамж гаргаж, олж авах нотлох баримтыг тодорхой заан, шаардлагатай ажиллагааг хэрхэн явуулах, даалгавар гүйцэтгэх хугацааг захирамждаа тодорхой заана. Даалгаврыг хүлээн авсан шүүх захирамжид заагдсан ажиллагааг хугацаанд нь, бүрэн гүйцэтгэж, хүргүүлнэ. Хэрэв биелүүлэх боломжгүй тохиолдолд энэ талаар даалгавар ирүүлсэн шүүхтэй буцаж харилцаатай байх нь чухал.

Шүүхийн даалгавар гүйцэтгүүлэх хугацаанд тухайн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.8-д заасан үндэслэлээр түдгэлзүүлнэ.

Хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5-д “талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авах” гэж заасан нь хэрэг маргааныг эвлэрлийн журмаар шийдвэрлэхэд шүүгчээс маргааны үйл баримт, нөхцөл байдал болон эрх зүйн асуудлыг судалснаар тодорхой арга хэмжээ авч, маргааныг эвлэрлээр дуусгах ач холбогдолтой. Энэ зохицуулалт нь захиргааны хэргийн хариуцагч болох захиргааны байгууллага, албан тушаалтанд өөрийн гаргасан шийдвэрээ илэрсэн бодит нөхцөл байдал, хуульд нийцүүлэн өөрчлөх, хүчингүй болгох эрх хуулиар олгогдсон байдагтай холбоотой юм. Ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг талуудын эвлэрлээр дуусгах нь хугацаа, зардлыг хэмнэхээс гадна, шүүхийн шийдвэр сайн дураар биелэгдэх, хэргийн оролцогчид харилцан буулт хийж, зөвшилцөн эвлэрдэг сэтгэл зүйн эерэг үр нөлөөтэй ч захиргааны хэргийн хувьд хариуцагчийн буулт нь гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндөх эсэх, шинээр гаргах захиргааны акт нь хууль зүйд хэр нийцтэй байх зэргийг шүүгч сайтар нягталсны дараа эвлэрлийг батлах ёстой гэдгийг анхаарах хэрэгтэй юм.

Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах хуулийн 38 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд

Шүүгч, шүүгчийн туслах энэ хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 40 дүгээр зүйлд заасны дагуу дуудан ирүүлсэн хариуцагчид нэхэмжлэлийн

хувийг гардуулах ажиллагааг нийслэлд 7, орон нутагт 14 хоногийн дотор гардуулан, эрх үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай баримт үйлдэн хэрэгт хавсаргана. Хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулснаар нэхэмжлэлд хариу тайлбар гаргах үүргийг мэдэгдэж, мөн хугацааг тоолж эхлэх тул дурдсан баримт нь хариуцагчийн эрх үүргээ хэрэгжүүлэх, тайлбарыг хугацаандаа гаргаж байна уу гэдэгт хяналт тавихад ач холбогдолтой.

Нэхэмжлэлийг гардаж авсан хариуцагч нь 14 хоногийн дотор хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1-д заасан “нэхэмжлэлийн талаар бичгээр тайлбар гаргах, захиргааны хэргийн шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх” үүргээ биелүүлж, нэхэмжлэлд бичгээр тайлбар гарган, холбогдох нотлох баримтыг хавсарган ирүүлнэ. Нөгөөтэйгүүр, энэ үүрэг хэрэгт татагдсан гуравдагч этгээдэд мөн хамааралтай бөгөөд шүүхээс тогтоосон хугацаанд тайлбар гаргаж ирүүлээгүй нь хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг хэрэглэх үндэслэл болно.

Энд хариуцагч, гуравдагч этгээдэд нэхэмжлэлийг гардуулахдаа эрх үүргийг нь шүүхээс тайлбарласан учраас хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4-т заасан “захиргааны хэргийн шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах” үүрэг давхар биелэгдэх ёстой.

Ийнхүү хариуцагч тайлбараа бичгээр ирүүлснийг шүүх нэхэмжлэгчид танилцуулснаар талуудын мэтгэлцээн эхэлж, нэхэмжлэлийн үндэслэл, хариуцагчийн тайлбарт дурдагдсан татгалзал, түүнд хавсаргасан баримтад шүүгч эрх зүйн дүгнэлт хийж, маргааны үйл баримтыг болон уг маргаантай харилцааг зохицуулсан хуулийн зохицуулалтыг судлан шаардлагатай нотлох баримтыг цуглуулах ажиллагааг хийнэ.

Захиргааны хэргийн иргэний хэргээс ялгагдах онцлог нь хэргийн оролцогчид нь харилцан тэгш биш байдаг, хариуцагч нь уг маргаанд ач холбогдол бүхий баримтыг бүрдүүлэх зэрэгт нэхэмжлэгчээс боломж, эрх хэмжээний хувьд илүү захиргааны байгууллага байдаг учраас нэхэмжлэгч, хариуцагчийн тайлбарыг судалсны дараа шүүгчийн мөрдөн шалгах, шаардлагатай нотлох баримтыг шаардан гаргуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийг татан оролцуулах, бичгийн нотлох баримтыг байгаа газарт очиж үзэж судлах, маргаан бүхий газар, объектод үзлэг хийх гэх мэт шаардлагатай аливаа ажиллагааг эхэлнэ.

Захиргааны хэргийн хувьд нэхэмжлэлд бичгээр гаргах хариу тайлбарыг хугацаандаа гаргаагүй нь нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцогддог Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт шууд хэрэглэгдэхгүй, учир нь хариу тайлбар өгөөгүй хэн нэгэн хариуцлагагүй албан тушаалтны үйлдлээс болж шүүх тухайн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг

хянаж, дүгнэлт хийгээгүй байтлаа шууд хүчингүй хэмээн тооцсон шийдвэр гаргах боломжгүй. Харин энэ тохиолдолд тайлбараа хуульд заасан болон шүүгчээс тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй бол холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтанд нэхэмжлэлд хариу тайлбар өгөхийг сануулан шаардах, улмаар хуульд заасан үүргээ биелүүлээгүй гэм буруугийнх нь төлөө Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх асуудал зайлшгүй.

Сөрөг нэхэмжлэл гарч болох тухай хуулийн 39 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх тухай

Хуулийн энэ зохицуулалт нь хариуцагч нэхэмжлэгчийн хууль бус гэж үзсэн захиргааны актаас өөр захиргааны акттай холбогдуулан уг маргаантай хамт шийдвэрлүүлэхээр сөрөг шаардлага гаргаж болохыг зөвшөөрсөн байна. Ийнхүү сөрөг нэхэмжлэл гаргаж байгаа нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй тухай хариуцагчийн татгалзлаас ялгаатай.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээн тогтооход чиглэсэн байдаг тул хариуцагч захиргааны байгууллага, албан тушаалтан нь нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдийн эсрэг сөрөг шаардлага гаргах нь төдийлөн тохиолдохооргүй, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн агуулга, зорилттой төдийлөн нийцэхгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

Гэвч нэхэмжлэгч хуульд заасан эрх үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд сөрөг үр дагавар гарсан байхыг үгүйсгэх боломжгүй. Энэ тохиолдолд захиргааны байгууллага хуулиар олгосон боломжийн хүрээнд сөрөг нэхэмжлэл гаргаж болно, гэхдээ сөрөг нэхэмжлэл нь үндсэн нэхэмжлэлийн шаардлага дахь маргааны үйл баримттай холбоотой (үндсэн нэхэмжлэлийн шаардлагатай тооцогдохуйц) байхыг шаардана. Үүнд гуравдагч этгээдийн бие даасан шаардлагад тавигдах нөхцлийн талаар энэ зөвлөмжид тусгасан агуулга ижил хэрэглэгдэх учир тухайн хэрэгтэй хамтад нь шийдвэрлэх сөрөг нэхэмжлэл мөн эсэхийг тогтооход анхаарч ажиллавал зохино.

Харин нэхэмжлэгч нь хүчингүй болгох, мөн даалгах нэхэмжлэлийн шаардлага гаргасан тохиолдолд хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргахыг хориглосон байна. Энэ төрлийн нэхэмжлэлд хариуцагчийн хуульд заасан үүргээ зөрчсөн, үүргээ биелүүлээгүйн улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн тухай асуудал яригдах учраас хуульд заасан үүрэг нь заавал биелэгдэх ёстой гэсэн агуулгаар хариуцагчийн сөрөг шаардлага гаргах эрх хязгаарлагдана.

Нэхэмжлэлээс татгалзах тухай хуулийн 41 дүгээр зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудлууд

Шүүхэд иргэн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэл захиргааны хэрэг үүсгэх үндэслэл болдог, өөрөөр хэлбэл, шүүхэд хэн нэгэн хандаагүй бол шүүх санаачилгаараа хэрэг үүсгэдэггүй учраас шүүхэд хандсан этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд нэхэмжлэлээсээ татгалзаж болно. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан бол шүүгч нэхэмжлэгчийн нэхэмжлэлээсээ татгалзсаныг батлан, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай захирамж гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгана.

Нэхэмжлэгч эрх зүйн мэдлэг дутмаг, нэхэмжлэлээс татгалзсаны үр дагаврыг ойлголгүйгээр нэхэмжлэлээс татгалзсан, эсхүл энэ тухай мэдэж байсан ч тодорхой шалтгаанаар үр дагаврыг эс тооцон нэхэмжлэлээсээ татгалзсанаа эрх зүйн мэдлэггүйн улмаас татгалзсан гэж маргах тохиолдлууд байдаг. Иймд нэхэмжлэлээсээ татгалзах бол уг асуудлаар шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болох үр дагавартайг шүүгч урьдчилан нэхэмжлэгчид тайлбарлан өгч, уг нөхцөл үр дагаврыг зөвшөөрсөн тохиолдолд татгалзлыг баталж, энэ тухай захирамждаа тусгах нь зүйтэй байдаг.

Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзаж байгаа нөхцөлд тэрээр хуульч өмгөөлөгчийнхөө зөвлөгөөг авсан эсэх, уг асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхээ алдах талаарх үр дагаврыг бүрэн ойлгосон эсэх, эрх зүйн туслалцаа авч, түүнээс гарах үр дагаврыг мэдсэн эсэхийг сайтар анхаарвал зохино.

Харин нэхэмжлэгч нэхэмжлэлээс татгалзсан нь энэ асуудлаар бусад этгээд нэхэмжлэл гаргахад саад болохгүй, мөн нэхэмжлэгч нэхэмжлэлээс татгалзах нь хэргийн бусад оролцогч тухайлбал, хариуцагч, гуравдагч этгээд ямар саналтай байхаас шалтгаалахгүй. Шүүх хуралдааны явцад нэхэмжлэлээсээ татгалзвал энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдааны ажиллагааг дуусган шүүгч захирамж, шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж, нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад “захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлнэ” гэх мэт шалтгаанаар нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг “дэмжихгүй” (татгалзах биш) гэдгээ мэдэгдэх тохиолдол гардаг бөгөөд энэ тохиолдолд түүнийг нэхэмжлэлийн шаардлагаас татгалзсан гэж үзэж, хуулийн 41 дүгээр зүйлээр шийдвэрлэхгүй. Харин нэхэмжлэлээ дэмжээгүй бол нэхэмжлэлийг хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь заалтаар нэхэмжлэгчид буцаах арга хэмжээ авна, энэ тохиолдолд

нэхэмжлэгч шаардлагаасаа татгалзаагүй тул дахин нэхэмжлэл гаргах эрх нь хэвээр хадгалагдсан үлднэ. Гэхдээ шүүхийн анхаарах асуудал бол хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэлийг буцаасан тохиолдолд дахин нэхэмжлэл гаргахдаа мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан хугацааны дотор гаргах эрхтэй, уг хугацаа хэтэрвэл шүүхэд хандах эрхээ алдана гэдгийг нэхэмжлэгчид тайлбарлаж, баримтжуулах шаардлагатай.

Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаас татгалзсанаа илэрхийлсэн байхад зарим үед шүүхүүд “тухайн шаардлагыг хэлэлцээгүй болохыг дурдсугай” гэх, эсхүл “нэхэмжлэлээсээ татгалзсаныг дурдсугай” гэх зэргээр шийдвэрийн тогтоох хэсэгтээ бичиж, уг шаардлагыг шийдвэрлэлгүй орхиж буй нь буруу.

Гэтэл уг шаардлагаас татгалзсан эсэхийг шийдвэрлээгүй байтлаа дээрх байдлаар “дурдсан” асуудлаар нэхэмжлэгч дахин нэхэмжлэл гаргах үед анхан шатны шүүхүүд уг шаардлагаасаа татгалзсан талаарх хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр тогтоол байна гэж үзэж нэхэмжлэлийг хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.6 дахь үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж, нэхэмжлэгчийн шүүхэд хандах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласан алдаа гаргаж байна.

Зүй нь нэхэмжлэлийн шаардлагаас татгалзсан бол татгалзлыг баталж, нэгэнт үүссэн захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгох ёстой, түүнээс “дурдаж орхих” тухай хуулийн зохицуулалт байхгүй төдийгүй энэ байдал нь дараа уг асуудлаар нэхэмжлэл гаргахад “уг шаардлагыг шүүх шийдсэн” гэж үзэх эсэх асуудлаар маргаан үүсэх үндэслэл болж байгааг анхаарвал зохино.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх хуулийн 42 дугаар зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудлууд

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэлтэй гэж үзэн бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн нь хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болох ч шүүгч хариуцагчийн зөвшөөрөл нь бусад этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй, мөн хуульд харшлаагүй гэдэгт хууль зүйн дүгнэлт өгсний эцэст зөвшөөрлийг батална. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч захиргааны байгууллага, албан тушаалтан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх нь гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлах нь олонтаа байдаг тул энэ тохиолдолд хариуцагчийн зөвшөөрлийг батлах боломжгүйг анхаарах нь зүйтэй.

Зарим тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр орвол зохих этгээдийг татан оролцуулаагүй атлаа хариуцагчийн

зөвшөөрлийг баталж байгаа нь туйлын буруу бөгөөд маш сөрөг үр дагаварт хүргэж байна, тиймээс үүний улмаас эрх нь хөндөгдөж болзошгүй гуравдагч этгээд байх боломжгүй гэдэг нь баталгаатай тогтоогдсон үед л хуулийн 42 дугаар зүйлд зааснаар хэргийг шийдвэрлэх нь зүйд нийцнэ.

Тиймээс хариуцагчийн тайлбар, бусад нотлох баримтыг сайтар судалж, хариуцагчийн зөвшөөрлийн улмаас өөр этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөр байгааг шүүх олж мэдвэл зөвшөөрлийг батлахгүй. Хэрэв хариуцагч хууль бус шийдвэр гаргаснаа зөвшөөрсөн нь хуульд харшлаагүй, мөн ийнхүү зөвшөөрснөөр бусад этгээдийн ялангуяа гуравдагч хэн нэгэн этгээдийн (гуравдагч этгээдээр татагдсан болон татагдаагүй ч эрх нь хөндөгдөж болзошгүй) эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөргүй бол шүүгч зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж гаргана.

Хуульд харшлаагүй гэдэгт албан тушаалтан хуулиар олгогдсон өөрийн эрх хэмжээнээс хэтэрсэн шийдвэр гаргахаар зөвшөөрөх, жишээ нь хариуцагч Сумын засаг дарга нь “Аймгийн төвийн сум дахь инженерын шугам сүлжээ бүхий газарт нэхэмжлэгчид газар эзэмшүүлсэн шийдвэр гаргах” эсхүл “хуулиар Сумын Засаг дарга шийдвэр гаргаж болох зориулалтаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх” зэрэг нөхцлийг зөвшөөрөх зэрэг тохиолдол хамаарна. Хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамж шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэнэ, тиймээс албадан биелүүлэхэд шаардагдах ажиллагааг хийнэ.

Нэхэмжлэгч, хариуцагч эвлэрэх хуулийн 43 дугаар зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудлууд

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэх арга замаа тодорхойлох зэргээр нэхэмжлэгч, хариуцагч нь маргаж буй асуудлаар харилцан буулт хийж, эвлэрэх замаар маргааныг дуусгавар болгож болно.

Ийнхүү талууд маргаанаа эвлэрэх замаар дуусгаж байгаа бол эвлэрлийн гэрээг бичгээр байгуулж, уг гэрээнд маргааныг шийдвэрлэх арга зам, талуудын хүсэл зоригийг тодорхой зааж, харилцан зөвшөөрч баталгаажуулна. Хэрэв гуравдагч этгээд оролцож байгаа бол түүнийг оролцуулан гурвалсан гэрээг байгуулж болох бөгөөд гуравдагч этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолд нэхэмжлэгч, хариуцагчийн эвлэрэл харшилж байвал шүүх гэрээг батлахгүй, эвлэрэл нь гагцхүү хуульд нийцэж, гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахааргүй бол түүнийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгон захирамж гаргана.

Эвлэрэл хуульд харшлаагүй гэдгийг “талууд хуулиар зөвшөөрөгдөөгүй, эсхүл аль нэг талд нь хуулиар тухайн үүргийг биелүүлэх боломж олгогдоогүй асуудлаар тохиролцож, маргаанаа дуусгавар болгох” зэрэг нөхцөл байхгүй байхыг ойлгоно. Харин үүнээс хэтэрсэн бол хуульд харшлаагүй эвлэрэл байж чадахгүйд хүрнэ. Жишээ нь: хариуцагч эвлэрэхдээ өөрт хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжтой асуудлаар тохиролцоонд хүрэх, өөр бусдын эрхэд илтэд харшлах асуудлаар шийдвэр гаргахаар зөвшөөрөх гэх мэт.

Шүүгч энэ тохиолдолд талуудын эвлэрлийг л баталсан, шүүхээс маргааны үйл баримтад дүгнэлт өгч шийдвэрлээгүй учир шүүгчийн захирамжид талууд гомдол гаргах эрхгүй, мөн уг асуудлаар анхан шатны шүүхэд нэхэмжлэгч дахин нэхэмжлэл гаргах эрхгүй. Шүүгч энэ тухай хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж гаргахаас өмнө урьдчилан тайлбарлан ойлгуулж, зөвшөөрлийг авсны дараа эвлэрлийг баталж, шийдвэрлэнэ.

Хэргийг нэгтгэх, тусгаарлах хуулийн 44 дүгээр зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудлууд

Хэргийг нэгтгэх, эсхүл тусгаарлах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй, нэг мөр, эсвэл давхардалгүй байлгах үүднээс шүүгчийн санаачилгаар хийгдэх бөгөөд хэргийн оролцогчоос энэ талаар хүсэлт гарсан эсэхээс үл хамааран шүүхийн шийдвэрлэх асуудал юм.

Захиргааны хэргийн шүүхэд нэг хариуцагчаас гаргасан тодорхой нэг захиргааны актын талаар өөр өөр нэхэмжлэгч адил үндэслэлээр маргаж байгаа нөхцөлд тухайн хэргүүдийг нэгтгэж нэг ажиллагаагаар шийдвэрлэх нь бүрдүүлэх нотлох баримтын хувьд ч, хэргийн оролцогчдын хувьд ч харшлах зүйлгүйн дээр нэг ажиллагаагаар шийдвэрлэх нь хэргийг нэг мөр бүрэн дүүрэн шийдвэрлэхэд ач холбогдолтой.

Гэтэл нэг шүүгч хэргийг нэгтгэх, эсвэл тусгаарлах үндэслэлгүй гэж үзэж захирамж гаргасан байхад нөгөө шүүгч нь хэргийг нэгтгэх, тусгаарлах нь зүйтэй гэж зөрчилтэй шийдвэр гаргах тохиолдол шүүхүүдэд гарч байгаа онцгой анхаарч, хэргийг нэгтгэх асуудлыг тухайн хэргүүдийг шалгаж байгаа шүүгч нар сайтар нягтлан, харилцан зөвшилцөж нэгтгэх эсэх асуудлыг нэг мөр шийдвэрлэж байх нь зүйтэй. Ингэхдээ 2 буюу түүнээс дээш хэргийг алыг алинд нь нэгтгэвэл оролцогчдын процессын эрхэд нийцвэртэй, чирэгдэлгүй, нотлох баримтыг бүрдэлд ашигтай байгаа зэргийг харгалзан үзэх нь зүйтэйг зөвлөж байна.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хуулийн 45 дугаар зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудлууд

Захиргааны эрх зүйн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд, захиргааны байгууллага нь харилцан адилгүй боломжоор хангагдсан байдаг, захиргааны байгууллага нь ямагт давуу эрх хэмжээтэй байдаг онцлогтойн учир тэдгээрийн харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэх явцад иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн урьдчилсан хамгаалалт шаардлагатай болдог. Энэхүү эрх зүйн хамгаалалтыг хуулийн энэ заалтаар тодорхойлж, маргаан бүхий актын биелэлтийг түдгэлзүүлэх эрхийг шүүхэд олгосон байна.

Иймээс захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхдээ заавал хэргийн оролцогчийн хүсэлт гарсан байхыг шаардахгүй, хэргийн нөхцөл байдлаас шалтгаалж, шүүхийн хэрэглэж болох өөрийнх нь эрх хэмжээний асуудал болно.

Шүүхээс “маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж” захирамж гаргаснаар тухайн захиргааны актын үйлчлэл хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд түр зогсох боловч, уг актын хууль зүйн үйлчлэл бүрмөсөн зогсож, хүчин төгөлдөр байдал нь алдагддаггүйгээрээ онцлог, үр дүнтэй арга юм.

Харин шүүхүүд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал байгаа эсэхийг хэргийн оролцогчдын тайлбар, холбогдох нотлох баримтад үндэслэн шийдвэрлэх шаардлагатай бөгөөд ингэхийн тулд хэргийн оролцогчдыг уг ажиллагаанд оролцож, саналаа илэрхийлэх, тайлбар, холбогдох нотлох баримтыг гаргаж өгөх боломжоор хангаж байх нь зүйтэй. Мөн түүнчлэн уг асуудлаар гарсан шүүгчийн захирамжийг танилцуулж, гомдол гаргах эрхтэйг тайлбарлаж байх нь зүйтэй.

Гэтэл шүүхүүд зарим тохиолдолд маргаан бүхий захиргааны актыг ч шаардлага хангасан хэлбэрээр хэрэгт авалгүйгээр (захиргааны актыг факсаар авсан), нэхэмжлэгчийн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг хүлээн авсан даруйдаа, хариуцагчид болон гуравдагч этгээдэд танилцуулалгүй, холбогдох тайлбар, нотлох баримтыг авалгүйгээр, түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдлыг сайтар судлалгүйгээр “түдгэлзүүлж болохгүй нөхцөл байхгүй” гэж дүгнэсэн алдаа гарч байна.

Мөн хуулийн 45 дугаар зүйлд хуульд тусгайлан заасан тохиолдолд түдгэлзүүлэхгүй тохиолдлууд, түүнчлэн “хэм хэмжээ тогтоосон акт” –ыг зөвхөн хуульд зааснаар түдгэлзүүлэхээр заасан тул тухайн маргаанд хамаарах материаллаг хуулийн зохицуулалтыг сайтар шүүж нягталсны эцэст маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэж байх нь зүйтэй.

Иймээс шүүх хуульд түдгэлзүүлж болохгүй гэж зааснаас бусад тохиолдолд маргаан бүхий захиргааны актын биелэлтийг хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд түдгэлзүүлэх нь хуульд нийцэхээс гадна нэхэмжлэгч нэхэмжлэлээ шүүхээр шийдвэрлүүлж дуустал уг актыг биелүүлэх үүрэггүй, хариуцагч уг актаа хэрэгжүүлэх эрхгүй болж, маргаан бүхий захиргааны акт хэрэг хянан шийдвэрлэж дуусах хүртэл хугацаанд даамжирсан сөрөг үр дагавар үүсгэхгүй байх ач холбогдолтой.

Хуулийн 46 дугаар зүйл. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл

Хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтад захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөлүүдийг тоочсон байна.

46.1.1 дэх заалтын “ноцтой”, “илт” хохирол учруулахаар гэдгийг шүүх актыг түдгэлзүүлснээс үүдэх хохирол, түдгэлзүүлэхгүй байх тохиолдолд гарах хохирлын хэмжээг харьцуулан тогтоосны үндсэн дээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэхээ шийдвэрлэнэ. Иймд ийнхүү тогтоохын тулд хэргийн оролцогчдын тайлбар, холбогдох нотлох баримтуудыг авч, харьцуулан судлах түүндээ тулгуурлан үндэслэл бүхий дүгнэлт хийх зэрэг тодорхой ажиллагаануудыг хийх шаардлага гарна.

Ингэхдээ захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдлыг зарим хуульд тусгайлан заасан байдгийг анхаарах хэрэгтэй. Жишээлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т “Тендер шалгаруулалттай холбогдох гомдлыг хүлээн авсан шүүх энэ хуулийн 55.4.1-55.4.3-т зааснаас бусад тохиолдолд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг түдгэлзүүлэхийг хориглоно” гэж заасан байна. Энэ тохиолдолд мөн хуулийн 55.4.1-55.4.3-т заасан нөхцөл байдал байгаа эсэхийг давхар шалгаж тогтоосны дүнд захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх шаардлагатай болно.

Хуулийн 46.1.2-т зааснаар татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй. Учир нь шүүхэд хэлэлцэгдэж байгаа маргаан бүхий акт хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдвол Татварын ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь “Татвар төлөгчийн үндэслэлгүй, илүү хураагдсан хөрөнгийг татварын алба энэ хуулийн 59.1.1-59.1.3-т заасан шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор буцаан олгоно” гэсэн заалтын дагуу мөн хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д “татварын алба, татварын улсын байцаагчийн буруугаар татвар төлөгчөөс үндэслэлгүй, илүү хураасан татварт алданги тооцох”, мөн зүйлийн 60.3.2-д “татвар

төлөгчөөс үндэслэлгүй, илүү хураасан мөнгөн хөрөнгөд алданги тооцох хугацааг уг хөрөнгийг татварын алба, татварын улсын байцаагчийн буруу шийдвэрээр татвар төлөгчийн данснаас авсан өдрөөс буцаан олгох буюу татварын өрөнд суутгах хүртэлх хоногийн тоогоор” гэж заасны дагуу тооцон үндэслэлгүй ногдуулсан татвар, төлбөрийг буцаан олгох хууль зүйн боломжтой тул маргаан бүхий актыг түдгэлзүүлэх шаардлагагүй юм.

Энэ зохицуулалт нь татвар, төлбөр, хураамж төлөхөөр тогтоогдсон этгээдээс татварын актаар ногдуулсан татварын төлбөр төлөх хугацааг маргаан гаргах замаар үндэслэлгүйгээр удаашруулахаас сэргийлсэн, мөн төсвийн бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байлгах улс, нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан заалт гэж үзэж болно.

Захиргааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн болон уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр нь нийтийн эрх ашгийн үүднээс олон нийтийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилго, агуулгатай тул уг шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэхгүй байх үндэслэлтэй. Хэрэв энэ тухай захиргааны акт хууль бус гэж тогтоогдвол нэхэмжлэгчийн эрхийг шүүхийн шийдвэрээр сэргээн тогтоох боломжтой, мөн уг актын улмаас гарсан хохирлоо иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй юм.

---oo0oo---

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЗӨВЛӨМЖ

2012 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримт цуглуулах, үнэлэх шүүгчийн ажиллагааны тухай

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх нөхцөл нь нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагаанаас шууд хамаарах тул энэ талаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан алдаа зөрчлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд тулгуурлан судалж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд (цаашид ИХШХШТХ гэнэ) заасан зарчим, зохицуулалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх талаар арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор **ЗӨВЛӨХ нь**:

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30, 31 дүгээр зүйл, ИХШХШТХ-ийн 37, 40-45, 47-49, 51 дүгээр зүйлүүдэд нотлох баримтыг ойлгох, гаргаж өгөх, цуглуулах, үнэлэх журмыг тодорхой тусгажээ.

Дээрх хуулийн заалтууд болон түүнийг нэг бүрчлэн тайлбарласан Улсын Дээд шүүхийн:

- ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3, 40.5, 43 дугаар зүйлийн 43.8.1, 47 дугаар зүйлийн 47.10, 48 дугаар зүйлийн 48.2, 49 дүгээр зүйлийн 49.1, 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалтуудыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаарх 2002.07.24-ний өдрийн тогтоол №263,
- ИХШХШТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсгийг тайлбарлах тухай 2009.10.28-ны өдрийн тогтоол №30,
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, 31.8 дахь заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаарх 2006.07.03-ны өдрийн тогтоол №37,
- 2008.10.10-ны өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд нотлох баримт үнэлэх шүүгчийн ажиллагаа”,
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь гэрчийн мэдүүлэг”,

- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бичмэл нотлох баримт ба эд мөрийн баримт”,
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шинжээчийн дүгнэлт”,
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь зохигчийн тайлбар”,
- “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйлийг зөв хэрэглэх талаар” 2005.04.06-ны өдрийн №01, 2007.07.05-ны өдрийн зөвлөмжүүд /Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим/,
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарласан ном, эмхтгэлүүд /2009 он/ зэргийг захиргааны хэргийн шүүхийн шүүгч нар судалж үзэх, хуульд заасан журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, алдаа зөрчил гаргахгүй байх тал дээр дүгнэлт хийж, хэрэг хянан шийдвэрлэхдээ дараах асуудлуудыг анхаарч ажиллавал зохино.

Нэг. Нотлох баримт цуглуулах ажиллагааны талаар:

1.1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2-д зааснаар захиргааны хэргийн шүүх захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргээ биелүүлэхгүй байгаагаас алдаа зөрчлүүд гарч байна. Тухайлбал:

- Нэхэмжлэлийн шаардлагыг тодруулаагүй/захиргааны байгууллагын хэзээ гаргасан, ямар захиргааны актыг ямар үндэслэлээр хууль бус гэж хүчингүй болгохыг шаардаж байгаа, хууль бус актын улмаас түүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн гэж үзэж байгаа зэргийг/,
- шүүх хуралдааны явцад нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилж, маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгуулахаар шаардлага гаргасан байхад түүнийг тодруулж бичгээр аваагүй, өөрчилсөн, нэмэгдүүлсэн шаардлагыг шийдвэрлэхэд шаардлагатай, хамааралтай нотлох баримтыг цуглуулаагүй, хариуцагчид тайлбар гаргах боломж хугацаа олгоогүй, бичгээр хариу тайлбар гаргуулаагүй байх гэх мэт.

Иймд дээрх алдааг гаргахгүйн тулд нэхэмжлэлийн шаардлага тодорхой бус тохиолдолд түүнийг тодруулж авч байх, мөн нэхэмжлэгч шүүх хуралдааны шатанд нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэх, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ өөрчлөх зэргээр бичгээр биш амаар

тайлбар мэдүүлэг гаргасан тохиолдолд шинэ нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх шаардлага гарч ирнэ.

Энэ тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг нь тодруулан, түүнийг нь бичгээр баримтжуулан авч, хариуцагч, гуравдагч этгээдэд гардуулж, тэдгээрт хариу тайлбар гаргах боломж олгох, уг шаардлагыг шийдвэрлэхэд шаардагдах холбогдох нотлох баримтуудыг бүрдүүлэх зэрэг ажиллагааг журмын дагуу гүйцэтгэж байх.

“нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ өөрчлөх” гэдгийг үндсэн нэхэмжлэлийн шаардлагаа бүхэлд нь өөрчилж өөр шаардлага болгох гэдгээр ойлгох хэрэгтэй. Тухайлбал; шүүх хуралдааны шатанд нэхэмжлэгч дүүргийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгох гэсэн нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилж, Нийслэлийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгох гэх мэт.

Нотлох баримт цуглуулах, бүрдүүлэх ажиллагаа нь маргааны төрлөөс шалтгаалж өөр өөр байдаг тул шүүхүүд нийтлэг тохиолддог төрлийн маргааныг шийдвэрлэхэд зайлшгүй шаардагдах, цуглуулах нотлох баримт хийгдэх ажилбаруудын жагсаалтыг гаргаж ажиллах нь ач холбогдолтой, учир нь нотлох баримт цуглуулах ажиллагаа нь адил төрлийн харьцангуй давтамжтай хийгддэг. Жишээ нь: Газар, тендер, төрийн албаны маргаантай хэрэгт ямар нийтлэг нотлох баримтыг цуглуулах, бүрдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ямар ажиллагаа явуулах талаарх жагсаалт /Хавсралт 1, Хавсралт 2-ыг үзэх/-ыг ашиглах.

Энэхүү жагсаалт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хийгдэж болох ажиллагаа, тодруулж болох нөхцөл байдлыг тоймлон, тухайн төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэхэд зайлшгүй шаардагддаг гол хүчин зүйлс, баримтууд юу болохыг тодорхойлж өгөх ач холбогдолтой.

Түүнчлэн, бичгийн нотлох баримтыг шүүх хүлээн авахдаа эх хувь мөн эсэх, мөн хуулбарлаж ирсэн бол хуульд заасан шаардлага хангасан эсэхийг нягтлах, нотлох баримтыг байгууллага, албан тушаалтнаас хугацаа тогтоон шаардан гаргуулах, хэрэгт хавсаргахаар ирүүлсэн бичгийн нотлох баримт их хэмжээтэй /олон хавтас, хуудастай/ бол тэдгээрээс тухайн маргаанд хамааралтай, хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримтуудыг хэргийн болон бусад оролцогчдын саналыг харгалзан сонгож эх хувиар эсхүл, хуулбарлан хуульд зааснаар баталгаажуулан хавтаст хэрэгт хавсаргаж байх нь зүйтэй.

Ингэхдээ шүүх уг баримт бичгийг хэрэгт үдэх, эсхүл хэргээс тусад нь цаг хугацаа, дэс дараалал, хэргийн оролцогчдоос гаргасан байдал, агуулга /татварын төрлүүдээр гэх мэт/ зэргээр нь ангилж хавтаслан дугаарлаж,

товъёог хийх нь хэргийн оролцогчид тухайн маргааны талаарх цэгцтэй мэдээлэл авч мэтгэлцэх эрхээ бүрэн хэрэгжүүлэх болон нөгөө талаар шүүх хуралдааны бэлтгэлийг бүрэн хангах ач холбогдолтойг анхаарах.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эд мөрийн баримтыг шалгаж, үзлэг хийх, мөн түүнийг хамгаалах арга хэмжээ авч байх. Жишээлбэл: Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох сонгуулийн ажиллагааны дүрс бичлэг, дуу бичлэг зэрэг эд мөрийн баримтыг хүлээж авахдаа хуульд заасан журмын дагуу үзлэг хийж шалган, тэмдэглэл хөтлөн хүлээн авч, хамгаалах арга хэмжээ авч байх нь ач холбогдолтой.

Хэрэв маргааны зүйл болох газар болон баримт бичиг, эд материалын байдалд үзлэг хийх бол шүүх үзлэг хийх цаг хугацаа, газрыг товлох, бүх талуудыг оролцуулах боломжоор хангахаас гадна хуульд заасан журмыг баримталж байвал зохино.

Урьд шийдвэрлэгдсэн хэргээс тухайн хэрэгт нотлох баримт авах шаардлагатай тохиолдолд өөрийн шүүх дээр байгаа хэргээс тэмдэглэл үйлдэж хуулбарлан авч “хуулбар үнэн” гэсэн дардас дарж хэрэгт хавсаргах, харин өөр шүүхээс авах тохиолдолд албан бичиг хүргүүлэн зохих журмын дагуу шаардан авч хэрэгт хавсаргана.

Гэрчээс мэдүүлэг авах талаар:

- гэрчээс мэдүүлэг авахдаа асуулт асуух дэс дараалал, тодруулах зүйлээ тодорхойлох,
- гэрчийг шүүх хуралдаанд оролцохоос өмнө эсвэл шүүх хуралдаан дээр асуух эсэхээ шийдвэрлэх,
- гэрчийг асуухдаа хэргийн болон бусад оролцогчтой хувийн холбоо, харилцаатай эсэхийг урьдчилан судлах,
- гэрчийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж байх,
- гэрчийг асуухад захирамж гаргах шаардлагагүй.
- шүүх өөрийн санаачлагаар гэрчээс мэдүүлэг авахаас бусад тохиолдолд урьдчилан талуудад мэдэгдэж, гэрчээс асууж тодруулах зүйлийн талаар хэргийн оролцогчдоос саналыг нь авах.

Шинжээчийн дүгнэлт гаргуулах талаар:

- Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийг баримтлан шинжээчийг томилох, шинжээч томилсон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолдоо шинжээчид мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасан эрх, үүргийг нь танилцуулсан баримтыг хавсаргаж хүргүүлж байх,
- Шинжээчид зөвхөн тусгай мэдлэг шаардсан асуудлаар асуултаа тавьж байх /шүүх өөрийн хийх ёстой хууль зүйн асуудлаар

тухайлбал “татварын байцаагчийн акт хууль зүйн үндэслэлтэй эсэх” гэсэн асуултыг шинжээчид тавихгүй байх/,

- Шинжээчид тавьсан асуулт нь бүрэн биш, дутуу, ойлгомжгүй болсноос шалтгаалж дахин шинжээч томилох сөрөг үр дагавар гарахаас сэргийлэхийн тулд шинжээчид тавих асуултын талаар урьдчилан талуудаас саналыг нь авах,
- Талуудаас шинжээчийн дүгнэлтийн талаар санал гаргах боломж олгох үүднээс шинжээчийн дүгнэлтийг хэргийн оролцогчдод тухай бүрт шүүх хурлаас өмнө танилцуулж байх,
- Шинжээчийн дүгнэлтийг хүлээж авахдаа шинжээчид эрх, үүрэгтэй нь танилцуулсан баримтыг хавсаргаж ирүүлсэн эсэхийг шалгаж авах,
- Хэргийн оролцогчдоос бичмэл нотлох баримтад дүгнэлт гаргуулахаар шинжээч томилуулах хүсэлт гаргавал хэрэгт авагдсан ямар нотлох баримтуудад дүгнэлт гаргуулах хүсэлтэй байгааг тодруулах, тэдгээр нь хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой эсэх талаар дүгнэлт хийж, хүсэлтийг шийдвэрлэх,

Тусгайлсан мэдлэг шаардагдахааргүй бол шинжээч томилох хүсэлтийг хангахаас татгалзаж байх.

Шүүх шинжлүүлж дүгнэлт гаргуулахад шаардлагатай нотлох баримтыг хавтас хэргээс түүвэрлэн авч, шинжээч томилсон захирамжийн хамт хүргүүлж байвал зохино. Гэтэл шүүхүүд шинжилгээний байгууллагад хавтас хэргийг бүхэлд нь явуулж байгаа нь буруу, үүнийг зогсоох хэрэгтэй байна.

1.2. Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т “оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчийн нотлох баримт гаргаж өгөх, үнэлэхийг шүүхээс шаардах эрх”-тэй гэж заасныг анхаарах.

Энэ эрхийг талууд өөрийн шаардлага, татгалзлын үндэслэл болох нотлох баримтыг бүрдүүлэх болон бусад ажиллагааг гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргах замаар хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, талууд шинжээч томилуулах, үзлэг, туршилт хийлгүүлэх, гэрч оролцуулах гэх мэт хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг тогтоолгох тухай хүсэлтийг шүүхэд гаргаж шийдвэрлүүлдэг.

Нөгөө талаас хэргийн оролцогчид нотлох баримт гаргуулахыг шаардаж байгаа нь шүүхүүд хэрэгт шинээр авагдсан нотлох баримт бүрийг хэргийн оролцогчдод тухай бүр танилцуулж, тэднээс гаргаж байгаа санал, тайлбарыг тэмдэглэл хөтөлж авах, тэднийг нотлох баримт цуглуулах, судлан шалгах ажиллагаанд оролцуулдаггүйтэй холбоотой.

Талуудаас нотлох баримт цуглуулахтай холбоотой гарсан аливаа хүсэлтийг хамгийн боломжит богино хугацаанд судлан хүсэлтийг “хангах эсэх”-ийг шийдвэрлэх, ингэхдээ хүсэлтийг хэрэгсэхгүй болгож байгаа тохиолдолд үндэслэл шалтгаанаа тодорхой заасан захирамж, тогтоол гаргаж, түүнийг эс зөвшөөрсөн тохиолдолд гомдол гаргах эрхийг нь хангаж, хэргийн оролцогчдын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт эдлэх эрхийг хангаж байх нь зүйтэй.

Гэтэл шүүхүүд нотлох баримттай холбоотой хүсэлтийг хэрэгт авсан боловч хэрхэн шийдсэн нь тодорхойгүй, улмаар хүсэлтийг хангахгүй тохиолдолд хуулийн 90 дүгээр зүйлд зааснаар “гомдол гаргах эрхийг нь захирамж, тогтоолдоо заахгүй” байх эсхүл “гомдол гаргах эрхгүй” гэж заан гомдол гаргах эрхийг хязгаарлах нь буруу.

Нотлох баримтыг дараах 2 шаттайгаар цуглуулах боломжтой. Үүнд: (1) юуны түрүүнд -нэхэмжлэл, -хариуцагчийн татгалзал, болон гуравдагч этгээдийн тайлбар дахь үндэслэлүүдийг судалж, тэдгээрт заагдсан шаардлагаа дэмжиж буй, татгалзлаа үндэслэж буй баримтуудыг тодруулан гаргаж ирэх. Үүний дагуу уг баримтуудыг эхний ээлжинд цуглуулах арга хэмжээ авах.

(2) талуудын гаргасан, эсхүл гаргаж ирээгүй ч тухайн хэргийг шийдвэрлэхэд ямар нэгэн байдлаар ач холбогдолтойг “заасан” баримтуудыг цуглуулсан ч маргааны үйл баримтыг бүрэн тогтооход шаардлагатай өөр бусад баримт байгаа эсэхийг судалж тогтоох, тэдгээрийг шүүх өөрийн санаачлагаар цуглуулах ажиллагааг хийх.

Ийнхүү хэргийн болон бусад оролцогчдын санал, тайлбарыг сайтар судлаагүй, хайхрамжгүй ханддагаас оролцогчид, түүний өмгөөлөгч, төлөөлөгч нь нотлох баримт гаргаж өгөх, үнэлэхийг захиргааны хэргийн шүүхээс шаардах эрх нь зөрчигдөхөд хүрч болзошгүйг анхаарах хэрэгтэй байна.

Тиймээс хэргийн оролцогчдод энэхүү хуульд заасан “шаардах эрх”-ийг хэрэгжүүлэх үүднээс нотлох баримтыг тухай бүрд танилцуулж байх, шүүх нотлох баримт гаргуулах тухай хэргийн оролцогчдын хүсэлтийг хүлээж авахдаа ямар нотлох баримтыг хаанаас гаргуулах, хэрхэн олж болох, түүгээр ямар баримт, үйл ажиллагааг нотлуулахыг хүсч байгаа зэргийг тодруулах, тухайн нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу шаардан гаргуулах, тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолгүй, хамааралгүй нотлох баримт гаргуулахыг хүссэн болон, ямар нотлох баримтыг хаанаас гаргуулах нь тодорхойгүй, хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлтийг аль болох богино хугацаанд шүүгчийн захирамжаар шийдвэрлэж байхыг зөвлөж байна.

1.3. Мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт заасан нотлох баримт гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчиж олж авсан бичгийн баримтыг хүлээн авч, үнэлж, тэдгээрийг үндэслэн хэргийг шийдвэрлэсэн зөрчил гарч байна.

Тухайлбал: Хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтууд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2, 44.3-д заасан нотлох баримтад тавигдах хэлбэрийн шаардлага хангаагүй, нэхэмжлэгч тодорхой захиргааны акттай холбогдуулан нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэн гаргасан байхад хавтас хэрэгт эдгээр маргаан бүхий актын зарим нь авагдаагүй, авсан зарим нь нотлох баримтын шаардлага хангаагүй байх, орон нутгийн сонгуулийн хэрэгт тус баг хэдэн өрхтэй, санал хураалтад оролцсон иргэд нь тус багийн иргэн мөн эсэхийг тогтооход ач холбогдолтой нотлох баримтыг хэрэгт аваагүй байна.

Тиймээс хэрэгт цугларсан нотлох баримтууд тухайн хэрэгт хамааралтай, нотолгооны ач холбогдолтой эсэх, нотлох баримтыг хуулиар зөвшөөрөгдсөн болон хуульд заасан арга журмаар олж авсан эсэх, хуульд зааснаар баталгаажсан эсэх, нотлох баримтыг эргэлзээгүй, үнэн бодитой эсэхийг шалгаж байвал зохино.

1.4. Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7-д заасан “шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт зайлшгүй шаардагдвал хуралдааныг нэг удаа хойшлуулах” мөн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-д заасан “Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилох...шүүх хуралдааныг 14 хоногоор хойшлуулж” хэмээн шүүх хуралдааныг нотлох баримттай холбоотойгоор хойшлуулах тухай үндэслэлүүдийг заасан байдаг.

Энэхүү хуулийн зохицуулалтаас үзвэл захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх явцад хэргийн оролцогчдоос нэмэлт тайлбар авах, нотлох баримт нэмж бүрдүүлэх, хүсэлт гаргасан тохиолдолд энэ нь үндэслэлтэй гэж үзвэл шүүх хуралдааныг уг зүйлд заасан журмаар хойшлуулна.

Гэтэл шүүх нотлох баримт нэмж бүрдүүлэхтэй холбоотой үндэслэл заасан боловч хойшлуулсан хугацаанд уг ажиллагааг хийлгүйгээр шүүх хуралдааныг олон удаа хойшлуулах тохиолдол гарч байна. Энэ асуудал нь шүүх, шүүгчийн өөрийнх нь ажлын хариуцлагатай холбоотой байдаг. Хэдийгээр зарим тохиолдолд хэргийн оролцогчдоос хамаарч болох ч нэгэнт хэрэг үүсгэсэн тохиолдолд шүүгчээс хуралдааны бэлтгэлээ сайн хангаж, аль болох нотлох баримтаа хангалттай бүрэн дүүрэн цуглуулах нь түүний үүрэг гэдгийг анхаарвал зохино.

- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох үүргийн зарчимтай холбоотойгоор шүүгч хэрэгт хангалттай нотлох баримт цугласан эсэх, нэхэмжлэлийн үндэслэл тус бүртэй холбоотой нотлох баримтыг цуглуулсан эсэхийг цаг тухай бүр хэргийн материалтай сайтар танилцаж, судлах, хэрэгт хангалттай нотлох баримт цуглаагүй байхад шүүх хуралдааныг зарлахгүй байх, ямар “шинэ нотлох баримт” зайлшгүй шаардагдсан, энэ хэрэгт ач холбогдолтой зэрэг хойшлуулж буй үндэслэлээ, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид маш тодорхой зааж хугацааг боломжтойгоор тогтоох шаардлагатай.

1.5. Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8 дахь заалтын дагуу захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасч шийдвэрлэх зохицуулалттай.

Энэхүү зохицуулалтыг тэр бүр хэрэглэдэггүйгээс хавтаст хэрэг ач холбогдолгүй баримтуудаар дүүрсэн байдаг. Нөгөө талаасаа хэргийн оролцогчдод олон хуудас, их л материал байвал илүү нотолж байна гэсэн өрөөсгөл хандлагыг бий болгож байна.

Шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргээс хасч байх, ингэхдээ шүүх хуралдааны бус үед шүүгчийн захирамжаар, шүүх хуралдааны явцад тэмдэглэлд тусгах замаар тус тус шийдвэрлэх, хэрэгт авагдсан бүхий л баримтыг нэг бүрчлэн бусад нотлох баримттай нь харьцуулан шалгах, тэдгээрийг үнэлэгдэх нотлох баримтад тооцох эсэх, нотолгооны ач холбогдолтой эсэхийг дүгнэдэг байх.

Тухайлбал: Төрийн захиргааны албан хаагчийн сахилгын шийтгэл хүлээлгэсэн маргаантай холбогдуулан нэхэмжлэгчээс ирүүлсэн төрийн үйлчилгээний албан хаагч байхдаа байгуулж байсан хөдөлмөрийн гэрээ, олон жилийн өмнө шагнагдаж байсан шагнал урамшууллын талаарх баримт нь тухайн маргаанд ач холбогдолгүй тул түүнийг нотлох баримтаар авалгүйгээр буцаах, эсхүл хасвал зохино.

Нотлох баримтыг “нотолгооны ач холбогдолгүй” гэдгийг хэргийн оролцогчид өөр өөрийн байр сууринаас хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд шүүх уг заалтыг хэрэглэхдээ анхааралтай хандах хэрэгтэй.

Давхардсан нотлох баримтыг хэргийн нотлох баримтаас хасах, тухайлбал, Газрын маргаантай хэрэгт газар эзэмших захирамж, гэрээ, газрын төлбөр, кадастрын зураг, гэрчилгээний хуулбарыг хэргийн оролцогч тус бүр гаргаж өгсөн тохиолдолд нэг хувийг нь авч, үлдэх давхардсан баримтуудыг буцаах баримт үйлдэж, гаргаж өгсөн талд хүргүүлэх ажиллагааг хийж байх шаардлагатай.

1.6. Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.5 дахь заалтын дагуу хэргийн оролцогч болон оролцогч бус этгээдүүдээс нотлох баримт шаардах хэлбэр нь албан бичиг, албан бичгийн дагуу ирүүлэхгүй бол захирамж хэлбэртэй байж болно.

Уг албан бичигтээ шаардлагыг биелүүлээгүй, биелүүлэхээс санаатай татгалзсан гэм буруутай этгээдэд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар тодорхой бичиж тусгахын зэрэгцээ шаардлагыг эс биелүүлсэн, шүүхэд нотлох баримт гаргаж өгөөгүй этгээдэд хуульд заасны дагуу арга хэмжээ авч байвал зохино.

Харин шүүх дээрх ажиллагааг явуулсан ч нотлох баримт ирүүлэхгүй байгаа тохиолдолд албадан гүйцэтгүүлэх захирамжийн дагуу шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан биелүүлэхээр гүйцэтгэх хуудас бичиж, уг ажиллагааг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183, 185-187 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан арга журмаар хийнэ.

Хоёр. *Нотлох баримт үнэлэх ажиллагааны талаар:*

Шүүх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цуглуулсан нотлох баримтуудыг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулалт хийх замаар зөв үнэлэлт өгөх нь чухал бөгөөд урьдчилаад хэрэгт авагдсан нотлох баримт нь үнэн, гарцаагүй хэмээн итгэх нь иргэн, хуулийн этгээдийн эрхийг зөрчих, “шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх” хуулийн шаардлагыг хангахгүй.

Нотлох баримтын үнэлгээг зөвхөн шүүх хийх боловч хэргийн оролцогч нотлох баримтыг хэрхэн үнэлэх талаар саналаа гаргах эрхтэй. Хуулийн холбогдох заалтын дагуу хэргийн оролцогчид нотлох баримт гаргаж өгөх, тэдгээрийг шинжлэн судлах болон шүүхийн мэтгэлцээний явцад нотлох баримтад өөрийн үнэлгээ дүгнэлтийг өгөх эрхтэй.

Нотлох баримтуудын хангалттай байдал ба хоорондын холбоог гаргаж ирэхийн тулд шүүх нотлох баримт бүрийн харьцангуй, боломжит, үнэн зөв байдлыг үнэлэх хэрэгтэй. Ингэхдээ аль нэгэн нотлох баримтын үнэн зөв гэдгийг шүүх бусад бүхий л нотлох баримтуудтай харьцуулан үзэж дүгнэлт гаргах ёстой.

Хуульд заасан “нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан” үзнэ гэдэг нь цугларсан баримтыг харилцан хамааралд нь цогцоор нь судалж, үнэлнэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл нотлох баримт бүрийн талаар бусад баримттай уялдуулж үнэлгээ өгөх ёстой. Шүүх тухайн баримтыг бусад нотлох баримттай хэрхэн дүйцэж байгаа, тэдгээрийн хооронд ямар

уялдаа холбоо байгаа, баримтууд бие биенээ үгүйсгэж байгаа эсэх, нэг үйл баримтыг давхар нотолж байгаа, эсхүл няцааж байгаа эсэхийг тус бүрд нь шалгадаг тул “бодитойгоор харьцуулан үзнэ” гэсэн ойлголт нотлох баримтыг тал бүрээс үнэлэх ажиллагааны нэг хэсэг болдог.

Нотлох баримтын үнэлгээний бүх үзүүлэлтүүд тэгш байх шаардлагатай, хэрэв нэгийг нь нөгөөгөөс илүү гэж үзэх нь нотлох баримтыг үндэслэлгүйгээр, хэрэг шийдэхээс өмнө хасах, ач холбогдлыг үгүйсгэх явдалд хүргэх бөгөөд ингэснээр шийдвэр үндэслэлтэй гарахад сөргөөр нөлөөлдөг. Гэтэл шүүхүүд нотлох баримт үнэлэх ажиллагаанд ач холбогдол өгдөггүй, анхааралтай ханддаггүй, хэрхэн яаж үнэлсэнээ тодорхой тайлбарладаггүй зэрэг нь энэхүү үйл ажиллагааг зохицуулсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан журмыг зөрчсөн алдаа гаргахад хүргэж байна.

Тухайлбал: - хариуцагчаас шүүхэд ирүүлсэн нотлох баримт нь шүүхээс тухайн газрын архивт үзлэг хийхэд уг нотлох баримт байхгүй байсан, мөн шүүхэд хуулбарлаж ирүүлсэн нотлох баримтаас нь өөр баримтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд хариуцагч гаргаж ирүүлсэн.

- хэргийн оролцогчдын тайлбар, хэргийн нөхцөл байдлыг үнэлж, дүгнэлгүйгээр, зөрүүтэй нотлох баримтад үндэслэн түүнд газар эзэмшүүлсэн шийдвэр гаргасныг “хуульд нийцсэн, бусдын эрх, зүй ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй шийдвэр” гэж буруу дүгнэсэн.

Иймд шүүх хэргийн оролцогчдын гаргаж өгсөн болон өөрөө цуглуулсан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзэхийн зэрэгцээ нотлох баримтыг үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлэх ёстой.

Гэрчийн мэдүүлгийг үнэлэх талаар: Сонирхлын зөрчилтэй гэрчийн мэдүүлгийг эргэлзээгүй нотлох баримт гэж үзэхгүй байх, тухайлбал нэхэмжлэгч Б ажлын байранд удаа дараа согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн талаар гэрчүүдийн мэдүүлэг зөрүүтэй байхад шүүх нэхэмжлэгчийг зөрчил гаргасан гэж дүгнэх боломжгүй, харин өөр бусад баримтаар уг үйл баримтад дүгнэлт өгөх шаардлагатай.

Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх талаар: Шинжээчийн дүгнэлтийг бусад нотлох баримтуудаас давуу байдалтайгаар үнэлэх, хэт илүүд үзэх нь буруу бөгөөд бусад нотлох баримтуудтай ижил түвшинд тавьж, харьцуулж үнэлэх шаардлагатай.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасныг зөрчиж газрын маргаантай хэрэгт хариуцагч сумын Засаг даргатай ажил, албан тушаал, чиг үүргийн хувьд “албаны сонирхол” бүхий этгээд болох сумын Засаг даргын тамгын газрын Газрын даамлыг

шинжээчээр томилсон, түүнчлэн шинжээчээр томилогдсон уг этгээдийг хариуцагч итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсон байсныг шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулсан зэрэг зөрчил гарсан байна.

Шүүхүүд хавтас хэрэгт авагдсан нотлох баримтуудаас шийдвэрийг дэмжсэн нотлох баримтуудыг үнэлээд (хэрэглээд), хэрэгт авагдсан бусад буюу тухайн шийдлийн эсрэг агуулга бүхий баримтуудын талаар дүгнэлт хийлгүй орхидог нь “нотлох баримт”-тай холбоотой гомдол гаргах нийтлэг үндэслэл болдог.

Жишээ нь: Нэхэмжлэлийг хангаж байгаа тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг дэмжсэн баримтуудыг зааж, тэдгээр баримтаар нэхэмжлэл үндэслэлтэй болох нь тогтоогдсон хэмээн дүгнэсэн боловч хариуцагчийн татгалзлыг дэмжиж буй өөр бусад баримтууд нь яагаад үнэлэгдэхгүй (хэрэглэгдэхгүй, ач холбогдолгүй) байгаа, эсхүл хэрхэн няцаагдаж байгааг тодорхойлж бичдэггүй.

Зүй нь шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож байгаа тохиолдолд: нэхэмжлэгчийн гаргаж буй нотлох баримтууд нь яагаад нэхэмжлэлийг хангахад хүрэлцээгүй, хангалтгүй болсныг болон эсрэг шийдлийг дэмжиж буй нотлох баримтыг няцааж чадахгүй байгааг тодорхойлон бичвэл зохино.

Анхан шатны шүүхүүдийн нотлох баримт үнэлэх ажиллагаанд нийтлэг тохиолддог бас нэг алдаа нь чухам аль нотлох баримтаар маргаж байгааг үйл баримтын юу нь хэрхэн, яаж нотлогдоод байгааг бичихгүй, олон тооны баримтын нэр заагаад эдгээрээр нотлогдож байна гэж ерөнхийд нь бичдэг явдал юм. Гэтэл тэдгээр баримтууд дотор нь шүүхийн нотлоод байгаа гэх “байдлын” эсрэг агуулгатай баримт ч байх тохиолдол байдаг тул хэргийн оролцогчид гомдох нь олонтоо байдаг.

Тиймээс шүүх нотлогдож байгаа гэх “үйл баримтыг нотлоод байгаа” баримтаа шууд нэрлэн заах шаардлагатай төдийгүй хэрхэн яаж нотолж байгаа гэж үзэж байгаагаа тайлбарлаж бичих нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3, 72 дугаар зүйлийн 72.4-д зааснаар шүүх шийдвэртээ хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, захиргааны актын хууль зүйн үндэслэлийг тодорхой тусгаж байх гэсэн шаардлагыг хангах үндэс болох юм.

Жишээ нь: Нэхэмжлэгч “газар давхцуулсан, дуудлага худалдаа явуулаагүй, төлөвлөгөөнд тусгаагүй, орц гарц хаасан, хүсэлтээ хуульд заасны дагуу гаргаагүй тул “АХ” ХХК-д газар эзэмшүүлсэн Нийслэлийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгуулах” шаардлага гаргасан тохиолдолд шүүх “тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хүсэлт гаргах үеийн баримтууд, газар зохион байгуулалтын зураглал (ямар хэлбэр,

хэмжээтэй, хаанаа орц гарцтай байхаар зөвшөөрөгдсөнийг тогтооход ач холбогдолтой), уг газарт урьд өөр өртгээдэд газар эзэмшүүлсэн эсэх, дуудлага худалдаа явуулах шийдвэр байгаа эсэх” зэрэг баримтуудад үндэслэж тухайн шинээр эзэмших эрх олгогдсон газар нь төлөвлөгөөнд тусгагдсан эсэх, нэхэмжлэгчийн эзэмшил газартай давахцсан эсэх, дуудлага худалдаа явуулах аргаар эрх олгогдох ёстой эсэх, тийм бол дуудлага худалдаа явуулсан эсэх, орц гарцыг хаасан эсэх зэрэг энэ маргааныг шийдвэрлэхэд тогтоогдвол зохилтой үйл баримтыг тодорхойлж гаргаж ирэх ёстой.

Нөгөөтэйгүүр, зарим шүүх, шүүгч хэрэгт авагдсан баримтуудыг огт үнэлэхгүй, үйл баримтад өөрөө дүгнэлт хийхгүй гагцхүү “захиргааны акт хуульд нийцсэн”, эсхүл “нэхэмжлэгчийн эрх зөрчигдөөгүй” гэсэн хийсвэр, өгүүлбэр бичиж хэргийг шийдвэрлэж байгаа тохиолдол гарч байна. Жишээ нь: татварын маргаантай нэгэн хэрэгт талууд 10 гаруй зөрчлийн асуудлаар маш тодорхой үндэслэл тайлбар, тэдгээрийг нотлох баримтыг гарган мэтгэлцэж байхад шүүх “зөрчлүүдийг жагсааж бичээд” эцэст нь татварын төлбөр ногдуулсан акт хууль зүйн үндэслэлтэй байна гэсэн ганцхан өгүүлбэр бичсэн тохиолдол гарсан.

Нотлох баримтыг үнэлэх ажиллагааг зөвхөн хэрэгт авагдсан нотлох баримтуудыг хооронд нь харьцуулж үнэлж дүгнэхээс гадна захиргааны акт гаргах үйл ажиллагаа, үйлдлийг зохицуулсан дүрэм, журам, заавруудыг нэг бүрчлэн судалж, маргааны үйл баримт түүнд нийцэж байгаа эсэх, хууль ёсны дагуу эсэхийг шалган тогтоож байх. Жишээ нь: Газрын маргаантай хэрэгт -Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм, Тендерийн маргаантай хэрэгт -Сангийн сайдаас баталсан Тендерийн үнэлгээний заавар, Тендерт оролцогчдод өгөх зааварчилга, төрөл бүрийн Тендерийн жишиг баримт бичиг, харин Төрийн албаны маргаантай хэрэгт -УИХ-аас баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилох ажилтныг сонгон шалгаруулах журам гэх мэт.

Нотлох баримт судлагдахуйц байх шаардлагыг хангах:

Бичмэл нотлох баримт нь уншигдахгүй, хуулбарлахдаа хуудасны тал хэсэг, дээд доод талыг дутуу хуулсан, бүдэг тодорхой биш байх тохиолдол ялангуяа Улсын бүртгэлийн маргаантай хэрэгт түгээмэл тохиолдож байна. Тиймээс шүүх өөрөө хэрэгт баримт авах, хэргийн оролцогчдоос ирүүлсэн баримтыг авахдаа дээрх шаардлага хангагдаж байна уу гэдгийг шалгаж авч байх нь зүйтэй, хэрэв хангахгүй бол буцаах зэргээр шаардлага хангуулж авах ажиллагааг хийвэл зохино.

---ооОоо---

Хавсралт-1

Газар эзэмших, өмчлөх эрхтэй холбоотой захиргааны хэрэг
 Нотлох баримтын бүрдлийг шалгах хуудас

Бүрдүүлэх баримтын нэр	Хэрэгт авсан эсэх			Тайлбар	Хуудасны дугаар
	Тийм	Үгүй	Шаардлагагүй		
Хэргийн оролцогч • Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ • Иргэний үнэмлэх					
Төлөөлөл • Итгэмжлэл					
Тэмдэгтийн хураамж					
Өмгөөлөл • Гэрээ • Хүсэлт					
Маргаан бүхий акт					
Газар олголтын хувийн хэрэг					
Газар эзэмших хүсэлт, өмчлөхийг хүссэн өргөдөл, хавсаргасан баримтууд					
Шилжүүлэх бол гэрчилгээ хүчин төгөлдөр эсэх					
Шилжүүлэх хүсэлтэд хавсаргавал зохих баримтууд					
Барилгын байршил тогтоосон бол ерөнхий төлөвлөгөө					
Эскиз зураг					
Газрын төлбөр төлсөн баримт					
Кадастрын зураг					
Гэрээ					
Гэрчилгээ					

Шинээр газар өмчлөл хийгдсэн бол ГЗБ-н төлөвлөгөө					
Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө					
ГХБГЗЗГ-ын мэдээллийн сангийн лавлагаа /нэгж талбар/					
Хорооны засаг даргын тодорхойлолт					
Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр					
ҮХЭХ бүртгэлийн лавлагаа					
Google харах					

Хавсралт-2

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх хяналтын хуудас

Ажиллагааны нэр	Хийгдсэн эсэх	Тайлбар
Хэрэг үүсгэх		
Нэхэмжлэлийн хувь гардуулах		
• Эрх үүрэг тайлбарлах, баталгаажуулах	Нэхэмжлэгч	
	Хариуцагч	
	Гуравдагч этгээд	
• Хариу тайлбар авах	Хариуцагч	
	Гуравдагч этгээд	
Гуравдагч этгээдээр татах		
Нотлох баримт авах		
Хүсэлт, гомдол шийдэх		
Үзлэг хийх /маргаан бүхий газар, хороо, нийслэл, дүүргийн газрын албаны архивт/		
Гэрч асуух		
Шинжилгээ хийлгэх		
Даалгавар гүйцэтгүүлэх		
Фото зураг авах гэх мэт.		

ХОЁРДУГААР ХЭСЭГ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 сарын 31 өдөр Төрийн ордон, Улаанбаатар хот

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ
ШАТНЫ ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг байгуулж, байршил, нутаг дэвсгэрийн харъяаллыг дор дурдсанаар тогтоосугай:

Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харъяалал
Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2010 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 77

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**ШҮҮГЧИЙН ОРОН ТОО, ЦАЛИНГИЙН
ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай хууль батлагдсантай холбогдуулж тус шүүхийн шүүгчийн орон тоог Ерөнхий шүүгч 1, шүүгч 6 байхаар тогтоосугай.

2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг 716789 төгрөгөөр, шүүгчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг 659490 төгрөгөөр тус тус тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



**МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2011 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ
ШҮҮХИЙН ТӨСӨВ, БАЙР, ТАМГЫН ХЭЛТСИЙН АЖИЛТАН,
ШҮҮГЧИЙН ТУСЛАХЫН ОРОН ТООНЫ ТУХАЙ**

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай хууль, Шүүхийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.11, 63 дугаар зүйлийн 63.3, 63.4 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан ТОГТООХ нь:

1. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын хэлтсийн ажилтан, шүүгчийн туслахын орон тоог 1 дүгээр хавсралтаар, албан тушаалтнуудын ангилал, зэрэглэлийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн төсөв, цалингийн сан, байрны асуудлыг Монгол Улсын Засгийн газар болон холбогдох бусад байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхийг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга Ц.Зоригт даалгасугай.

ДАРГА

Ц.ЗОРИГ

ГҮЙЦЭТГЭХ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Н.ГАНБАЯР

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2011 оны
01 дүгээр сарын 05-ны өдрийн 05
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ
ШҮҮХИЙН ТАМГЫН ХЭЛТСИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН
АНГИЛАЛ ЗЭРЭГЛЭЛ

Д/д	Албан тушаалын		Албан тушаалын нэр
	Ангилал	Зэрэглэл	
1	Эрхэлсэн түшмэл	ТЗ-11	Тамгын хэлтсийн дарга
2	Дэс түшмэл	ТЗ-7	Тамгын хэлтсийн мэргэжилтэн
		ТЗ-5	Шүүгчийн туслах бөгөөд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга
		ТЗ-4	Мэдээлэл лавлагаа хариуцсан ажилтан
Мэдээлэл технологи /компьютер/-ийн мэргэжилтэн			
3	Удирдах албан тушаал	ТҮ-8	Нягтлан бодогч
4	Мэргэжлийн албан хаагч	ТҮ-5	Нярав
		ТҮ-5	Зарлага
5	Техникийн гүйцэтгэх албан хаагч	ТҮ-3	Жолооч
		ТҮ-3	Слесарь
6	Бага тушаалын албан хаагч	ТҮ-1	Үйлчлэгч
		ТҮ-1	Жижүүр

-oOo-



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

ХӨРӨНГӨ ГАРГАХ ТУХАЙ

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай хууль, Улсын Их Хурлын 2010 оны 77 дугаар тогтоол, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд шаардагдах 434,4 сая (дөрвөн зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гарган Монгол Улсын 2011 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусган батлуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
САНГИЙН САЙД

С.БАТБОЛД
С.БАЯРЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 03 дугаар
сарын 02-ний өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

БАЙГУУЛЛАГЫН БАЙРШЛЫН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын одоогийн байрлаж байгаа байранд байршуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2011 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 55

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн
албан тушаалд томилох тухай**

“Шүүхийн тухай” Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэндийн Цогтыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Мишигийн Батсуурь, Авирмэдийн Отгонцэцэг, Түндэвийн Энхмаа, Пүрэвдоржийн Соёл-Эрдэнэ нарыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2011 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 87

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгчийн
албан тушаалд томилох тухай**

“Шүүхийн тухай” Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтыг баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дэмбэрэлийн Батбаатар, Бямбаагийн Мөнхтуяа нарыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Доржгочоогийн Баатархүү, Эрдэмбилэгийн Лхагвасүрэн, Цолмонгийн Сайхантуяа нарыг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ


ГУРАВДУГААР ХЭСЭГ

2011 оны шүүн таслах ажиллагааны тоон мэдээ

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь 2011 оны 04 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар нийт **388** захиргааны хэрэг хүлээн авсан байна. Үүнд:

Анхан шатны шүүхийн шийдвэртэй **247** хэрэг, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжтай **101** хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргасан **5** хэрэг, бусад **9** хэрэг, нийт **362** хэргийг хянан шийдвэрлэж, **26** хэргийн үлдэгдэлтэй байжээ.

Нийт хүлээн авсан хэрэг



2011 оны 04 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар нэг шүүгч дунджаар **52** хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

2011 оны 04 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 22 хүртэл		
Хүлээн авсан хэрэг	Шийдвэрлэсэн хэрэг	Үлдэгдэл
388	362	26

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2011 оны 4 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 22-ны байдлаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийн тоон үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв.

1. Магадлал

Д/д	Анхан шатны шүүхийн нэр	Хурлаар шийдвэрлэсэн нийт	Үүнээс		
			Хэвээр үлдээсэн	Өөрчилсөн	Хүчингүй болгосон
1	Нийслэлийн захиргааны хэргийн шүүх	158	84	30	44
2	Архангай аймгийн ЗХШ	6	2	0	4
3	Баян-Өлгий аймгийн ЗХШ	10	5	2	3
4	Баянхонгор аймгийн ЗХШ	3	0	1	2
5	Булган аймгийн ЗХШ	5	2	2	1
6	Говь-Алтай аймгийн ЗХШ	2	0	1	1
7	Говь-Сүмбэр аймгийн ЗХШ	2	0	0	2
8	Дархан-Уул аймгийн ЗХШ	10	4	1	5
9	Дорноговь аймгийн ЗХШ	8	4	3	1
10	Дорнод аймгийн ЗХШ	1	0	0	1
11	Дундговь аймгийн ЗХШ	1	1	0	0
12	Завхан аймгийн ЗХШ*	0	0	0	0
13	Орхон аймгийн ЗХШ	9	5	0	4
14	Өвөрхангай аймгийн ЗХШ	4	0	0	4
15	Өмнөговь аймгийн ЗХШ	2	1	1	0
16	Сүхбаатар аймгийн ЗХШ	8	2	4	2
17	Сэлэнгэ аймгийн ЗХШ	5	1	1	3
18	Төв аймгийн ЗХШ	3	1	0	2
19	Увс аймгийн ЗХШ	3	1	2	0
20	Хөвсгөл аймгийн ЗХШ	4	0	0	4
21	Ховд аймгийн ЗХШ	1	0	0	1
22	Хэнтий аймгийн ЗХШ	2	1	1	0
	Нийт	247	114	49	84

*-Тус шүүх байгуулагдсанаас хойш Завхан аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр болон шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжтай хэрэг хянагдаагүй болно.

Дээрх хүснэгтээс харахад захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийдвэртэй **247** хэргийг хянан шийдвэрлэснээс шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн **46** хувь буюу **114** хэрэг, өөрчилсөн **20** хувь буюу **49** хэрэг, хүчингүй болгосон **34** хувь буюу **84** хэрэг байна.


Магадлалаар шийдвэрлэсэн хэрэг



■ Хэвээр үлдээсэн ■ Өөрчилсөн ■ Хүчингүй болгосон

1.1 Өөрчилсөн шалтгаан:

Магадлалаар аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн **49** шийдвэрт өөрчлөлт оруулснаас, **20** хэргийг нотлох баримт буруу үнэлсэн, **29** хэргийг хууль буруу хэрэглэсэн гэсэн үндэслэлээр тус тус өөрчлөлт оруулсан байна.



1.2 Хүчингүй болгосон шалтгаан:

Мөн магадлалаар анхан шатны шүүхийн **84** шийдвэрийг хүчингүй болгосноос нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу бүхэлд нь хангасан **16** хэрэг, анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан **50** хэрэг, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон **9** хэрэг, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан **9** хэрэг байна.




Үүнээс анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан 50 хэргийн хууль зүйн үндэслэлийг үзүүлбэл:

Д/д	Хууль зүйн үндэслэл	Тоо
1	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ноцтой дутагдал илэрсэн	1
2	Хэргийн оролцогч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулаагүй	1
3	ЗХХШТХ зөрчсөн нь шийдвэр гаргахад нөлөөлсөн	20
4	Хуулийн шаардлага хангаагүй нотлох баримтыг үндэслэсэн	10
5	Шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй	3
6	Нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн	14
7	Хууль бус бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэсэн	1
	Нийт	50

Нийт хянагдсан шүүхийн шийдвэрийн 133 хэрэг буюу 54 хувьд нь өөрчлөлт оруулж, хүчингүй болгосон байна.


Давж заалдах шатны журмаар хянагдаж буй захиргааны хэргийг маргааны төрлөөр авч үзвэл:



2. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж

д/д	Шүүхийн нэр	Хурлаар шийдвэрлэсэн нийт	Үүнээс		
			Хэвээр үлдээсэн	Өөрчилсөн	Хүчингүй болгосон
1	Нийслэлийн захиргааны хэргийн шүүх	76	43	4	29
2	Архангай аймгийн ЗХШ	1	1	0	0
3	Баян-Өлгий аймгийн ЗХШ	5	3	0	2
4	Булган аймгийн ЗХШ	2	1	0	1
5	Дархан-Уул аймгийн ЗХШ	1	1	0	0
6	Дорнод аймгийн ЗХШ	2	0	0	2
7	Дундговь аймгийн ЗХШ	2	0	0	2
8	Өмнөговь аймгийн ЗХШ	2	0	0	2
9	Хөвсгөл аймгийн ЗХШ	4	3	0	1
10	Сэлэнгэ аймгийн ЗХШ	1	1	0	0
11	Төв аймгийн ЗХШ	1	0	0	1
12	Орхон аймгийн ЗХШ	3	2	0	1
13	Увс аймгийн ЗХШ	1	0	0	1
	Нийт	101	55	4	42

Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол



Анхан шатны шүүхийн 101 хэргийн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянан шийдвэрлэснээс хэвээр үлдээсэн 54,4 хувь буюу 55 хэрэг, өөрчилсөн 4 хувь буюу 4 хэрэг, хүчингүй болгосон 41,5 хувь буюу 42 хэрэг тус тус хянан шийдвэрлэжээ.

3. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас магадлалыг хянасан

д/д	Шүүхийн нэр	Хурлаар шийдвэрлэсэн нийт	Хүсэлтийг хангасан	Хүсэлтийг хангаагүй
1	Нийслэлийн захиргааны хэргийн шүүх	5	0	5
	Нийт	5	0	5

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлт гаргасан **5** хэргийг хянан шийдвэрлэж хүсэлтийг хангахаас татгалзсан байна.

4. Бусад

Хэргийн оролцогчдоос давж заалдах гомдлоосоо татгалзсан тул шүүгчийн захирамжаар давж заалдах гомдол гаргаагүйд тооцсон **4** хэрэг, хүлээн аваад гомдол хэлэлцүүлэхээс татгалзсан **5** хэргийг буцаасан байна.


Гомдол хэлэлцүүлэхээс татгалзсан 55%

44% Давж заалдах гомдол гаргаагүйд тооцсон

Шүүгч тус бүрээр хүлээн авсан хэргийг хүснэгтээр харуулахад:

Д/д	Шүүгчдийн нэр	Нийт хүлээн авсан	Үүнээс шүүхийн шийдвэр, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж			Шинээр илэрсэн	Бусад	Үлдэгдэл
			Хэвээр	Өөрчлөлт	Хүчингүй			
1	Ц.Цогт	49	19	9	16	-	3	2
2	М.Батсуурь	66	32	9	15	1	2	7
3	Д.Батбаатар	50	20	8	20	-	-	2
4	Б.Мөнхтуяа	46	23	5	13	1	1	3
5	А.Отгонцэцэг	57	24	7	19	1	1	5
6	П.Соёл-Эрдэнэ	64	33	9	18	1	-	3
7	Т.Энхмаа	56	18	6	25	1	2	4
	Бүгд	388	169	53	126	5	9	26

Шүүхийн шийдвэр, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж



Шүүхийн шийдвэр, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж

Улсын Дээд Шүүхийн захиргааны хэргийн танхим давж заалдах шатны шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлж давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж байх үеийн тоон үзүүлэлтэй харьцуулбал:

Үзүүлэлт	УДШ-ийн Захиргааны хэргийн танхим 2010 онд	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2011 онд	Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
			2010 он	2011 он	зөрүү
Хүлээн авсан хэрэг	573	530*	-	-	-
Хурлаар хэлэлцэлгүй хариу өгсөн	23	12	-	-	-
Нийт шийдвэрлэсэн хэрэг	521	492	-	-	-
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	516	484			
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянасан	5	8			
Үүнээс	Хэвээр үлдээсэн	327	62,8	53,9	-8,9
	Өөрчлөлт оруулсан	57	10,9	13,4	+2,5
	Хүчингүй болгосон	137	26,3	32,7	+6,4
Үлдэгдэл	29	26			

*- Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2011 онд хянан шийдвэрлэсэн хэрэгт 2011 оны 01 дүгээр сараас 4 дүгээр сар хүртэлх хугацаанд Улсын Дээд Шүүхийн захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тоог нэмж оруулсан болно.

5. Хяналтын шатны шүүх хуралдаанаар магадлал хянагдсан байдал

Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн танхимд тус шүүхийн нийт **120** магадлал хянагдсан байна.

Үүнээс **63,3** хувь буюу **76** магадлал хэвээр үлдсэн байна. Өөрчлөлт орсон **9** хувь буюу **11** хэргийн **3** нь буюу **27,3** хувь нь магадалал дангаар, **8** буюу **72,7** хувь нь анхан шатны шүүхийн шийдвэрийн хамт өөрчдөгджээ. Мөн хүчингүй болсон **27,5** хувь буюу **33** магадлалын **11** буюу **33,3** хувьд нь анхан шатны шүүхийн шийдвэрийн хамт хүчингүй болсон байна.

Нийт хянагдсан магадлалын **44** буюу **36,5** хувьд нь өөрчлөлт орж, хүчингүй болсон байна.


Хяналтын шатны шүүх хуралдаанаар

	Хуулийн заалт	Тогтоолын төрөл	Заалт тус бүрээр	Хэсэг тус бүрээр	Нийт	Хувиар
Хэвээр	176.2.1	Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих	51	76	76	63.3%
		Магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих	25			
Өөрчлөгдсөн	176.2.2	Шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулах	8	11	11	09.1%
		Магадлалд нэмэлт өөрчлөлт оруулах	3			

Хүчингүй	176.2.3	Магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх	16	22	Хүчингүй	27.5%
		Магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, шийдвэрийг өөрчлөх	6			
	176.2.4	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгох	0	3		
		Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох	3			
	176.2.5	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаах	8	8		
		Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр давж заалдах шатны шүүхэд буцаах	0			
Нийт хянагдсан магадлал					120	100%


**2011 оны эрүү, иргэн, захиргааны хэргийн чанарыг
Давж заалдах шатны шүүхээр хянагдсан байдлаар
дүн мэдээгээр харьцуулсан судалгаа**

Шүүх	Хэргийн төрөл	Захиргаа		Эрүү		Иргэн	
	Шийдвэрийн төрөл						
Давж заалдах шатны шүүх	Хүлээн авсан	551		2159		1925	
	Хурлаар шийдвэрлэсэн	492		2032		1830	
	Хэвээр	265		1080		989	
	Өөрчилсөн	66	227	444	952	448	841
	Хүчингүй	161		508		393	



**2011 оны эрүү, иргэн, захиргааны хэргийн чанарыг
Хяналтын шатны шүүхээр хянагдсан байдлаар
дүн мэдээгээр харьцуулсан судалгаа**

Шүүх	Хэргийн төрөл		Захиргаа	Эрүү	Иргэн	
	Шийдвэрийн төрөл					
Хяналтын шатны шүүх	Хүлээн авсан		427	822	1135	
	Хурлаар шийдвэрлэсэн		324	704	861	
	Хэвээр		217	252	579	
	Өөрчилсөн	77	107	90	452	173
	Хүчингүй	30		362		109



----- о о О о о -----

Шүүн таслах ажиллагааны талаар болон шүүхийн удирдлага, зохион байгуулалтын ажлын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийн нэг чухал зорилт нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг байгуулах асуудал байсан бөгөөд УИХ-ын 2010 оны 12-р сарын 31-ний өдрийн хуулиар байгуулагдаж, 2011 оны 4-р сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаагаа албан ёсоор эхлэн ажиллаад 1 жил болж байна.

Энэ хугацаанд дотоод зохион байгуулалт, менежментийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөний 2011 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор “Давж заалдах журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүгч / илтгэгч шүүгч/, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн томилох хуваарь”, “Хэрэг автоматаар хуваарилах програм ашиглах заавар”-ыг тус тус баталж мөрдөн ажиллаж байна.

Тус шүүх “Хэрэг автоматаар хуваарилах програм”-аар анхан шатны шүүхийн шийдвэр, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан, мөн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас магадлалыг хянуулах тухай хүсэлтэй хэргийг хуваарилж байна. Энэ нь хэрэг тохиолдлын журмаар хуваарилагдах зарчмыг хангахад чухал бөгөөд шүүхийн хувьд шинэлэг ажил болсон гэж үзэж байна.

➤ “Хэрэг автоматаар хуваарилах програм ашиглах заавар”-ыг дөрөвдүгээр хэсгээс үзнэ үү.

Хуваарилах		Шүүгчид	
Нэхэмжлэлийн утга	Хуваарилагдсан шүүгчийн дугаар	Шүүгчийн хувийн дугаар	
Нэхэмжлэлийн утга: 1. "Ская" ХХК	<input type="checkbox"/> 6	1 - А.Отгонцэцэг	
Нэхэмжлэлийн утга: 2. Ж.Батаа	<input type="checkbox"/> 4	2 - М.Батсуурь	
Нэхэмжлэлийн утга: 3. Д.Жаргалсайхан	<input type="checkbox"/> 3	3 - Д.Батбаатар	
Нэхэмжлэлийн утга: 4. "Сонин" ХХК	<input type="checkbox"/> 7	4 - Т.Энхмаа	
Нэхэмжлэлийн утга: 5. А.Хасбаатар	<input type="checkbox"/> 1	5 - П.Соёл-Эрдэнэ	
Нэхэмжлэлийн утга: 6.	<input type="checkbox"/> 5	6 - Ц.Цогт	
Нэхэмжлэлийн утга: 7.	<input type="checkbox"/> 2	7 - Б.Мөнхтуяа	

Хуваарилсан: Мэдээлэл лавлагааны ажилтан: / Б. Анхбаяр /



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛГӨӨНИЙ ТОГТООЛ

2011 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Хуваарь тогтоох тухай

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 85 дугаар зүйлийн 85.2, 85.4, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, 78.2, 78.4, Шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.4.1-т заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 2011 онд мөрдөх “Давж заалдах журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүгч /илтгэгч шүүгч/, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүнийг томилох хуваарь”-ийг 1 дүгээр, “Хэрэг хуваарилах програм ашиглах заавар”-ыг 2 дугаар хавсралтаар, “Шүүгчдийн хувийн дугаар”-ыг зөвлөлгөөний тэмдэглэлд тусгаснаар тус тус баталсугай.
2. Энэхүү хуваарийг баталсан өдрөөс эхлэн 2012 онд мөрдөх хуваарийг Шүүгчдийн зөвлөлгөөний тогтоолоор шинэчлэн батлах хүртэл мөрдсүгэй.
3. Энэ хуваарь, зааврыг мэдээлэл лавлагааны ажилтан, шүүгчийн туслахуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын хэлтэст /А.Насандэлгэрт/ даалгасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧИД

Ц.ЦОГТ
М.БАТСУУРЬ
А.ОТГОНЦЭЦЭГ
П.СОЁЛ-ЭРДЭНЭ
Т.ЭНХМАА

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Захиргааны үйл ажиллагааны ерөнхий хууль”-ийн төслийг боловсруулж байгаатай холбогдуулан аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхүүдээс тус бүрийн шүүхийн практикийг судалсан судалгаа гаргуулж, уг хуулийн төсөлд оруулах саналыг авч нэгтгэн 2011 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 1/107 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан Захиргааны үйл ажиллагааны ерөнхий хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилагаар зохион байгуулагдсан “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганд тус шүүхийн шүүгч нар оролцсон бөгөөд “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт зургадугаар салбар хуралдаанд Ерөнхий шүүгч Ц.Цогт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим сэдвээр мэдээлэл хийж, хэлэлцүүлээ.

► Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ба мэтгэлцэх зарчим сэдэвт хэлэлцүүлгийг дөрөвдүгээр хэсгээс үзнэ үү.

Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай хууль батлагдаж, тус шүүх үйл ажиллагаагаа эхлүүлсэнтэй холбогдон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсэгт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан ба тус шүүхээс уг хуулийн төслийг боловсруулан Улсын Дээд шүүхээр дамжуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдөр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн 80 хувийн саналаар анхны хэлэлцүүлэгээр батлагдлаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг танилцуулах хэсэгт тус шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Цогт оролцов.

► Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дөрөвдүгээр хэсгээс үзнэ үү.

Тус шүүхээс Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Захиргааны хэргийн хөдөлгөөний стандартад оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар болон Хуульчийн эрх зүйн

байдлын тухай, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Улс төрийн намын тухай хуулиудын төсөлд тус тус санал хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар байгуулагдсан шүүх эрх мэдлийн шинэчлэлийн хүрээнд Шүүхийн багц хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт Ерөнхий шүүгч Ц.Цогт орж, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулахад ажилласан.

Мөн Ерөнхий шүүгч Ц.Цогт, шүүгч М.Батсуурь нар нь Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2011 оны 11, 20 дугаар тогтоолоор байгуулагдсан “Монгол Улсын шүүхийн тухай болон Шүүхийн захиргааны тухай” хуулийн, шүүгч М.Батсуурь “Хуульчийн эрх зүйн зүйн байдлын тухай” зэрэг хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2011 оны 8 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүд болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Одбаяр Улсын Их Хурлын гишүүн,
Хууль зүйн байнгын хорооны дарга

Гишүүд

Ц.Мөнх-Оргил Улсын Их Хурлын гишүүн

Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын гишүүн

Х.Тэмүүжин Улсын Их Хурлын гишүүн

С.Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн

Хоёр. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

П.Цагаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх

Г.Баясгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

О.Зандраа Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн шүүгч

Ц.Амарсайхан Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгч

Ц.Цогт Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч

Н.Ганбаяр Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга

Н.Тунгалаг Улсын Их Хурлын Тамгын газрын ахлах зөвлөх

С.Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны зөвлөх

М.Батсуурь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч

Г.Ганзориг Улсын ерөнхий прокурорын газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, судалгааны төвийн дарга

Г.Эрдэнэбат Улсын ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт хариуцсан Улсын ерөнхий прокурорын туслах, хууль цаазын итгэмжит зөвлөх

Ж.Энхнасан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрхлэгч

Г.Нямдэлгэр	Хууль зүйн байнгын хорооны референт
Ж.Баярцэцэг	Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлого хариуцсан туслах
Г.Оюунболд	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ОДБАЯР

Дэлхийн Банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”-өөс санхүүжүүлж, “Захиргааны хэргийн бүртгэл, мониторингийн програм хангамж”-ийг боловсруулж байгаа бөгөөд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс байгуулсан уг програм хангамжийн техникийн шаардлага боловсруулах ажлын хэсэгт Ерөнхий шүүгч Ц.Цогт, шүүгч П.Соёл-Эрдэнэ, шүүгчийн туслах Ч.Сэлэнгэмөрөн нар оролцон ажиллаж байна.

Хэрэг хянан шийдвэрлэх процессын бүх ажиллагааг хялбар шуурхай болгох үүднээс захиргааны хэргийн анхан шатны шүүхээс гаргах актын төрлийн жагсаалтыг гаргаж, аймгуудын захиргааны хэргийн шүүхийн шүүгч нараар актуудын жишиг загварыг боловсруулж ирүүлснийг ажлын хэсэг шалган уг програмд оруулахад бэлтгэж байгаа.



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2011 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Шүүхийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсгийг баримтлан ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн дэмжлэгтэйгээр Захиргааны хэргийн шүүхийн бүртгэл, мониторингийн програмыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар өөрчилсүгэй.

Зөвлөлийн ахлагч:

О.Зандраа Улсын Дээд шүүхийн Захиргааны
хэргийн танхимын тэргүүн

Нарийн бичгийн дарга:

Н.Дамдинсүрэн Улсын Дээд шүүхийн Захиргаа
хэргийн танхимын тэргүүний туслах

Гишүүд:

Л.Атарцэцэг Улсын Дээд шүүхийн Захиргааны
хэргийн танхимын шүүгч

Ц.Цогт Захиргааны хэргийн давж заалдах
шатны шүүхийн Ерөнхий шүүгч

П.Соёл-Эрдэнэ Захиргааны хэргийн давж заалдах
шатны шүүхийн шүүгч

Х.Батсүрэн Нийслэлийн захиргааны хэргийн
шүүхийн Ерөнхий шүүгч

С.Мөнхжаргал	Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч
Ч.Сэлэнгэмөрөн	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах
Г.Мөнхсайхан	Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн туслах
Т.Халтар	Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн ажилтан /тохиролцсоны дагуу/
Д.Мөнхзориг	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны мэдээлэл технологи автоматжуулалт хариуцсан референт

2. Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу Захиргааны хэргийн програм хангамжийн судалгаа хийх, сургалт зохион байгуулах, програмын стандарт боловсруулах, хэрэгжүүлэх, програм хангамжийг турших, нэвтрүүлэх, иргэний болон эрүүгийн хэргийн ажлын хэсэгтэй ажлаа уялдуулан ажиллах, ажлын явцын талаар зөвлөлд танилцуулж байхыг ажлын хэсэг /О.Зандраа/-т даалгасугай.

ДАРГА

Ц.ЗОРИГ

➤ Төсөл хэрэгжүүлэх гэрээг дөрөвдүгээр хэсгээс үзнэ үү.

“Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан” (www.shuukh.mn)-ийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Ерөнхий шүүгч Ц.Цогт орж ажиллаж, уг цахим санг ашиглалтад оруулахад бэлэн болоод байна. Тус шүүхээс захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн болон давж заалдах шатны шүүхийн 2011 оны шүүхийн шийдвэр, магадлалыг бүрэн оруулах ажлыг зохион байгуулаад байна.



**МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2011 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Шүүхийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсэгт заасныг баримтлан ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын нийт шүүхийн шийдвэр болон бусад эрх зүйн баримт бичгийг олон нийтэд нээлттэй байлгах зорилгоор холбогдох журмын төсөл боловсруулж, тэдгээрийг тусгай цахим хуудас бий болгон байршуулахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Н.Ганбаяр

ШЕЗ-ийн Гүйцэтгэх
нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Р.Мэндсайхан

ШЕЗ-ийн Ажлын албаны
Захиргааны Удирдлагын
тасгийн дарга

Гишүүд:

Ц.Цогт

Нийслэлийн захиргааны
хэргийн шүүхийн шүүгч

С.Жанхор

ШЕЗ-ийн Ажлын албаны
Санхүүгийн тасгийн дарга

Н.Сономдагва

Ерөнхийлөгчийн Тамгын газрын
референт /тохиролцсоноор/

Д.Мөнхзориг

ШЕЗ-ийн мэдээллийн технологи,
автоматжуулалт хариуцсан референт

Э.Баярбаатар	УДШ-ийн компьютерийн техник хангамж хариуцсан референт
Ч.Цэнд	УДШ-ийн Захиргааны хэргийн Танхимын Тэргүүний туслах
Ө.Уянга	УДШ-ийн Эрүүгийн хэргийн Танхимын Тэргүүний туслах
И.Амартөгс	УДШ-ийн Иргэний хэргийн Танхимын Тэргүүний туслах
Д.Оюунчимэг	УДШ-ийн Судалгааны төвийн ахлах мэргэжилтэн

2. Үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргад танилцуулж байхыг Ажлын хэсгийн дарга /Н.Ганбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЗОРИГ

21 аймгийн захиргааны хэргийн шүүхүүдтэй хийх онлайн видео сургалтад SKYPE програм ашиглах зөвлөмжийг боловсруулж, захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд хүргүүлж, бэлтгэл ажлыг ханган Хөвсгөл, Дархан-Уул аймгийн Захиргааны хэргийн шүүхтэй онлайн видео сургалтыг хийлээ.

Дараачийн ээлжид бусад аймгийн Захиргааны хэргийн шүүхүүдтэй онлайн видео сургалтыг хийхээр төлөвлөж байгаа.

➤ SKYPE програм ашиглах заавар, зөвлөмжийг манай шүүхийн цахим хуудаснаас үзнэ үү.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль Улсын Их Хурлын чуулганаар 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдөр батлагдаж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2011 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 25 дугаарт албан ёсоор нийтлэгдсэнтэй холбогдуулан уг хуулийн холбогдох заалтыг хэрхэн хэрэглэх талаар аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхүүдэд албан бичиг хүргүүлэв.



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ НАРТ

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
4-р хороо, Самбуугийн гудамж-211238
Утас: 98896414, 98896416
www.admincourt2.gov.mn

2011.07.09 № 1/203
танай _____-ны № _____

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай

1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль Улсын Их Хурлын чуулганаар 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдөр батлагдаж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2011 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 25 дугаарт албан ёсоор нийтлэгдсэн байна. Уг нэмэлт, өөрчлөлт оруулсан хуульд дагаж мөрдөх хугацааг 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдрөөс гэж заасан байна. Харин Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Шүүх ... хэрэг, маргаан гарах үед хүчин төгөлдөр болоогүй, албан ёсоор нийтлэгдээгүй хуулийг хэрэглэхгүй” гэж заажээ.

Иймд “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэгдсэнээс хойш буюу 2011 оны 7 дугаар сарын 04-ний өдрөөс Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүх хэрэглэх эрх зүйн үндэслэл бүрдэх тул мөн өдрөөс хойш захиргааны хэргийн шүүхэд гаргаж буй нэхэмжлэлтэй холбогдуулан төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын дагуу төлүүлэх нь зүйтэй болно.

2. Эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр өргөдөл, гомдол, нэхэмжлэл шүүхэд гаргахад Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “Эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд 70200 төгрөг”-ийн тэмдэгтийн хураамж төлүүлэхээр Улсын Их хурлын 2011 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан байна.

Иргэдээс захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахад төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг "70200 төгрөг" болгон шинэчлэн тогтоосон нь захиргааны үйл ажиллагааг хянуулахаар шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд зарим иргэдэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж болзошгүй болоод байна.

Захиргааны хэргийн шүүх маргааныг хянан шийдвэрлэх замаар захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас иргэдийн зөрчигдсөн эрхийг хамгаалж, сэргээн тогтоох үйл ажиллагаа явуулдаг.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д "Захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52-60 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ" гэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-т "Нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй болох нь түүний тайлбар, бусад нотлох баримтаар тогтоогдсон буюу хуульд заасан бусад үндэслэл байвал түүнийг улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс шүүгчийн захирамжаар чөлөөлнө" гэж тус тус заажээ.

Иймд иргэдийн шүүхэд хандах эрхийг хангах үүднээс улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлэхдээ шаардлагатай тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3-т заасан зохицуулалтыг аль болох хэрэглэж, иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг хамгаалах талаар анхаарах нь зүйтэй байна.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ НАРТ

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
4-р хороо, Самбуугийн гудамж-211238
Утас: 98896414, 98896416
www.admincourt2.gov.mn

2011.08.11 № 1/264

танай _____-ны № _____

Шүүхийн тогтоол, захирамжид гаргасан гомдлын тухай

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр өргөдөл, гомдол, нэхэмжлэл шүүхэд гаргахад “Эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд 70200 төгрөг”-ийн тэмдэгтийн хураамж төлүүлэхээр заажээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д заасан шүүгчийн захирамж, тогтоолд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахаар зохицуулсан боловч улсын тэмдэгтийн хураамж төлөх талаар тусгайлан зохицуулаагүй байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52-60 дугаар зүйлд зөвхөн “шийдвэрт” давж заалдах журмаар гомдол гаргах талаар зохицуулсан. Түүнчлэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д зааснаар “давж заалдах гомдол” гэдэгт зөвхөн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт гаргаж буй гомдлыг ойлгох бөгөөд мөн хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д заасан “гомдол” нь үүнд хамаарахгүй байна.

Өөрөөр хэлбэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д “Захиргааны хэргийн шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52-60 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын

дагуу шийдвэрлэнэ” гэж заасан бөгөөд дээрх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52-60 дугаар зүйлд зөвхөн шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргах талаар зохицуулсан байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90 1-д зааснаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нараас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргахад улсын тэмдэгтийн хураамж болох 70200 төгрөгийг төлүүлэхээр шаардах хууль зүйн үндэслэлгүй байна.

Иймд шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг урьдчилан төлүүлэх нь зүйтэй байна.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ

Захиргааны хэргийн хариуцагчаас хариу тайлбар авах, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах, давж заалдах гомдол хүлээн авах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зөвлөмж (албан бичиг) боловсруулж, захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдэд хүргүүлэв.



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ НАРТ

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
4-р хороо, Самбуугийн гудамж-211238
Утас: 98896414, 98896416
www.admincourt2.gov.mn

2011.07.19 № 1/214
танай _____-ны № _____

Давж заалдах гомдол хүлээн авах ажиллагааны тухай

Давж заалдах гомдлыг хүлээн авахдаа Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.2 дахь хэсэгт заасан шаардлагад нийцсэн эсэхийг нягтлан, аль шүүхэд ямар журмаар гомдол гаргаж байгааг шалгаж авч байх шаардлагатай байна.

Дээрх байдлыг шалгахгүйгээр Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гэж хаягласан гомдлыг хүлээн авч тус шүүхэд ирүүлснээр хэргийн оролцогчдын зүгээс давж заалдах шатны шүүх өөрт хаяглаагүй гомдлыг хүлээн авч шийдвэрлэх гэх мэт маргаантай байдлыг үүсгэж байна.

Иймд хэргийн оролцогчдод давж заалдах гомдлыг ямар шүүхэд гаргах талаар зөв тайлбарлан өгөх, гомдолд давж заалдах шатны шүүхийг буруу тодорхойлсон бол залруулах боломжийг олгох шаардлагатай байгааг анхаарна уу.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ НАРТ

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

4-р хороо, Самбуугийн

гудамж-211238

Утас: 98896414, 98896416

www.admincourt2.gov.mn

2011.10.10 № 1/372

танай _____-ны № _____

**Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны
талаар зөвлөмж хүргүүлэх тухай**

Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа дараах зүйлүүдийг анхаарч ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38 2 дахь хэсэгт “хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх эсэх тухайгаа шүүхэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй”¹ гэж заасан. Энэ заалтын дагуу хариуцагч өөрөө шүүхэд тайлбараа бичгээр гаргаж өгөх ёстой ба хууль тогтоогч шийдвэр гаргасан этгээдийн үндэслэл, тайлбарыг шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ харгалзах зайлшгүй шаардлагатай гэдэг үүднээс дээрх байдлаар зохицуулжээ

Захиргааны акт гаргана гэдэг нь төлөвлөх, бодлого боловсруулах, зорилгоо тодорхойлох, хувилбар гаргах, түүнийг үнэлэх, хэрэгжих үр нөлөөг судлах гэх мэт олон үе шаттай байдаг тул энэ бүх болсон процессыг шүүхэд бодитойгоор мэдүүлж чадах этгээд бол хариуцагч өөрөө болно.

Гэтэл хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүхэд тайлбар гаргаж өгснөөр хэргийн бодит байдлыг тогтооход хүндрэл учруулж байна. Тухайлбал тухайн маргаан бүхий асуудлыг хариуцах этгээд нь шүүхэд тайлбар өгөхгүй. харин түүний өмнөөс итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тайлбар

гаргаснаар бодит байдлаас зөрүүтэй тайлбар өгөх, эсхүл бодит байдлын талаар мэдээлэлгүй байх зэргээр нөхцөл байдал, маргааны үйл баримтыг бодитойгоор тогтоох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг алдагдуулж байна

Хариуцагч өөрөө нэхэмжлэлд тайлбар өгөх нь “мэдэгдэх ба сонсох” зарчим, тэгш эрхийн зарчмыг зохих ёсоор хэрэгжүүлэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг билээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч бус зөвхөн төлөөлүүлж буюу өмгөөлүүлж байгаа этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж буй этгээд мөн” гэж зааснаас үзэхэд хариуцагч өөрөө шүүхэд бичгээр тайлбар гаргаж ирүүлэх үүрэгтэй нь тодорхой байна. Түүнчлэн хариуцагч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан оролцогчийн хувьд хэргийн талаар бодитой тайлбар өгч чадах чадамжтай бөгөөд үүсэн гарах хариуцлагыг хүлээх этгээд болно.

Иймд цаашид Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийг хэрэглэхдээ хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс биш хариуцагчаас өөрөөс нь нэхэмжлэлийн тайлбарыг бичгээр авах нь зүйтэй байна

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт зааснаар шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179-182 дугаар зүйлд заасан журмыг баримтлахаар зохицуулсан. Улмаар мөн хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар дээрх хүсэлтийг шийдвэрлэсэн тогтоолд гомдол гаргаж болох талаар заагаагүй байна

Мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1 дэх хэсэгт заасан тогтоол, захирамжийн дотор шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг шийдвэрлэсэн тогтоол багтаагүй болно.

Эндээс дүгнэхэд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг шийдвэрлэсэн тогтоол нь эцсийн шийдвэр байх бөгөөд түүнд хэргийн оролцогчид гомдол гаргах эрхгүй байхад анхан шатны шүүхүүд дээрх хэргийг “давж заалдах гомдлын дагуу” хэмээн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд ирүүлж байгаа нь буруу байна.

Иймд цаашид шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг шийдвэрлэсэн тогтоолд “уг тогтоол эцсийн шийдвэр” гэдгийг дурьдаж, хэргийн оролцогчдод гомдол гаргах эрхгүй тухай хуулийн зохицуулалтыг сайтар тайлбарлан өгч байх нь зүйтэй.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ

Хэрэг, материалыг хуулийн хугацаанд шуурхай хянан шийдвэрлэх талаар зохион байгуулалтын дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, үр дүнд хүрч ажиллаж байна. Үүнд:

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хэрэглэгдэх “Магадлал, Тогтоол боловсруулах”, “Хэргийг илтгэн танилцуулах дараалал”-ын загварыг Ерөнхий шүүгчийн 2011 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 3/06 тоот захирамжаар батлан мөрдөж ажиллаж байна.



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2011 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 3/06

Улаанбаатар хот

Шүүн таслах ажиллагааны зохион байгуулалтыг хангах тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, шүүгчийн туслахуудын шүүн таслах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах зорилгоор Шүүхийн тухай хуулийн 37¹ дугаар зүйлийн 37¹.1.4-т заасныг удирдлага болгон **ЗАХИРАМЖЛАХ нь:**

1. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хэрэглэгдэх “магадлал боловсруулах загвар”-ыг 1 дүгээр, “тогтоол боловсруулах загвар”-ыг 2 дугаар, “хэргийг илтгэн танилцуулах дарааллын загвар”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх загваруудыг магадлал, тогтоол боловсруулах, хэргийг илтгэн танилцуулах үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг шүүгч нарт зөвлөсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ

➤ Хэргийг илтгэн танилцуулах дараалал хавсралт дөрөвдүгээр хэсгээс үзнэ үү.

Давж заалдах шатны журмаар хянагдаж байгаа бүх хэргүүдэд шүүгч, шүүгчийн туслах нар “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шалгах ажилбар” /check list/ хийж, түүн дээр үндэслэн шүүхийн практикийг нэгтгэн судалж байна

➤ “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шалгах ажилбар”-ыг дөрөвдүгээр хэсгээс үзнэ үү.

Захиргааны хэргийг хуульд заасан хугацааны дотор товлон зарлаж, шийдвэрлэж байгаа эсэх, шүүх бүрэлдэхүүнийг “Давж заалдах журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэх илтгэгч шүүгч, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүнийг томилох хуваарь”-ийн дагуу томилогдож байгаа эсэхийг хянах зорилгоор сар бүр шүүгч тус бүрийн бүрэлдэхүүнд орсон байдал болон хуулийн хугацаанд хуралдааныг товлон зарлаж байгаа эсэх талаар хэрэг хянан шийдвэрлэсэн хугацааны талаарх мэдээллийг гаргуулан авч судалж үзэж байна.

Хэргийн оролцогчдын санал хүсэлт, шүүх хуралдаанд оролцож буй оролцогчдыг удаан хүлээлгэх хүлээлт үүсгэхгүйн тулд манай шүүх нь долоо хоног бүрийн Лхагва, Пүрэв гарагт давж заалдах шатны шүүх хуралдааныг товлон зарлаж, хуралдааны цагийг үдээс өмнө, үдээс хойш тус бүр 2 удаа /09³⁰, 11³⁰, 14³⁰, 16⁰⁰ цагт/ хийж байхаар өөрчлөн зохион байгууллаа.

----- о о О о о -----



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2011 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 3/09

Улаанбаатар хот

Шүүх хуралдааны бэлтгэл ажиллагааг хангах, зохион байгуулах тухай

Шүүхийн тухай хуулийн 37¹ дугаар зүйлийн 37^{1.1.4}-т заасныг удирдлага болгон **ЗАХИРАМЖЛАХ нь:**

1. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг 7 хоног бүрийн Лхагва, Пүрэв гарагт хийж байхаар зохион байгуулсугай.

2. Давжзаалдах шатны шүүхийн шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаа, зохион байгуулалтын ажлыг илтгэгч шүүгчийн туслах хариуцаж, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар оролцуулж байхаар тогтоосугай.

3. Шүүгчийн туслахууд шүүх хуралдааны зарыг хуралдаан болохоос 7 хоногийн өмнө гаргах бөгөөд түүнийг "Шүүхийн мэдээллийн самбар" болон цахим хуудсанд байрлуулахыг Мэдээлэл лавлагааны ажилтан болон Мэдээлэл технологийн мэргэжилтэнд тус тус даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Ерөнхий шүүгчийн 2011 оны 04 сарын 11-ний өдрийн 03 дугаар захирамжийг хүчингүй болгосугай

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын хэлтсийн мэргэжилтэн /М.Цэцэгмаа/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдаанаас Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон тохиолдолд үндэслэл шалтгааны талаар 7 хоног бүрээр судалгаа бүрдүүлж, Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоолыг шүүгч, шүүгчийн туслах нарт танилцуулан ажиллаж байна.

Тамгын хэлтийн даргын 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 41 дүгээр тушаалаар “Шүүхийн хэвлэл, мэдээллийн төлөөлөгч”-ийг томилон ажиллуулж байна. Хэвлэл, мэдээллийн төлөөлөгч нь өдөр тутмын сониноос өөрийн шүүх болон захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдтэй холбоотой мэдээллийг түүвэрлэх, тус шүүхээр хянагдсан хэргийн талаарх мэдээллийг олон нийтийн телевиз, радиод тус шүүхийг төлөөлж мэдээлэл өгөх чиг үүрэгтэй ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль батлагдаж шинээр хэрэгжүүлж ажиллаж байгаа тул уг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлсан төлөвлөгөө гарган ажиллаж байгаа.

----- о о О о о -----

2011 онд захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, шүүгчийн туслах нарт зориулсан бүсчилсэн сургалтын тойм

Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдээс “Анхан шатны шүүхүүдийн шийдвэрлэж байгаа хэргийн шийдвэр өөрчлөгдөж, хүчингүй болж байгаа шалтгаан нөхцөл, анхаарах асуудал”-ын талаар практик судалж сургалт явуулах, Газрын тухай хууль болон Төрийн албаны тухай хууль” зэрэг чиглэлээр ирүүлсэн нийт 22 багц санал болон шүүн таслах ажлын үр дүнд тулгуурлан Нийслэлийн захиргааны хэргийн шүүх болон 21 аймгийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслахуудад зориулсан бүсчилсэн сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Үүнд: Баруун бүсийн Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Завхан аймгуудын захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслах нарт зориулсан сургалт 2011 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Ховд аймагт,

Төвийн бүсийн Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслах нарт зориулсан сургалт 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Архангай аймагт,

Хойд бүсийн Сэлэнгэ, Эрдэнэт, Булган аймгуудын захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслах нарт зориулсан сургалт 2011 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Дархан-Уул аймагт,

Зүүн бүсийн Төв, Дорнод, Сүхбаатар аймгуудын захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслах нарт зориулсан сургалт 2011 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Хэнтий аймагт,

Говийн бүсийн Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслах нарт зориулсан сургалт 2011 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Дундговь аймагт,

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслахууд нартай хамтарсан уулзалт, ярилцлага 2011 оны 12 дугаар сарын 19-ны өдөр тус тус амжилттай зохион байгуулсан.

Сургалтад тус шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Цогт, шүүгч М.Батсуурь, шүүгч Д.Батбаатар, шүүгч Б.Мөнхтуяа, шүүгч А.Отгонцэцэг, шүүгч П.Соёл-Эрдэнэ, шүүгч Т.Энхмаа, Тамгын хэлтсийн дарга А.Насандэлгэр, мэргэжилтэн М.Цэцэгмаа, шүүгчийн туслах Ж.Даваасүрэн нар оролцов.

1. “Газар, төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбогдон үүсч буй захиргааны эрх зүйн маргаантай хэрэг /шүүхийн практик/” сэдвийн хүрээнд:

- Газар эзэмших (ашиглах), газар өмчлөх эрх үүсэх, өөрчлөгдөх, баталгаажих, дуусгавар болох, бусдад шилжих, хүчингүй болохтой

холбогдон үүсч буй захиргааны эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд тулгарч буй нийтлэг асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх.

- Төрийн алба хаах болон үүнтэй холбоотой бусад эрхээ хэрэгжүүлэх явцад үүсч буй захиргааны эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд тулгарч буй нийтлэг асуудлууд болон энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарвал зохих асуудлуудыг хөндөх, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх.

2. “Анхан шатны шүүхийн шийдвэр болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал” сэдвийн хүрээнд:

- Нэхэмжлэл хүлээн авах
- Хэргийн оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхойлох
- Нотлох баримтыг цуглуулах
- Захиргааны хэргийн нотлох баримтыг үнэлэх
- Давж заалдах гомдлыг хүлээн авах, хэргийг шүүхэд хүргүүлэх
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд

3. “Шүүн таслах ажиллагааны удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудал, давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэргийн талаарх судалгаа” зэрэг сэдвүүдийн хүрээнд энэ жилийн сургалтыг зохион байгууллаа.

Цаашид жил бүр уг сургалтыг давж заалдах шатны шүүхээр хянагдаж байгаа хэргүүдийг маргааны төрлөөс шалтгаалан өөр өөр сэдвийн хүрээнд үргэлжлүүлэн тогтмол явуулах бөгөөд энэ сургалтыг явуулснаар захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын алдаа, зөрчлийг багасгаж, шүүн таслах ажиллагааг чанаржуулахад ач холбогдолтой болно гэж үзэж байгаа билээ.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**Гадаадад сургалт, айлчлалаар явсан тухай мэдээлэл**

Тус шүүхийн шүүгч Д.Батбаатар нь 2011 оны 9 дүгээр сарын 09-23-ны өдрүүдэд Монгол Улсын Дээд шүүх болон Тайвань Улсын Дээд шүүхүүдийн хоорондын хэлэлцээрийн дагуу Тайваны “Шүүгчдийн давтан сургалтын төв”-өөс зохион байгуулсан “Тайваны шүүхийн тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, харилцан туршлага солилцох нь” сэдэвт 14 хоногийн сургалтад хамрагдав.

Ерөнхий шүүгч Ц.Цогт нь 2011 оны 9 дүгээр сарын 20-28-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Шүүхийн тухай багц хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүний хувьд БНСУ-д албан томилолтоор явж тус улсын шүүхийн үйл ажиллагаатай танилцаж, Шүүхийн хуулиудын судалгаа хийв.

Канад улсын Нийтийн албаны зөвлөлийн Ерөнхийлөгч хадагтай Maria Barrados-ын урилгаар Монгол Улсын төрийн албаны болон шүүхийн шинэтгэлийн ажлын хүрээнд Ерөнхий шүүгч Ц.Цогт, шүүгч М.Батсуурь нар 2011 оны 11 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд Канад улсын Нийтийн албаны зөвлөлд зочилж, Канад улсад нийтийн албан хаагчийг томилох ажиллагаа, эрх шилжүүлэх ажиллагаа болон түүнтэй холбоотой хянан шалгах, аудитын ажиллагаа зэрэгтэй танилцсан.

Мөн CIDA буюу Канад улсын Олон улсын хөгжлийн агентлагийн Азийг хариуцсан ерөнхий захирал Dean Frank, Монголыг хариуцсан захирал Stephen Potter болон ахлах ажилтан Michael Aylward нартай уулзаж, Монгол улс дахь төрийн албаны шинэчлэл болон уул уурхайн маргааныг шийдвэрлэж буй Канад улсын шүүхийн туршлагыг судлах, цаашид хамтран ажиллах боломжийн талаар санал солилцож, тус улсын Парламентын ордонд зочилж, парламентын үйл ажиллагаатай танилцав.

**Хэрэг автоматаар хуваарилах програм
ашиглах заавар**

1. Мэдээлэл лавлагааны ажилтан жил бүр Шүүгчдийн зөвлөлгөөнөөр “Давж заалдах журмаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүгч /илтгэгч/, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүнийг томилох хуваарь”-ийг шинэчлэн батлах үед 1-7 хүртэлх тооны аль нэгийг давхцахгүйгээр агуулсан 7 сугалааг бэлтгэж /шүүгчдийн зөвлөлгөөнд/ шүүгч тус бүрээр 1 ширхэгийг сонгуулна.

2. Шүүгч бүрийн сугалж авсан тоо нь тухайн жилд тэр шүүгчийн захиргааны хэрэг хүлээн авах “Хувийн дугаар” болох бөгөөд үүнийг Шүүгчдийн зөвлөлгөөний тэмдэглэлд тусгана.

3. Хэрэг автоматаар хуваарилах програмд хэрэглэгчийн эрх, нууц үгээр нэвтрэн орно.

4. Хэрвээ аль нэг шүүгч нь амарсан, өвчтэй, чөлөөтэй гэх мэт шалтгаанаар хэрэг хуваарилах процесст оролцох боломжгүй бол тухайн шүүгчийн хувийн дугаарын урд талын тэмдэглэх хэсэг /CheckVox/-г сонгож хэрэг хуваарилалтанд оролцуулахгүй байж болно. Ингэж шүүгчийг идэвхигүй болгосон үед тухайн шүүгчид нэхэмжлэл хуваарилагдахгүй болно.

5. Програмд 1-7 хүртэл дугаарласан хүснэгтэд нэхэмжлэгчийн нэрийг оруулж, “Хуваарилах” гэсэн товчийг дарна.

6. Програм автоматаар нэхэмжлэгчийн нэр тус бүрд 1-7 хүртэлх тооны аль нэг /шүүгчдийн хувийн дугаар/-ийг автоматаар хуваарилан гаргаж ирэх бөгөөд тэрхүү “Хувийн дугаар” нь таарсан хэргийг “Judge-2005” програмд бүртгэж, тухайн шүүгчид хүлээлгэн өгнө

7. Мэдээлэл лавлагааны ажилтан захиргааны хэрэг хуваарилсан тохиолдол тус бүрт нэн даруй програмаас хуваарийг хэвлэж хадгална.

8. Хэрэв тухайн өдөрт ирсэн хэргийн тоо 7 /тухайн жилд ажиллаж буй нийт шүүгчдийн тоо/ хүрээгүй тохиолдолд ирсэн байгаа хэргүүдийг ирсэн дарааллаар “Хэрэг автоматаар хуваарилах програм”-д оруулж, дутуу хэргийн оронд тэдгээрийн хэрэг бүртгэх дэвтэр дээр бүртгэгдэх дэс дугаарыг /урьдчилан/ оруулж “Хуваарилах” гэсэн товчийг дарж хуваарилна.

9. Энэ зааварт зааснаар програмд хэрэг бүртгэх дэвтэр дээрх дэс дугаарыг нь урьдчилан оруулж хуваарилсан хэргийг хүлээн авмагц дээрх хуваарилалтын дагуу бүртгэж, “Хувийн дугаар” нь таарсан шүүгчид хүлээлгэн өгнө.

10. “Шүүгч, /илтгэгч шүүгч/, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүнийг томилох хуваарь”-д заасны дагуу хэргийг “дахин” хуваарилахдаа энэ зааврын 4 дугаарт зааснаар хуваарилна.

11. Нэхэмжлэлийг нэг л удаа хуваарилах боломжтой бөгөөд дахин хуваарилах боломжгүй мөн хуваарилагдсан хэргийг засварлах боломжгүй байна.

----- о о О о о -----

“Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ба мэтгэлцэх зарчим” мэдээлэл

Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлүүдэд “шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зармын үндсэн дээр явуулах” тухай зохицуулсан.

Ингэхдээ Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх журмыг байцаан шийтгэх хуулиар тогтооно” гэж зааснаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйл (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийг иш татсан) -д захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх журмыг дараахь байдлаар тогтоосон байна.

- Хэрэгжих хүрээ: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжинэ;
- Мэтгэлцээний зүйлийн хязгаар: Хэргийн үйл баримт, хариуцагчийн (сөрөг нэхэмжлэлтэй тохиолдолд нэхэмжлэгчийн) гэм буруугийн талаар;
- Хэрэгжүүлэх арга зам: Талууд шүүх хуралд биеэр оролцох, бичгээр тайлбар гаргах, нотлох баримт гаргах, тэдгээрийг судлахад тэгш эрхтэй оролцоно;
- Оролцогчийн хүрээ: Хэргийн оролцогчид (нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд), тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч;

Мэтгэлцэх зарчим ба Шүүхийн өмнө тэгш байх зарчим Шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимтай шууд уялдаатай, мэтгэлцэх боломжийг хангахгүйгээр “шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчим хэрэгжих үндэс муутай. Учир нь мэтгэлцэх боломжгүй бол тэгш байх боломж хангагдахгүй.

Мэтгэлцэх зарчим ба Шүүхийн шийдвэр

Шүүхийн шийдвэр нь “маргааны үйл баримт, захиргааны актын хууль зүйн үндэслэл, хариуцагчийн гэм буруугийн талаар” талуудын гаргасан тайлбар, хэрэгт цугларсан нотлох баримтад үндэслэгдсэн байх ёстой. Энэ утгаараа талуудын мэтгэлцээнээс шүүхийн шийдвэрийн үр дүн (үндэслэл бүхий байх, бодитой байх) шууд хамааралтай байдаг. Тиймээс мэтгэлцээн ба шүүхийн шийдвэр хоорондоо (шийдвэрийн үндэслэлт байдал, чанар, хүлээн зөвшөөрөгдөх шинж) шууд хамааралтай, нэг нь нөгөөгөө

нөхцөлдүүлэгч гол хүчин зүйл байдаг. Хэрэв мэтгэлцээн хязгаарлагдмал (хуулийн зохицуулалт дутмаг) эсхүл хэрэгжих боломжгүй (зохицуулалттай хэдий ч хэрэгжилт хангалтгүй) бол тэр хэмжээгээр шүүхийн шийдвэрийн чанарт муугаар нөлөөлнө. Мэтгэлцэх зарчим ба Мөрдөн шалгах зарчим Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д зааснаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “мөрдөн шалгах” зарчим нь нотлох баримт цуглуулах, үнэлэх үүргээр л илэрч байгаа (нотлох үүргийн зарчим/burden of proof). Мөрдөн шалгах зарчмыг хэрэгжүүлэгч этгээд нь Шүүх, харин мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэгч этгээд нь Маргаан талууд. Мөрдөн шалгах зарчим нь шийдвэр гаргагчийн үйл ажиллагаанд “маргааны үйл баримтыг олж тогтооход” чиглэсэн идэвхитэй, өөрийн санаачлага бүхий эрх, үүргээр илэрдэг бол харин мэтгэлцэх зарчим нь маргагч талуудын үйл ажиллагаанд (хүсэлт, тайлбар, нотлох баримт гаргах, шүүх хуралдаанд мэдүүлэх зэргээр) биелэлээ олдог.

Мэтгэлцэх зарчим vs. Мөрдөн шалгах зарчим:

Захиргааны хэргийн шүүх манай улсад байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулсан өнгөрсөн 7 жилийн хугацааны туршлагад үндэслэн дүгнэвэл, энэ хоёр зарчмыг нэг ажиллагаанд зэрэг хэрэгжүүлэхэд зөрчилдөх байдал гарсангүй гэж дүгнэж болно. Захиргааны хэргийн шүүх өөрийн санаачлагаар “нотлох баримт цуглуулах, нотлох үүрэг” хүлээсэн байдал нь талуудын мэтгэлцэх үйл ажиллагаанд нөлөөлөхгүй.

Дүгнэлт: Мэтгэлцэх зарчим захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжиж ирсэн, цаашид ч хэрэгжих боломжтой ач холбогдолтой зарчим юм. Харин цаашид шүүн таслах ажиллагаанд энэ зарчмын хэрэгжилтийг хангах арга замыг боловсронгуй болгох нь шүүх “маргааны бодит үйл баримтыг олж тогтоох”, “үндэслэл бүхий шийдвэр гаргах” -ад өргөн утгаараа шүүх хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа байх нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Үүнд:

- Аль нэг тал (ихэвчлэн хуульч) шүүн таслах ажиллагааг санаатайгаар удаашруулах хэрэгслэл болгохоос сэргийлсэн нарийвчилсан зохицуулалт шаардлагатай (үүнд, аль нэг оролцогч шүүх хуралдаанд

ирээгүй гэдэг үндэслэлээр, эсхүл өмгөөлөгч авах үндэслэлээр хурал хойшлуулах)

- Мэтгэлцээний зүйлийн хүрээг зөвхөн “хэргийн үйл баримт, хариуцагчийн гэм буруугийн талаар” гэж хязгаарлалгүй “хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний хувьд” ч мэтгэлцэх боломжтой болгон хуульчлах
- Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчим болон мөрдөн шалгах (нотлох үүрэг) зарчим нэгэн зэрэг хослон хэрэгжих боломжтой.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ
ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 15.3 дахь хэсэг нэмсүгэй:

“15.3. Улсын дээд шүүх давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.2. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн захиргааны хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.”

3 дугаар зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.6 дахь хэсэг, 90 дүгээр зүйлийн 90.1 дэх хэсгийн “Улсын дээд шүүхэд” гэснийг “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд” гэж, 85 дугаар зүйлийн 85.1 дэх хэсэг, 90 дүгээр зүйлийн 90.2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим” гэснийг “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх” гэж, 15 дугаар зүйлийн 15.3, 15.4 дэх хэсгийн дугаарыг “15.4.”, “15.5.” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

40, 50 мянгат-1 Самбуугийн гудамж Улаанбаатар хот 15170

Цаашид “ШЕЗ” гэх

болон

ДЭЛХИЙН БАНКНЫ “ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

Цаашид “ХЗСҮС” гэх нар

Захиргааны хэргийн бүртгэл, мониторингийн програм хангамж /цаашид Захиргааны хэргийн програм/ боловсруулж, нэвтрүүлэх төслийн хүрээнд хамтран ажиллахаар тохиролцов.

Талууд Монгол Улсын Засгийн Газар болон Дэлхийн Банкны хооронд байгуулсан Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл хэрэгжүүлэх Санхүүжилтийн гэрээний Бүрэлдэхүүн хэсэг 3-ын дагуу Захиргааны хэргийн програм хангамж боловсруулж, нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх гэрээг байгуулав.

Нэг. Төслийн зорилго

Захиргааны хэргийн програм хангамж нэвтрүүлсэнээр захиргааны хэргийн шүүхийн нэхэмжлэл хүлээн авахаас эхлэн хийгдэх процессын бүх ажиллагааг хялбар шуурхай болгох, шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажил үүргийн хуваарь, мэдээлэл солилцоог сайжруулах, тайлан мэдээ гаргахад зарцуулдаг цаг хугацаа, дахин давтан хийгддэг хөдөлмөрийг багасгах, ХХША-ны явцад гарч буй техник алдааг багасгах зорилготой юм.

Хоёр. Талууд дараах байдлаар хамтран ажиллана

2.1 Төслийг хэрэгжүүлэх ажиллагааг харилцандэмжих, хамтран хэлэлцэх, тухайлбал системийн програм хангамжийн боловсруулалтыг хянан төлөвлөгөөний дагуу хийх,

2.2 Уулзалт, семинар болон хамтран хэрэгжүүлэх бусад ажиллагааг зохион байгуулах, оролцох;

2.3 Програмын системийн судалгааг бэлтгэж гүйцэтгэгч компанийг шалгаруулж ажиллуулах

2.4 Програм хангамжийн боловсруулалт, хяналт, хүлээн авах туршилт, үнэлгээтэй холбоотой техникийн өгөгдөл, мэдээллийг солилцох;

2.5 Талуудын тохиролцсон хамтын ажиллагааны бусад хэлбэрүүд.

Гурав. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн үүрэг

3.1 Шүүхийн Ерөнхий зөвлөл нь Захиргааны хэргийн програмд тавигдах хэрэглэгчийн шаардлага /бизнес процесс, системд хийгдэх ажиллагаа, харагдах байдал, хэлбэр, загвар, ажиллагаа г.м./-ыг боловсруулах ажлын хэсэг томилон ажиллуулах.

3.2. ХЗСҮС Төслийн нэгжтэй хамтран энэ төслийн гүйцэтгэл, үр дүнгийн хэрэгжилтийг хянаж, боловсруулагч байгууллага (тендерт ялсан байгууллага)-ыг бодлогын болон менежментийн зөвөлгөөгөөр тухай бүр хангаж байна.

3.3. Програм хангамжийн системийн баримт бичгүүд, тухайлбал системийн шинжилгээний баримт бичгүүд, зохиомж, эх кодыг өөрийн өмчлөлд хүлээн авах, програм хангамжийг улсын хэмжээнд нэвтрүүлэхэд шаардлагатай бүх нөхцлийг бүрдүүлэх.

3.4. Хүлээлгэн өгч буй програм хангамжийг ШЕЗ-ийн серверт суулгах, турших, ажиллуулах нөхцлөөр ханган, дэмжиж ажиллах

3.5. Ажлын хэсгийн гишүүдийн ажлын ачааллыг харгалзан үзэж зохион байгуулалтын арга хэмжээ авах

Дөрөв. ХЗСҮСТ-ийн үүрэг

4.1 Захиргааны хэргийн шүүхийн програм хангамжийн баримт бичиг, системийн судалгаа, зохиомж дээр тулгуурлан Захиргааны хэргийн програм хангамжийг боловсруулах, суурилуулах ажиллагааг санхүүжүүлэх.

4.2 Захиргааны хэргийн програм хангамжийг боловсруулах үйл явц, төлөв, програмын туршилттай холбоотой асуудлаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн байгуулсан ажлын хэсэгтэй байнга хамтран ажиллах

4.3 Онлайн програмын суурь дэд бүтэц болох сүлжээний хувьд “Хуулийн Салбарын Холбооны Сүлжээ” төслийг хэрэгжүүлэх замаар Шүүхүүдийн хооронд аюулгүй холболтын боломжийг бий болгох.

4.4 Програм ажиллуулах серверийг ШЕЗ-д худалдан авч өгөх

4.4 Захиргааны хэргийн програм хангамжийг ШЕЗ-ийн серверт суулгах, турших, ажиллуулах үйл явцыг хамтран зохион байгуулах, санхүүжүүлэх.

4.6 Програм хангамж нэвтрүүлж эхлэхэд сургалт зохион байгуулах, санхүүжүүлэх

Тав. Нууцыг задруулахгүй байх

Талууд энэхүү гэрээний хүрээний хамтын ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг арилжааны болон бусад зорилгоор бусдад задруулахгүй байх.

Зургаа. Гэрээний үүргээс татгалзах ба гэрээг дуусгавар болгох

6.1 Дараахь тохиолдолд ХЗСҮСТ нь гэрээний үүргээс татгалзаж болно.

6.2 ШЕЗ нь энэхүү гэрээ эсхүл энэ гэрээтэй холбоотой байгуулсан бусад тохиролцоогоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл энэхүү гэрээний 1 дүгээр хэсэгт заасан төслийн зорилгод хүрэх боломжгүй болгосон эсхүл ноцтой саад учруулахуйц нөхцөл байдал үүссэн бол.

6.3 6.2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд ХЗСҮСТ ба ШЕЗ-ийн хэрэгжүүлэхээр тохиролцсон төслийн нийт хугацааны турш үргэлжилсэн эсхүл энэ хугацааны дотор арилгаагүй тохиолдолд ХЗСҮСТ нь Дэлхийн банкны зөвшөөрөлтэйгөөр гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

Долоо. Үргэлжлэх хугацаа

Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба Захиргааны хэргийн програм хангамжийг ШЕЗ туршилт хийгдэж бүрэн хүлээн авах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

Найм. Гэрээг нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх

Энэхүү гэрээний 1 дэх хэсэгт заасан зорилгод хүрэхэд гэрээний аль нэг заалт саад учруулах тохиолдолд ШЕЗ ба ХЗСҮСТ харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр гэрээг хэдийд ч нөхцөл байдалд нийцүүлэн өөрчилж болно. Гэрээний өөрчлөлтийг бичгээр хийнэ.

Ёс. Гэрээ хүчин төгөлдөр болох ба үйлдэх хувь

Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдөр хүчин төгөлдөр болно. Гэрээг хоёр хувь монгол хэл дээр үйлдэнэ.

Улаанбаатар хот, 2012 он 1 дүгээр сарын 24-ний өдөр

Монгол улсын Шүүхийн Ерөнхий
зөвлөлийн Гүйцэтгэх нарийн
бичгийн дарга

Н.ГАНБАЯР

Дэлхийн банкны Хууль зүйн
салбарын үйлчилгээг
зохицуулагч

Б.САРАНТУЯА

Хэргийг илтгэн танилцуулах дараалал

..... хэргийн тухай

<p>Нэхэмжлэлийн шаардлага</p> <ul style="list-style-type: none"> ✓ Нэхэмжлэл хүлээн авсан, он... сар... өдөр шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага ✓ Маргаан бүхий актууд ✓ Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл ✓ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд өөрчилсөн, нэмэгдүүлсэн, байдал ✓ Маргаан бүхий актыг зөвшөөрөхгүй байгаа үндэслэл, хуулийн зүйл заалт, агуулга 	
<p>Хариуцагчийн тайлбар</p> <ul style="list-style-type: none"> ✓ Нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн үзэж байгаа, хариу тайлбарын үндэслэл ✓ Ямар хуулийн зүйл заалтыг үндэслэж байгаа, үндэслэл шалтгаан 	
<p>Гуравдагч этгээдийн тайлбар</p> <ul style="list-style-type: none"> ✓ Нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн үзэж байгаа, хариу тайлбарын үндэслэл ✓ Ямар хуулийн зүйл заалтыг үндэслэж байгаа, үндэслэл шалтгаан 	
<p>Шийдвэрийн агуулга</p> <ul style="list-style-type: none"> ✓ Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн хуулийн заалтыг танилцуулна, ✓ Нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэсэн талаар 	
<p>Анхан шатны шүүхийн дүгнэлт</p> <ul style="list-style-type: none"> ✓ Нэхэмжлэлийн шаардлагад дүгнэлт хийсэн байдал үндэслэл ✓ Хуулийн зүйл заалт /Шүүхийн шийдвэрийн дүгнэлт үндэслэл зэргийг тус бүрээр нь тодорхойлон тайлбарлах/ 	

<p>Давж заалдах гомдлын үндэслэл</p> <ul style="list-style-type: none"> ✓ Гомдлыг үндэслэл тус бүрээр нь товч илтгэх. Үүнд: <ul style="list-style-type: none"> - хэргийн оролцогчдын шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг хангаагүй - хууль зөрчсөн нь шийдвэр гаргахад нөлөөлөхөөр байвал - шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн, эсхүл шаардлага хангаагүй нотлох баримтыг шийдвэрийнхээ үндэслэл болгосон - шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн - шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч гарын үсэг зураагүй, шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан ✓ Гомдлын хариу тайлбар ✓ Гомдолд хариу тайлбарын үндэслэлийг тайлбарлах 	
<p>Хэрэгт авагдсан нотлох баримтын талаар танилцуулах</p> <ul style="list-style-type: none"> ✓ Гомдолд заагдсан (няцаасан, эсхүл нотолсон) нотлох баримтыг хэлбэрийн шаардлагын тухайд маргааны агуулгатай холбогдуулан танилцуулах 	

Дотоод хэрэгцээнд

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТЭЙ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙГ ДАВЖ ЗААЛДАХ ЖУРМААР ХЯНАХ АЖИЛБАРУУДЫН ЖАГСААЛТ (check list)

Магадлалын дугаар он сар ... өдөр ...		
д/д	Хийгдэх ажиллагаа	Шалгасан байдал
1	Нэхэмжлэлийг гаргасан хугацаа, төлөөлөгч гаргасан бол итгэмжлэл авагдсан эсэх, тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлэх бол уг эрхийг итгэмжлэлд тусгайлан заасан эсэх	

2	Давж заалдах гомдлыг хуулийн хугацаанд гаргасан болон ирүүлсэн эсэх, гомдлыг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлд уг эрхийг тусгайлан зааж өгсөн эсэх	
3	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэх	
4	Нэхэмжлэгчийн анхны гаргасан нэхэмжлэлийн шаардлагаар хэрэг үүсгэж хэрхэн шийдвэрлэсэн, нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн шийдвэрлэсэн, нэхэмжлэлийн шаардлагаас давж шийдвэрлэсэн эсэх, итгэмжлэгдсэн төлөөлөгч нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлсэн, өөрчилсөн бол уг эрхийг итгэмжлэлд тусгайлан зааж өгсөн эсэх	
5	Иргэн, хуулийн этгээдийг гуравдагч этгээдээр татсан эсэх, бие даасан шаардлага гаргасан эсэх	
6	Хэргийн оролцогчдод эрх үүргийг нь танилцуулж, эдлүүлсэн байдал, хугацаа	
7	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын удирдлага болгон, баримталсан хуулийн заалтууд үндэслэлтэй эсэх	
8	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүх хуралдааны явцад хэргийн оролцогчид хүсэлт гаргасан эсэх, түүнийг шийдвэрлэсэн байдал	
9	ЗХХШТХ –ийн 34.1 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа эсэх.	
10	Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны товыг хуульд заасан хугацаанаас өмнө мэдэгдсэн эсэх, хэргийн оролцогчдыг шүүх хуралдаанд оролцох эрхийг хангасан эсэх.	
11	Шүүх бүрэлдэхүүн хуулийн дагуу томилогдсон эсэх, өөрчлөгдсөн бол Шүүгчдийн зөвлөлгөөний тогтоол (үндэслэл) байгаа эсэх.	
12	Хуралдааны тэмдэглэл хөтлөлтийг хуулийн дагуу хөтөлсөн эсэх	

13	Шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн, эх хувь, хуулбар бол нотариатаар гэрчлүүлсэн эсхүл архивын хуулбар үнэн тэмдэг дарагдсан эсэх, бичмэл нотлох баримт уншигдаж, судлагдахуйц байх шаардлага хангасан эсэх, хуулийн шаардлага хангаагүй нотлох баримтыг захиргааны хэргийн шийдвэрийн үндэслэл болгосон, /ЗХХШТХ 88.3.4/	
14	Хууль хэрэглээний байдал /ЗХХШТХ 88.3.5/	
15	Хэргийг эмхэтгэж, товъёогчлож, үдсэн байдал	
16	Нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болгосон хуулийн заалтууд.	
17	Хариуцагчаас хариу тайлбарын үндэслэл болгосон хуулийн заалтууд	
18	Гуравдагч этгээдээс үндэслэл болгосон хуулийн заалтууд.	
19	Бусад	

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ



